# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

## (ХУУЛЬ, ТОГТООЛ, ЗАРЛИГ, НИЙТЛЭЛ)

*Монгол Улсын Их Хурлын Тамгын газар*

1993 оны 4—5-р сар №3 (12)

### ГАРЧИГ

### I. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Зарим хууль, хуулийн заалт, зарлигийг хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын хууль 279
Хуулийг дагаж мөрдөх хугацааг хойшлуулах тухай Монгол Улсын хууль 280
Монгол Улсын малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль 281
Хуулийн зарим зүйлийг хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын хууль 296
Гэрээ соёрхон батлах тухай Монгол Улсын хууль 297
Монгол Улсын прокурорын байгууллагын тухай хууль 298
Монгол Улсын засгийн газрын тухай хууль 314
Хууль хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын хууль 340
[illegible] ажлын татварын тухай Монгол Улсын хууль 341
Хууль хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын хууль 343
Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хууль 344
Гэрээ соёрхон батлах тухай Монгол Улсын хууль 345
Хууль хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын хууль 346
Олон улсын конвенц соёрхон батлах тухай Монгол Улсын хууль 347
Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль 348
Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай Монгол Улсын хууль 357

17. Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хууль 359
18. Шүүх байгуулах тухай Монгол Улсын хууль 360
19. Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хуулиар зөвшөөрөх тухай Монгол Улсын хууль 365

## 2. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

20. Монгол Улсын прокурорын байгууллагын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай № 16 366
21. Ажлаа түдгэлзэх, ажлаас чөлөөлөх тухай № 29 367
22. Монгол Улсын малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай № 30 368
23. Орон нутгаас гаргасан санал, хүсэлтийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай № 31 369
24. Монгол Улсын прокурорын байгууллагын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай тогтоолд өөрчлөлт оруулах" тухай № 32 371
25. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүдийн тухай № 33 372
26. Монгол банкны дүрэм батлах тухай № 34 373
27. Монголбанкны дүрэм (34-р тогтоолын хавсралт) 374
28. Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай № 36 382
29. Зарим хүнийг ажлаас чөлөөлөх, ажилд томилох тухай № 37 383
30. «500 төгрөгийн дэвсгэртийг хууль ёсны төлбөрийн хэрэгсэлд тооцох гүйлгээнд гаргахыг зөвшөөрөх тухай № 38 384
31. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай Монгол Улсын хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай № 39 385
32. Журам батлах тухай № 40 386
33. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх Ёслолын журам (40-р тогтоолын хавсралт) 387
34. Алт худалдах, гадаад валютын орлогыг хадгалуулахыг зөвшөөрөх тухай № 41 390
35. Цалинг нэмэхийг зөвшөөрөх тухай № 42 391
36. НҮБ-ын Бага хурлаас баталсан зөвлөмжийг дэмжих тухай № 43 392
37. Монгол Улсын Ерөнхийлөгч тангараг өргөх өдөр, цагийг товлох тухай № 44 393
38. Шүүгчийн орон тоо батлах тухай № 45 394
39. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай № 46 398
40. Монгол Улсын Зохиогчийн эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай № 47 399
41. Сум байгуулах тухай № 48 400
42. Монгол Улсын Патентийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай № 49 404
43. М. Энхсайханыг Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай № 50 405

44. Цэргийн дэг журам хангах ажлыг зохицуулан зохион байгуулах түр комисс байгуулах тухай № 51 — 406
45. Зарим хүнийг үүрэгт ажлаас чөлөөлөх тухай № 52 — 407
46. Улсын Их Хурлын гишүүн А. Ганбаатарын бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай № 53 — 408
47. «50 төгрөг», «100 төгрөг»-ийн [illegible] хэрэгсэл гаргах, гүйлгээнд гаргахыг зөвшөөрөх тухай № 54 — 409
48. Үндсэн хуулийн цэцийн гишүүдийн тухай № 55 — 410
49. Г. Ганболдыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх тухай № 56 — 411
50. Улсын төвлөрсөн төсвийн 1992 оны гүйцэтгэлийн тайлан батлах тухай № 57 — 412
51. Монгол Улсын 1993 оны улсын төсвийн тухай тодотгол хийх тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай № 58 — 413


## 3. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ


52. Зарим хүнд Монгол Улсын Гавьяат жүжигчин цол олгох тухай № 59 — 414
53. Г. Долгорсүрэнд Монгол Улсын Ардын жүжигчин цол олгох тухай № 60 — 415
54. Зарим хүнд Монгол Улсын Гавьяат багш цол олгох тухай № 61 — 415
55. Зарим багш, сурган хүмүүжүүлэгчийг одон, медалиар шагнах тухай № 62 — 416
56. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай № 63 — 420
57. Б. Доржид, Д. Ганбаатар нарыг «ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГ»-ийн одонгоор нэхэн шагнах тухай № 64 — 421
58. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай № 65 — 421
59. А. Батсүхийг Алтан гадас одонгоор шагнах тухай № 66 — 423
60. С. Гэнгоо, Д. Энхтайван нарыг «ШУДАРГА ЖУРАМ» медалиар шагнах тухай № 67 — 423
61. Ч. Бачбаатыг «ШУДАРГА ЖУРАМ» медалиар шагнах тухай № 68 — 424
62. Зарим хүнийг Найрамдал медалиар шагнах тухай № 69 — 425
63. Зарим хүнийг албан тушаалаас нь чөлөөлөх тухай № 70 — 425
64. Зарлигт нэмэлт оруулах тухай № 73 — 426
65. Ю. Жаргалд хошууч генерал цол олгох тухай № 75 — 427
66. Улсын мөрдөн байцаах байгууллагыг бэхжүүлэх талаар чиглэл өгөх тухай № 76 — 427
67. А. А. Белкин, Л. И. Жуковская нарыг одонгоор шагнах тухай № 77 — 428
68. Т. В. Степановаг «АЛТАН ГАДАС» одонгоор шагнах тухай № 78 — 429
69. Г. Эрх-Амгаланг «ШУДАРГА ЖУРАМ» медалиар шагнах тухай № 79 — 429

## 4. ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

70. Үндсэн хуулийн цэцийн тогтоол № 03 430

## 5. НИЙТЛЭЛ, ТЭМДЭГЛЭЛ

71. Улсын Их Хурлын Хүн ам зүй, эрүүл мэнд, хөдөлмөр нийгмийн хангамжийн байнгын хороо юу эрхэлдэг вэ? 434
72. Хүн ам зүй, эрүүл мэнд, хөдөлмөр нийгмийн хангамжийн байнгын хорооны үндсэн гишүүдийн намтар 436
73. Иргэдийн санал, хүсэлт 440

---

Сэтгүүлийн зөвлөл:
Ерөнхий эрхлэгч Н. Ринчиндорж
Нарийн бичгийн дарга Сан. Жаргалсайхан
Т. Баасандэгүрэн
Ч. Бакут

Техник редактор Н. Оюунцэцэг
Хянагч С. Нэргүй

Зах № 09
Үйлдвэрт шилжүүлсэн 1993 оны 7 сарын 22-нд. Өрөлтөнд 1993 оны 8 сарын 2-нд. Хэвлэлтэд 1993 оны 11-р сарын 20-нд. Цаасны хэмжээ 60х98/16. Хэвлэлийн хуудас 10,5. Хэвлэлтийн тоо 1500 ширхэг

Засгийн газрын хэвлэх үйлдвэр

МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ

1993 оны 2 дугаар сарын 4-ний өдөр — Улаанбаатар хот

# ЗАРИМ ХУУЛЬ, ХУУЛИЙН ЗААЛТ, ЗАРЛИГИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хууль батлагдсантай холбогдуулан дор дурдсан хууль, хуулийн заалт, зарлигийг 1993 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

1) «БНМАУ-ын Прокурорын хяналтын хууль батлах тухай» 1976 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хууль;

2) «БНМАУ-ын хууль тогтоомжийн зарим актад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигуудыг батлах тухай» 1988 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн хуулийн «БНМАУ-ын Прокурорын хяналтын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1988 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 20 дугаар зарлиг» гэсэн хэсэг;

3) «БНМАУ-ын зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигуудыг батлах тухай» 1989 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуулийн «Зарим хуульд өөрчлөлт оруулах тухай БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1989 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 120 дугаар зарлиг» гэсэн хэсэг;

4) «БНМАУ-ын Прокурорын хяналтын хууль батлах тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1976 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 253 дугаар зарлиг.

5) «БНМАУ-ын Прокурорын хяналтын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1988 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 20 дугаар зарлиг;

6) «Зарим хуульд өөрчлөлт оруулах тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1989 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 120 дугаар зарлиг.

| | |
|---|---|
| Монгол Улсын Их Хурлын дарга | Н. БАГАБАНДИ |
| Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга | Н. РИНЧИНДОРЖ |

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

| | |
|---|---|
| 1993 оны 3 дугаар сарын 30-ны өдөр | Улаанбаатар хот |

## ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦААГ ХОЙШЛУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуульд тавьсан хоригийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг Улсын Их Хурал хүлээж авсантай холбогдуулан «Зарим хууль, хуулийн заалт, зарлигийг хүчингүй болсонд тооцох тухай» 1993 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн Монгол Улсын хуулийг Монгол Улсын Прокурорын тухай хууль хүчин төгөлдөр болтол мөрдөхгүй байхаар тогтоосугай.

| | |
|---|---|
| Монгол Улсын Их Хурлын дэд дарга | Ж. ГОМБОЖАВ |
| Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга | Н. РИНЧИНДОРЖ |

# МОНГОЛ УЛСЫН МАЛЫН УДМЫН САН, ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### *Нийтлэг үндэслэл*

*1 дүгээр зүйл.* Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь малын удмын сан, мал, түүнчлэн аж ахуйн зориулалтаар үржүүлдэг тэжээвэр амьтны (цаашид «мал, амьтан» гэх) эрүүл мэндийг хамгаалах, чанар ашиглаг, үржлийн ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх талаар Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн, тус улсын нутаг дэвсгэрт байгаа аж ахуйн нэгж, байгууллага (цаашид «иргэн, аж ахуйн нэгж, байгууллага» гэх) хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

*2 дугаар зүйл.* Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах хууль тогтоомж

Монгол Улсын малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

*3 дугаар зүйл.* Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах ажилд төрөөс баримтлах зарчим

1. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах ажилд төрийн болон мэргэжлийн удирдлагыг уялдуулна.

2. Мал, амьтныг өсгөн үржүүлэх, эрүүлжүүлэх уламжлалт арга ажиллагааг орчин үеийн шинжлэх ухааны ололттой хослуулна.

3. Байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул, халдварт өвчнөөс мал, амьтныг өмчийн төрөл, хэлбэрийг үл ялгаварлан хамгаална.

4. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаа явуулахад өмчлөгчийн эрхийг хууль бусаар үл хөндөнө.

5. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалахад олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс гаргасан санал, санаачилгыг дэмжинэ.

*4 дүгээр зүйл.* Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах

1. Малын удмын санг хамгаалах ажил нь тухайн үүлдэр,

омог, хэвшлийн малыг цэврээр үржүүлж, үржил ашиг шимт чанарыг нь удамшуулах, хадгалах, улмаар сайжруулахад чиглэгдэнэ.

2. Малын удмын санг хамгаалах зорилгоор нийт мал сүргээс удмын сангийн сүрэг, торгон сүрэг, цөм сүрэг, гойд ашиг шимт малыг тогтоосон жишигт нийцүүлэн шинж мал үржлийн алба сонгон шалгаруулах үндсэн дээр дараахь байдлаар бүрдүүлнэ:

1) удмын сангийн сүргийг нийт мал сүргээс үржлийн зориулалтаар шилэгдсэн хээлтэгч, хээлтүүлэгч, тэдгээрийг нөхөн сэлбэх өсвөр малаар;

2) торгон сүргийг нийт мал сүрэгт сайжруулагч болгон ашиглах зорилгоор удмын сангийн сүргээс үржил, ашиг шимт чанараар нь сонгон шалгаруулж авсан үржлийн мал, тэдгээрийг нөхөн сэлбэх өсвөр малаар;

3) цөм сүргийг торгон сүргийн дотроос шалгаруулсан сайжруулагч шилмэл малаар;

4) гойд ашиг шимт малыг тухайн үүлдэр, омог, хэвшлийн малаас үржил, ашиг шимийн онцгой давуу чанараар нь үржилд ашиглахаар шалгаруулж, баталгаажуулна.

Гойд ашиг шимт мал, түүний үр, үр хөврөлийг зохих журмын дагуу олон улсын генийн банкинд хадгалуулахаас бусад тохиолдолд гадаадад гаргахыг хориглоно.

3. Малын эрүүл мэндийг хамгаалах ажил нь мал, амьтныг өвчин, эмгэг, үүний дотор халдварт, гоц халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх болон мал эмнэлгийн ариун цэвэр, хорио цээрийн талаар тогтоосон журмыг сахин биелүүлэхэд чиглэгдэнэ.

4. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах ажлыг мал эмнэлэг, үржлийн албаны хяналтын дор мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, үйлчилгээ явуулах замаар хэрэгжүүлнэ.

*5 дугаар зүйл.* Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах ажлыг төрөөс удирдах, зохицуулах

1. Монгол Улсын Үндсэн хуулийн тавдугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу мал сүрэг төрийн хамгаалалтад байна.

2. Улсын Их Хурал малын удмын сан эрүүл мэндийг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах төрийн бодлогын үндсийг тодорхойлох;

2) мал эмнэлэг, ариун цэврийн талаар бүх нийтээр дагаж биелүүлэх, хорио цээр тогтоох, мал, амьтныг даатгах зэрэг үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох.

3. Засгийн газар малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах төрийн бодлого, хууль тогтоомжийг биелүүлэх цогцолбор арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх, санхүүжүүлэх;

2) торгон сүрэг бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад төрөөс үзүүлэх хөнгөлөлт, урамшууллыг эрх хэмжээнийхээ дотор тогтоох;

3) цөм сүргийг байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул, өвчин, эмгэгээс сэргийлэн хамгаалах, эрүүлжүүлэх, ашиг шим, удамшлын чадавхийг нь сайжруулахад дэмжлэг туслалцаа үзүүлэх;

4) мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэхэд шаардлагатай эм, бэлдмэлийн нөөц бий болгож, зарцуулах журмыг тогтоох;

5) мал, амьтан, тэдгээрээс хүнд халдварлах өвчний үүсгэгчээр үйлдвэрлэл, туршилт явуулдаг байгууллагад хаалттай бүс тогтоох;

6) үржлийн ажлын чанар, түвшинг хянах, малын генийн банк, бүртгэл мэдээллийн сан бий болгож ажиллуулах.

4. Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (цаашид «төв байгууллага» гэх) малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1) малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулж хангах;

2) мал эмнэлэг, үржлийн албыг зохион байгуулах, мэргэжлийн нэгдсэн удирдлагаар хангах;

3) мал эмнэлэг, үржлийн төлбөртэй ажил, үйлчилгээний чиглэл, нэр төрлийг тогтоох;

4) иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээнд мэргэжлийн аргачилсан туслалцаа үзүүлж чиглүүлэх;

5) мал эмнэлэг, мал аж ахуйн эрдэм шинжилгээний байгууллагын үйл ажиллагааг шинжлэх ухааныг удирдах байгууллагатай хамтран чиглүүлэх;

6) мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээ явуулах технологийн зааврыг баталж мөрдүүлэх;

7) шинэ үүлдэр, үүлдрийн болон үржлийн хэсэг, омог, хэвшлийн мал, түүнчлэн мал, амьтны шинэ эм, биолдмол, өвчин үүсгэгчийн омог зохион бүтээсэн тухай асуудлыг хянан үзэж баталгаажуулах;

8) патент авсан шинэ үүлдэр, үүлдрийн болон үржлийн хэсэг, омог, хэвшлийн мал, түүнчлэн мал, амьтны эм, биолдмол, өвчин үүсгэгчийн омгийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх зөвшөөрөл олгох;

9) цөм сүргийг хяналтад авах;

10) мал, амьтныг өвчнөөс сэргийлэх, эмчлэх, цөм, торгон сүрэгт явуулах үржлийн ажлын талаар жил бүр авах арга хэмжээг боловсруулж зохион байгуулах.

5. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах талаар дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

1) төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг хангах үндсэн дээр нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх;

2) улсын мал эмнэлэг, үржлийн албыг зохион байгуулах, санхүүжүүлэх;

3) иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас эрхлэх мал эмнэлэг, үржлийн ажилд дэмжлэг туслалцаа үзүүлэх;

4) иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын сайн дурын үндсэн дээр баг, сумын хэмжээнд хүн, ухныг нийлүүлгийн бус үед эх сүргээс тусгаарлан сургаж тохиромжтой нутаг бэлчээрт маллуулах, цаг тухайд нь хээлтүүлэгт оруулах;

5) сум, багт торгон сүргийг бүрдүүлж үржлийн малын бүртгэлд бүртгэж хамгаалалтад авах;

6) төрийн өмчид байх цөм сүргийг хяналтад байлгах;

7) гойд ашиг шимт малын даатгалын хураамж, цөм сүрэгт явуулах мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээний төлбөрийг сум, дүүргийн төсөвт тусгах, санхүүжүүлэх;

8) өвчтэй мал, амьтныг цэдалсан, устгаснаас учирсан хохирлын асуудлыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх;

9) байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул, халдварт өвчин зэрэг мал сүрэгт хор хөнөөл учруулах нөхцөл бий болсон үед түүнээс сэргийлэх, гарсан үр дагаврыг арилгахад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүчийг зохих журмын дагуу дайчлах.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### *Мал эмнэлэг, үржлийн алба*

*6 дугаар зүйл.* Улсын мал эмнэлэг, үржлийн албаны тогтолцоо

1. Улсын мал эмнэлэг, үржлийн алба нь төв, орон нутгийн болон тусгай албадаас бүрдэнэ.

2. Улсын мал эмнэлэг, үржлийн төв алба нь төв байгууллагын бүтцэд байна.

3. Орон нутгийн алба нь аймаг, нийслэл, сумын албанаас бүрдэнэ. Орон нутгийн албыг хууль тогтоомж, төв байгууллагын бодлого чиглэлийн дагуу тухайн шатны Засаг дарга зохион байгуулна.

4. Аймаг, нийслэлийн мал эмнэлэг, үржлийн албаны удирдлагыг төв байгууллагатай зөвшилцөн тухайн шатны Засаг дарга; сумын мал эмнэлэг, үржлийн албаны удирдлагыг аймаг, нийслэлийн албаны удирдлагатай зөвшилцөн тухайн шатны Засаг дарга тус тус томилж, чөлөөлнө.

5. Хилийн боомт зэрэг шаардлагатай газар мал эмнэлгийн тусгай албыг Засгийн газар байгуулна. Энэхүү тусгай алба нь төв байгууллагад шууд харьяалагдана.

*7 дугаар зүйл.* Мал эмнэлэг, үржлийн албаны эрх, үүрэг

1. Мал эмнэлэг, үржлийн бүх шатны алба үйлчлэх нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд дараах нийтлэг эрх, үүрэгтэй байна:

1) мал, амьтныг өвчнөөс сэргийлэх, эмчлэх, шинжлэх, ариутгах, халдваргүйжүүлэх болон үржлийн ажлын талаар жил бүр явуулах арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх;

2) мал, амьтны халдварт өвчин гарсан болон гарч болзошгүй нутаг дэвсгэрийн тухай нийтэд зарлан мэдээлэх;

3) өвчтэй мал, амьтныг хяналтад авч тусгаарлах, эмчлэх, шаардлагатай бол зохих журмын дагуу нядлуулах, устгуулах, түүнээс учирсан хохирлын асуудлыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх;

4) эрүүл мэндийн байгууллагатай хамтран мал, амьтнаас хүнд халдварладаг өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

5) мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээг хувиараа эрхлэх мал үр, үр хөврөл, мал эмнэлгийн зориулалттай эм, бэлдмэл,

малын тэжээл үйлдвэрлэх зөвшөөрлийг зохих шаардлага хангасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгож, тэдгээрийн ажил, үйлчилгээнд мэргэжлийн туслалцаа үзүүлэх;

6) шинэ мал сүрэг, үүлдэр хийж сүргийн бүтцийг зөв тогтоох, цөм, торгон сүрэг, гойд ашиг шимт мал сонгон үржүүлэхэд нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжлийн арга зүйн туслалцаа үзүүлэх;

7) цөм, торгон сүрэг, гойд ашиг шимт малыг үржлийн малын бүртгэлд авч гэрчилгээ олгон баталгаажуулах;

8) мал, амьтны ашиг шимийн гарц, чанарыг нэмэгдүүлэх, сайжруулах талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

9) гойд ашиг шимт малын үр, үр хөврөлийг малын генийн банкинд хадгалж ашиглах;

10) мал эмнэлгийн ариун цэвэр, эрүүл ахуй болон мал үржлийн ажлын холбогдолтой норм, нормативыг боловсруулж батлуулах, биелэлтийг зохион байгуулах;

11) мал, амьтны үзэсгэлэн гаргах, үнэ хаялцуулан худалдах, арилжих зарим арга хэмжээг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын санаачилгыг үндэслэн зохион байгуулах;

12) иргэдэд мал эмнэлэг, үржлийн ажлын талаар шаардлагатай мэдэгдэхүүн олгох сургалт зохион явуулах.

2. Улсын мал эмнэлэг, үржлийн төв алба нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасанаас гадна дараах эрх, үүрэгтэй байна:

1) мал эмнэлэг, үржлийн орон нутгийн болон тусгай албыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

2) мал эмнэлэг, үржлийн албаны боловсон хүчин бэлтгэх, тэднийг мэргэшүүлэх, давтан сургах ажлыг зохион байгуулах;

3) төв байгууллагын эрх олгосноор мал эмнэлэг, үржлийн ажил, мал эмнэлгийн ариун цэвэр, хорио цээрийн талаар гадаад орны болон олон улсын байгууллагатай гэрээ, хэлцэл хийх;

4) шинээр зохион бүтээсэн болон гадаадаас авсан мал, амьтны эм, бэлдмэл, үр, үр хөврөлийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, гадаадаас сайжруулагч мал, амьтан авах, үржлийн мал, амьтныг гадаадад гаргах зөвшөөрөл олгох.

*8 дугаар зүйл.* Мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээ эрхлэх

1. Мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээг зөвхөн малын эмч, мал зүйчийн мэргэжилтэй иргэн явуулна.

2. Улсын мал эмнэлэг, үржлийн албаны малын эмч, мал зүйчийн эрх, үүргийг төв байгууллагаас хууль тогтоомжид нийцүүлэн тодорхойлно.

3. Иргэд мал эмнэлэг, үржлийн чөлөөт үйлчилгээг хууль тогтоомжийн дагуу хувиараа эрхэлж болно.

4. Мал, амьтан бүхий аж ахуйн нэгж, байгууллага өөрийн мал эмнэлэг, үржлийн албатай байж болно.

5. Энэ зүйлийн 3, 4 дэх хэсэгт заасан мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг ажил, үйлчилгээний төрөл, мэргэжлийн түвшин, шаардлагыг харгалзан улсын мал эмнэлэг, үржлийн албанаас олгоно.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### *Мал эмнэлэг, мал үржлийн ажилд тавих улсын хяналт*

*9 дүгээр зүйл. Улсын хяналт, түүний зохион байгуулалт*

1. Мал эмнэлэг, мал үржлийн ажилд тавих улсын хяналт нь мал, амьтныг болон малаас хүнд, хүнээс малд халдах өвчнөөс урьдчилан сэргийлэх, эдгээр өвчинтэй тэмцэх, малын удмын санг хамгаалах, үржлийн ажлыг зохион байгуулах талаар гарсан хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан эрх бүхий байгууллагын шийдвэрийн биелэлтийг хянан шалгаж, илэрсэн зөрчлийг таслан зогсоох, арилгахад чиглэгдэнэ.

2. Мал эмнэлэг, мал үржлийн ажилд тавих улсын хяналтыг мал эмнэлэг, үржлийн төв, орон нутгийн болон тусгай албадын бүтэц, бүрэлдэхүүнд ажиллах малын эмч, мал зүйч нар хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлнэ.

3. Мал эмнэлэг, мал үржлийн ажилд тавих хяналтыг улсын хэмжээнд Улсын ерөнхий байцаагч, улсын байцаагчид; аймаг, нийслэлд улсын ахлах байцаагч, улсын байцаагчид; суманд болон хилийн боомт зэрэг газарт улсын байцаагчид тус тус хэрэгжүүлнэ.

4. Бүх шатны улсын байцаагчийг малын эмч, мал зүйчдээс мэргэшлийн түвшин, ажлын туршлагаар шалгаруулж дараахь байдлаар томилж, чөлөөлнө:

1) Улсын ерөнхий байцаагчийг төв байгууллага;

2) аймаг, нийслэлийн улсын ахлах байцаагчийг аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцөн Улсын ерөнхий байцаагч;

3) аймаг, нийслэлийн улсын байцаагчийг улсын ахлах байцаагч;

4) сумын улсын байцаагчийг сумын Засаг даргатай зөвшилцөж аймаг, нийслэлийн улсын ахлах байцаагч;

5) энэ хэсгийн 3, 4-т заснаас бусад улсын байцаагчийг улсын ерөнхий байцаагч тус тус томилж, чөлөөлнө.

*10 дугаар зүйл.* Улсын хяналтын албаны бүрэн эрх

1. Мал эмнэлгийн албаны улсын байцаагч дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) өвчнөөр тайван бус нутгийн мал, амьтан, тэдгээрийн байр, хашаа хороо, ус, бэлчээр, өвс тэжээл болон мал, амьтны гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүн бэлтгэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, худалдах явцад мал эмнэлгийн ариун цэвэр, эрүүл ахуйн үзлэг, шинжилгээ хийлгэсэн эсэхэд шалгалт хийх;

2) хүний эрүүл мэндэд хор учруулах, мал, амьтны өвчин тарах нь тогтоогдсон мал, амьтны гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүнийг нийтийн хэрэгцээнд нийлүүлэх, эдгээр зүйлээр үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахыг таслан зогсоох, улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, шаардлагатай үед хураалж устгуулах буюу халдваргүйжүүлэх арга хэмжээ авах;

3) мал эмнэлгийн ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангахгүй мал, амьтны гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүн, малын тэжээл бэлтгэх, боловсруулах, хадгалах байрыг ашиглахыг хориглох;

4) мал, амьтны эм, бэлдмэл, өвчин үүсгэгч омгийг үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, худалдах, хэрэглэх явцад хяналт тавих;

5) халдвар тарах өвчтэй мал, амьтныг үржилд ашиглахыг хориглох;

6) мал эмнэлгийн шүүх магадлан шинжилгээ хийлгэх;

7) мал эмнэлгийн тусгай албаны байцаагчид төрийн байгууллагаас баталсан ялгах тэмдэг, дүрэмт хувцас хэрэглэх.

2. Мал үржлийн албаны улсын байцаагч дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын мал сүрэгт тогтоосон хугацаанд үзлэг хийж, цөм, торгон сүрэг, гойд ашиг шимт малыг сонгон шалгаруулж, баталгаажуулсан байдалд шалгалт хийх;

2) цөм, торгон сүргийн ашиг шимийн чиглэлийг өөрчлөх, үржлийн мал, түүний үр, үр хөврөлийг гадаадад гаргах, гадаадаас авахад улсын мал үржлийн төв албанаас зөвшөөрөл авсан эсэхийг шалгах, хууль бус үйлдлийг түдгэлзүүлэх, таслан зогсоох;

3) сүргийн зохистой бүтэц алдагдах, жишигт тэнцээгүй хээлтүүлэгчийг үржилд ашиглах, удам угсаа доройтуулахад чиглэсэн үйл ажиллагааг хориглох;

4) цөм, торгон сүрэг, гойд ашиг шимт малд төв байгууллагаас баталсан дүрэм, зааврын дагуу үржлийн бүртгэл хөтөлж, бонитлолт хийсэн байдлыг хянан шалгах;

5) мал, амьтны гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний чанарт хяналт тавьж, үнэлгээ өгөх.

*11 дүгээр зүйл.* Мал эмнэлгийн хорио цээр тогтоох үндэслэл, журам

1. Мал, амьтанд халдварт болон гоц халдварт өвчин гарвал мал эмнэлгийн албаны дүгнэлтийг үндэслэн тухайн шатны Засаг дарга хамаарах нутаг дэвсгэрийг өвчнөөр тайван бус нутаг гэж зарлаад хорио цээр тогтооно.

2. Хэд хэдэн аймгийн нутаг дэвсгэрт болон төмөр зам, нисэх, усан замын буудал, хилийн боомт, улсын чанартай авто болон мал туугийн замд гоц халдварт өвчин гарвал улсын мал эмнэлгийн төв албаны дүгнэлтийг үндэслэн Засгийн газар хорио цээр тогтооно.

3. Мал эмнэлгийн хорио цээр тогтоосон нөхцөлд тухайн шатны Засаг дарга хүн хүч, хөрөнгө гаргаж, мал, амьтны өвчинтэй тэмцэх шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

4. Хорио цээр тогтоох өвчний жагсаалтыг төв байгууллага батална.

5. Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрт дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

1) явган буюу аливаа хөсгөөр гадагш зорчих;

2) мал, амьтныг гаднаас оруулах, гадагш гаргах, дамжин өнгөрүүлэх;

3) мал, амьтны гаралтай түүхий эд бэлтгэх, гадагш гаргах, тээвэрлэх;

4) мал эмнэлгийн албаны зөвшөөрөлгүйгээр мал сүргийн хөдөлгөөн хийх, бэлчээр нутаг сэлгэх, ердийн хөсөг, унаагаар зорчих, тээвэр хийх;

5) өвчтэй болон эрүүл мал, амьтныг шилжүүлэн маллах;

6) өвчтэй мал, амьтны хашаа, байр, тоног төхөөрөмжийг бусад мал, амьтанд хэрэглэх, хашаа, байранд малын эмч, тухайн малчнаас өөр хүн оруулах.

6. Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрээс зайлшгүй шаардлагатай гарах бол ариутгал, халдваргүйжүүлэлт хийлгэж мал эмнэлгийн албаны зөвшөөрөл авна.

7. Халдварт өвчнийг бүрэн устгаж мал эмнэлэг, ариун цэврийн арга хэмжээг авч явуулсны дараа хорио цээрийг түүнийг тогтоосон байгууллага, албан тушаалтны шийдвэрээр татан буулгана.

*12 дугаар зүйл.* Улсын хилээр мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн нэвтрүүлэх

1. Хилийн боомт буюу хил орчмын сумын мал эмнэлгийн алба нь мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, малын тэжээл, бусад зүйлээр дамжин мал, амьтны болон малаас хүнд халдварладаг өвчин тус улсын нутагт гадаадаас нэвтрэх буюу гадагш гарах явдлаас урьдчилан сэргийлж, улсын хилээр зорчин өнгөрөх хөдөлгөөнд мал эмнэлэг, ариун цэврийн улсын хяналтыг тавьж хэрэгжүүлнэ.

2. Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн малын тэжээлийг холбогдох орны эрх бүхий байгууллагын хооронд байгуулсан гэрээ, хэлэлцээрт заасан журмын дагуу тухайн болон өөрийн орны мал эмнэлгийн албанаас олгосон гэрчилгээг үндэслэн улсын хилээр нэвтрүүлнэ.

3. Монгол Улсын нутагт зэргэлдээ улсаас өтрөөр мал, амьтан нэвтрүүлэхийг хоёр улсын мал эмнэлгийн хэлэлцээр, төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн хилийн боомт буюу хил орчмын сумын мал эмнэлгийн улсын байцаагч гаалийн болон хилийн хяналтын байгууллагуудын эрх бүхий албан тушаалтныг байлцуулан шийдвэрлэнэ.

4. Мал эмнэлгийн албаны гэрчилгээтэй боловч тээвэрлэлт, тууварлалтын явцад халдварт өвчний шинж тэмдэг илэрсэн мал, амьтан, гэмтэж муудсан түүхий эд, бүтээгдэхүүн, малын тэжээлийг улсын хилээр нэвтрүүлэхийг хориглоно.

5. Хил орчмын нутагт мал, амьтны гоц халдварт өвчин гарах үед улсын мал эмнэлгийн төв албаны дүгнэлтийг үндэслэн хилийн гарцыг Засгийн газрын шийдвэрээр тодорхой хугацаанд хаах хүртэл арга хэмжээ авна.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### *Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалахад иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг*

*13 дугаар зүйл.* Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх

Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалахад иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараахь эрх эдэлнэ:

1) улсын мал үржлийн албатай зөвшилцөн малынхаа ашиг шимийн чиглэлийг өөрчилж, үүлдэрлэг байдлыг сайжруулах;

2) тогтоосон журмын дагуу мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээ хийлгэхийг шаардах, үйлчлүүлэх албаа сонгох;

3) зохих журмын дагуу гойд ашиг шимт мал болон цөм, торгон сүргээс үржлийн мал бойжуулах, үр, үр хөврөл үйлдвэрлэх, худалдан борлуулах;

4) мал эмнэлэг, үржлийн албаны буруугаас учирсан хохирлыг хуульд заасан журмын дагуу нөхөн төлүүлэх.

*14 дүгээр зүйл.* Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг

1. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараахь нийтлэг үүрэг хүлээнэ:

1) мал, амьтныг нядлах, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, малын тэжээл бэлтгэх, боловсруулах ажлыг ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан байр, агуулах, орчинд хийж гүйцэтгэх;

2) мал, амьтныг аймаг, нийслэл, сумын нутаг дэвсгэрээс гаргахдаа шинжүүлэн хөдөлгөх, мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх, тээвэрлэх, хүлээн авах, улсын хил нэвтрүүлэхэд мал эмнэлгийн ариун цэврийн үзлэг, шинжилгээ хийлгэж зөвшөөрөл авах;

3) мал эмнэлэг, үржлийн ажлын төлбөрт үйлчилгээний хөлс, хуульь тогтоомжид заасан хураамж төлөх;

4) мал эмнэлгийн хорио цээрийн дэглэмийг биелүүлэх;

5) мал, амьтны өвчнийг оношлох, эмчлэх, сэргийлэх болон малын удмын сан устаж үрэгдэхээс хамгаалах ажлыг зохион байгуулахад төв байгууллагаас баталсан дүрэм, зааврыг биелүүлэх;

6) мал, амьтанд халдварт өвчний шинж тэмдэг илэрсэн, гэнэт олноор хорогдсон тохиолдолд мал эмнэлгийн алба буюу баг, хорооны удирдлагад 12 цагийн дотор мэдэгдэх.

2. Мал, амьтан бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага дараахь үүрэг хүлээнэ:

1) мал эмнэлэг, үржлийн аль нэг албанд харьяалагдаж тэдгээрээс зохиож байгаа арга хэмжээнд мал, амьтныг тогтоосон хугацаанд нь бүрэн хамруулах;

2) мал, амьтны байр, орчны ариун цэвэр, эрүүл ахуй, арчилгаа, маллагаа, тэжээллэг, эдэлгээ нь технологийн шаардлага хангасан байх;

3) эрүүл мал, амьтан, баталгаажуулсан хээлтүүлэгчийг үржилд ашиглах, хээлтүүлгийн нас гүйцсэн малыг нийлүүлэгт оруулах;

4) бэлчээрийн маллагаатай бог малыг жилд нэгээс илүү төллүүлэхгүй байх;

5) цөм, торгон сүргийн мал болон гойд ашиг шимт малд тэмдэг, дугаар тавьж, үржлийн малын удмын болон үржил, ашиг шимийн бүртгэлийг зохих журмын дагуу хөтлөх;

6) гойд ашиг шимт мал болон цөм, торгон сүргийн мал хорогдсон, тэдгээрийг худалдах, арилжих, бэлэглэх зэргээр бусдад шилжүүлсэн тухайгаа сум, дүүргийнхээ мал үржлийн албанд мэдэгдэх;

7) бүх төрлийн, түүний дотор сүрэг сэлбэх өсвөр хээлтүүлэгчийг цөм, торгон сүргээс бойжуулж, улсын мал эмнэлэг, үржлийн албаар үзлэг, шинжилгээ хийлгэж, магадлагаа авсны дараа үржилд ашиглах;

8) цөм, торгон сүргийн ашиг шимийн чиглэлийг өөрчлөх, үржлийн мал, түүний үр, үр хөврөлийг гадаадад гаргах, гадаадаас авчирч үржилд ашиглахдаа улсын мал үржлийн төв албанаас зөвшөөрөл авах.

## ТАВДУГААР БҮЛЭГ

### *Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах хуулийн биелэлтийг хангах баталгаа*

*15 дугаар зүйл.* Эдийн засгийн баталгаа

1. Улсын мал эмнэлэг, үржлийн албанаас малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах талаар хэрэгжүүлдэг дараахь арга хэмжээний зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ:

1) халдварт, гоц халдварт өвчинтэй тэмцэх, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх;

2) төрийн өмчид байх цөм сүргийн малыг өсгөн үржүүлэх, үржлийн ажлыг явуулах;

3) байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулаас сэргийлэх, тэмцэх.

2. Улсын мал эмнэлэг, үржлийн албаны ажилтны цалин, үйл ажиллагааны зардлыг улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд мал эмнэлэг, үржлийн албаны ажил, үйлчилгээ төлбөртэй байна.

4. Улсын мал эмнэлэг, үржлийн албанаас үзүүлэх ажил, үйлчилгээний төлбөрийн хэмжээг хуульд өөрөөр заагаагүй бол Засгийн газар тогтооно.

5. Мал ,амьтныг халдварт өвчин, байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулаас хамгаалах, даатгалтай мал, амьтан хорогдсоноос учирсан хохирлыг нөхөн төлөх санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэх даатгалын тогтолцоог хуулиар тогтооно.

*16 дугаар зүйл.* Малын эмч, мал зүйчдийн ажиллах нөхцөл

1. Мал эмнэлэг, үржлийн албад, мал бүхий аж ахуйн нэгж, байгууллагын захиргаа нь тогтоосон журам, нөхцөлийн дагуу ажлын тусгай хувцас, хөдөлмөр хамгаалах хэрэгсэл, ариутгах, ццэврлэх, угаах, хамгаалах бодис үнэгүй олгоно.

2. Малын эмч, мал зүйчдийн хөдөлмөрийн нөхцөлийн талаар баримтлах журмыг төв байгууллагатай зөвшилцөн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

3. Мал эмнэлэг, үржлийн зохих шатны албаны захиргаа нь малын эмч, мал зүйчдийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

4. Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүйн нөхцөлөөр хангагдаагүйгээс малын эмч, мал зүйчид үйлдвэрийн осолд өртсөн буюу мэргэжлээс шалтгаалах өвчнөөр өвчилсөн учирсан шууд хохирлыг хөдөлмөрийн болон иргэний хууль тогтоомжийн дагуу захиргаа нөхөн төлнө.

*17 дугаар зүйл.* Хууль зүйн баталгаа

1. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалахтай холбогдсон хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, зааврыг тус улсын нутаг дэвсгэрт байгаа нийт иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хэрхэн сахин биелүүлж байгаад мал эмнэлэг, үржлийн улсын алба эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавина.

2. Мал эмнэлэг, үржлийн албаны улсын байцаагч малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах хууль тогтоомжийг зөрчигчдөд захиргааны хариуцлага хүлээлгэх эрхтэй.

*18 дугаар зүйл.* Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

1. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах хууль тогтоомж зөрчсөн этгээдэд түүний гэм буруу, зөрчлийн шинж байдал, учруулсан хохирлын хэмжээг харгалзан хуульд заасан эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

2. Иргэн, албан тушаалтны дараах үйлдэл, эс үйлдэхүй гэмт хэргийн шинжгүй бол түүнд доор дурдсан захиргааны хариуцлага хүлээлгэнэ:

1) цөм, торгон сүрэг, гойд ашиг шимт малын бүртгэл хөтлөөгүй, бүртгэгдсэн малыг худалдах, арилжих, бэлэглэх зэргээр бусдад шилжүүлсэн тухайгаа зохих шатны мал үржлийн албанд мэдэгдээгүй бол 500 хүртэл төгрөгөөр торгох;

2) мал эмнэлгийн үзлэг, шинжилгээ хийлгээгүй, баталгаажуулаагүй хээлтүүлэгчийг нийлүүлэгт оруулсан, цөм, торгон сүрэгт мал үржлийн албаны зөвшөөрөлгүй өөр чиглэлийн хээлтүүлэгч ашиглан удам угсааг доройтуулсан, хээлтүүлгийн нас гүйцээгүй малыг зориуд нийлүүлэгт оруулсан, бэлчээрийн маллагаатай бог малыг жилд дахин төллүүлсэн бол 1000 хүртэл төгрөгөөр торгох;

3) мал эмнэлэг, үржлийн албадаас явуулж байгаа арга хэмжээнд мал сүргээ тогтоосон хугацаанд нь бүрэн хамруулаагүй, мал, амьтны өвчнийг эмчлэх мал төллүүлэх, хээлтүүлэх ажилд баримтлах дүрэм, зааврыг зөрчсөн бол 300—1000 төгрөгөөр торгох;

4) шинээр зохион бүтээсэн болон гадаадаас авсан, мал, амьтны эм, бэлдмэл, өвчин үүсгэгчийн омог, үржлийн мал, малын үр, үр хөврөлийг зөвшөөрөлгүйгээр үйлдвэрлэлд ашигласан бол 5000 хүртэл төгрөгөөр торгох;

5) ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангаагүй байр орчинд мал, амьтныг нядалсан, түүхий эд, хүнсний бүтээгдэхүүн бэлтгэсэн, боловсруулсан, тээвэрлэсэн, хадгалснаас гарсан үр дагавар, хохирлын хэмжээг харгалзан 5000 хүртэл төгрөгөөр торгох;

6) халдвар тараах өвчтэй малыг үржилд ашигласан бол 1000—5000 төгрөгөөр торгох;

7) мал, амьтанд халдварт өвчний шинж тэмдэг илэрсэн, гэнэт олноор хорогдсон тухай мал эмнэлгийн алба буюу баг, хорооны удирдлагад энэ хуульд заасан хугацаанд мэдэгдээгүй; мал, амьтан, хүнд халдварлах өвчтэй нь мал эмнэлгийн албаны

шинжилгээгээр тогтоогдсон мал, амьтныг зохих зааврын дагуу ялдлаагүй, устгаагүйгээс гарсан үр дагавар, хохирлын хэмжээг харгалзан 10000 хүртэл төгрөгөөр торгох;

8) хорио цээрийн дэглэмийг зөрчсөн бол 10000 хүртэл төгрөгөөр торгох;

9) мал, амьтны гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүнийг мал эмнэлгийн албаны шинжилгээ, зөвшөөрөлгүй нийтийн хэрэгцээнд бэлтгэсэн, нийлүүлсэн, хүлээн авсан, хүний эрүүл мэндэд хор учруулах мал, амьтны өвчин тараах нь тогтоогдсон түүхий эд, хүнсний бүтээгдэхүүнийг ариутгаагүй, халдваргүйжүүлээгүй худалдсан, эдгээр зүйлээр үйлдвэрлэл, үйлчилгээ явуулсан бол хууль бусаар олсон орлогыг хурааж 2000—10000 төгрөгөөр торгох;

10) мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, малын тэжээлийг тухайн болон өөрийн орны мал эмнэлгийн албаны гэрчилгээгүй; халдварт өвчний шинж тэмдэгтэй мал, амьтан, гэмтэж муудсан түүхий эд, бүтээгдэхүүн, малын тэжээлийг улсын хилээр нэвтрүүлэхийг завдсан буюу нэвтрүүлсэн бол 10000—25000 төгрөгөөр торгох.

3. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах хууль тогтоомж зөрчсөнөөс бусдад учруулсан материалын хохирлыг гэм буруутай этгээдээр Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу нөхөн төлүүлэхийг сонирхогч этгээд нэхэмжлэх эрхтэй.

*19 дүгээр зүйл.* Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1993 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын
дарга — Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын
Тамгын газрын Ерөнхий
нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН**
**ХУУЛЬ**

1993 оны 4 дүгээр
сарын 13-ны өдөр

Улаанбаатар
хот

## ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль батлагдсантай холбогдуулан Захиргааны хариуцлагын тухай хуулийн 53 дугаар зүйлийг 1993 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Их Хурлын
дарга — Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын
Тамгын газрын Ерөнхий
нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

МОНГОЛ УЛСЫН
**ХУУЛЬ**

1993 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр — Улаанбаатар хот

## ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 15 дугаар заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1993 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр Москва хотноо байгуулсан Монгол Улс, Оросын Холбооны Улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Гэрээг Засгийн газраас өргөн мэдүүлсний дагуу соёрхон батлагсугай.

Монгол Улсын Их Хурлын дарга — **Н. БАГАБАНДИ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга — **Н. РИНЧИНДОРЖ**

# МОНГОЛ УЛСЫН ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬ

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### *Нийтлэг үндэслэл*

*1 дүгээр зүйл.* Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Үндсэн хуульд заасан прокурорын чиг үүргийг хэрэгжүүлэх, Монгол Улсын прокурорын байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

*2 дугаар зүйл.* Прокурорын байгууллага

Монгол Улсын прокурорын байгууллага (цаашид «прокурорын байгууллага» гэх) нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүргийг хэрэгжүүлнэ.

*3 дугаар зүйл.* Прокурорын байгууллагын тухай хууль тогтоомж, олон улсын гэрээ

1. Прокурорын байгууллагын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заагаагүй бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

*4 дүгээр зүйл.* Прокурорын байгууллагын зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн зарчим

Прокурорын байгууллагын зохион байгуулалт, үйл ажиллагаа нь нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх, гадны нөлөөнд үл автах, хуулийг нэг мөр хэрэглэх зарчимд үндэслэнэ.

*5 дугаар зүйл.* Нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх

1. Нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх зарчим дараах байдлаар хэрэгжинэ:

1) дээд шатны прокурорын шийдвэрийг доод шатны прокурор заавал биелүүлэх. Дээд шатны прокурорын шийдвэр хуульд нийцсэн байна;

2) доод шатны прокурор нь дээд шатны прокурорын өмнө ажлаа хариуцан тайлагнах;

) Хуульд өөрөөр заагаагүй бол дээд шатны прокурор нь өөрийн тодорхой бүрэн эрхийг доод шатны прокурорт шилжүүлэх;

4) дээд шатны прокурор нь доод шатны прокурорын хууль бус, үндэслэлгүй шийдвэрийг хүчингүй болгох, өөрчлөх, буцаан авах;

5) дээд шатны прокурор нь доод шатны прокурорын үйл ажиллагаа, шийдвэрийн талаархи гомдлыг хянан шийдвэрлэх.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалтууд тодорхой хэргийн нотлох баримтыг прокурор өөрийн дотоод итгэлээр үнэлэхэд хамаарахгүй.

*6 дугаар зүйл.* Гадны нөлөөнд үл автах

1. Прокурор бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ гадны нөлөөнд үл автан, гагцхүү хууль, түүнд нийцүүлэн гаргасан Улсын ерөнхий прокурорын шийдвэрийг удирдлага болгоно.

2. Прокурор бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд бусад байгууллага, албан тушаалтан, иргэн хэн боловч хөндлөнгөөс оролцож, дарамт шахалт үзүүлж болохгүй.

*7 дугаар зүйл.* Хуулийг нэг мөр хэрэглэх

Прокурор бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ орон нутгийн болон байгууллага, салбарын онцлогийг үл харгалзан хуулийг нэг мөр хэрэглэх явдлыг өөрийн чиг үүргийн хүрээнд хангана.

*8 дугаар зүйл.* Прокурорын байгууллагын тогтолцоо

1. Прокурорын байгууллага:

1) Улсын ерөнхий прокурорын газар;

2) аймаг, нийслэлийн прокурорын газар;

3) сум, сум дундын буюу дүүргийн прокурорын газраас бүрдэнэ.

2. Прокурорын газрыг ажлын шаардлага, хүн ам, нутаг дэвсгэрийн байдлыг харгалзан Улсын Их Хурал байгуулна. Прокурорын хяналтын ажлын онцлог, Улсын ерөнхий прокурорын саналыг үндэслэн дагнасан прокурорын газрыг байгуулж болно.

3. Прокурорын газар үйл ажиллагааныхаа чиглэлээр зохион байгуулалтын бүтцийн нэгж, алба болон ажлын аппараттай байна.

4. Улсын ерөнхий прокурор, аймаг, нийслэлийн прокурорын дэргэд тэдгээрийн эрх хэмжээнд хамаарах асуудлаар зөвлөх эрх бүхий зөвлөл ажиллана.

*9 дүгээр зүйл.* Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нар, тэдгээрийн бүрэн эрхийн хугацаа

1. Прокурорын байгууллагыг Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хуралтай зөвшилцөн 6 жилийн хугацаагаар томилсон Улсын ерөнхий прокурор толгойлно.

2. Ерөнхийлөгч Улсын ерөнхий прокурорын саналыг үндэслэн түүний орлогч нарыг Улсын Их Хуралтай зөвшилцөн 6 жилийн хугацаагаар томилох бөгөөд тэд Улсын ерөнхий прокурорын өмнө ажлаа хариуцан, түүний эзгүйд бүрэн эрхийг нь хэрэгжүүлнэ.

3. Улсын ерөнхий прокурор, түүний орлогчийн бүрэн эрхийн хугацаа тэдгээрийг томилсон өдрөөс эхэлж, Улсын ерөнхий прокурор, түүний орлогчийг шинээр томилсноор дуусгавар болно.

4. Улсын ерөнхий прокурор, түүний орлогч гэмт хэрэгт холбогдсон бол энэ тухай эрх бүхий байгууллагын дүгнэлт, шийдвэрийг үндэслэн Ерөнхийлөгч бүрэн эрхийг нь түдгэлзүүлж болно.

5. Улсын ерөнхий прокурор, түүний орлогчийн бүрэн эрх дараахь тохиолдолд Ерөнхийлөгчийн шийдвэр гарснаар хугацаанаас өмнө дуусгавар болно:

1) биеийн эрүүл мэндийн байдал болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхээ цаашид хэрэгжүүлэх боломжгүй болсон;

2) өөрийнх нь зөвшөөрснөөр өөр ажилд томилсон буюу сонгосон;

3) чөлөөлөгдөх тухай хүсэлтээ гаргасан;

4) гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### *Прокурорын эрх хэмжээ*

*10 дугаар зүйл.* Хэрэг бүртгэх ажиллагаанд тавих хяналт

Прокурор дараахь ажиллагаанд хяналт тавина:

1) төрийн захиргааны эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаа хуульд нийцэж байгаа эсэх;

2) гэмт хэргийн үйл баримтыг шалгаж тогтоох, гэмт этгээдийг илрүүлэх талаар хийж байгаа хэрэг бүртгэх ажиллагаа хуулийн дагуу явагдаж байгаа эсэх;

3) мөрдөн байцаалт заавал явуулахаар хуульд тусгайлан заасна ас бусад эрүүгийн хэргийг бүртгэх ажиллагаа хуулийн дагуу явагдаж байгаа эсэх.

*11 дүгээр зүйл.* Мөрдөн байцаах ажиллагаанд тавих хяналт

Прокурор дараахь ажиллагаанд хяналт тавина:

1) мөрдөн байцаах ажиллагаа Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа эсэх;

2) мөрдөн байцаах ажиллагаанд Эрүүгийн хуулийг зөв хэрэглэж байгаа эсэх.

*12 дугаар зүйл.* Яллан эдлүүлэх ажиллагаанд тавих хяналт

Прокурор дараахь ажиллагаанд хяналт тавина:

1) ял эдлүүлэх ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа эсэх;

2) хорих ял эдлүүлэх ажиллагаа хуулиар тогтоосон нөхцөл, дэглэмд нийцэж байгаа эсэх;

3) ял эдэлж байгаа этгээдийн хууль ёсны эрхийг хангаж байгаа эсэх;

4) эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэглэж байгаа эсэх.

*13 дугаар зүйл.* Прокурор шүүх хуралдаанд оролцох

1. Прокурор шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно.

2. Прокурор эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд улсын яллагчаар оролцоно. Улсын яллагч хууль болон хангалттай нотлох баримтад тулгуурласан өөрийн дотоод итгэлийг удирдлага болгон шүүгдэгчийн гэм бурууг шүүхийн өмнө нотлох үүргийг гүйцэтгэнэ. Хэрэв гэм буруу нь шүүх хуралдааны явцад нотлогдоогүй гэж прокурор үзвэл яллахаас татгалзана. Мөрдөн байцаалт явуулсан эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд улсын яллагч заавал оролцоно.

3. Иргэн, захиргааны зэрэг бусад төрлийн хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд хуульд заасан журмын дагуу төрийг төлөөлөн оролцоно.

4. Шүүхийн шийдвэр хэргийн бодит байдал болон хуульд нийцээгүй гэж прокурор үзвэл эсэргүүцэл бичнэ.

*14 дүгээр зүйл.* Прокурорын үндсэн бүрэн эрх

1. Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих чиг үүргийн дагуу дараахь үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) хэргийн тухай гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх, шалгаж шийдвэрлэх журмын биелэлтийг хянах;

2) эрүүгийн хэрэг үүсгэх ажиллагаанд хяналт тавих;

3) хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явц, үр дүнг хянахын тулд хэргийн баримт материал, бусад мэдээг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаас танилцах;

4) хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хуулийн заалтыг зөрчихийг хангуулах, хуулийг хэрэглэх талаар болон тодорхой ажиллагааг гүйцэтгүүлэхээр хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид заалт өгөх;

5) хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад хүний эрх, эрх чөлөө, хувийн болон гэр бүл, захидал харилцааны нууц, орон байр, өмчийн халдашгүй байдлыг хөндсөн ажиллагаа явуулах зайлшгүй шаардлага гарвал зөвшөөрөл өгөх асуудлыг хянан шийдвэрлэх;

6) хэрэг бүртгэх, мөрдөн байцаах зарим ажиллагааг явуулахад оролцох;

7) хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн хууль бус, үндэслэлгүй шийдвэрийг хүчингүй болгох буюу өөрчлөх;

8) мөрдөн байцаалт заавал явуулах шаардлагатай гэж үзвэл эрүүгийн хэргийг хэрэг бүртгэлтээс мөрдөн байцаалтад шилжүүлэх;

9) хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад хуулийг ноцтой зөрчсөн буюу уг хэрэгт хувийн сонирхолтой, эсхүл хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа зохих ёсоор гүйцэтгэж чадахгүй байвал хэргийг бодитойгоор мөрдүүлэхийн тулд тухайн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаар хэргийг цаашид мөрдүүлэхийг зогсоох, өөр хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид шилжүүлэх;

10) хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны үр дүнг үндэслэн хэргийг мөрдөн байцаалтад болон шүүхэд шилжүүлэх, эсхүл нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцаах;

11) хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах буюу хэргийг хэрэгсэхгүй болгох;

12) хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллага, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн үйл ажиллагаа, шийдвэрийн талаар прокурорын байгууллагад гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх;

13) хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон хяналтын ажилд шаардлагатай мэдээ, судалгаа, баримт бичгийг аль ч байгууллага, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах, газар дээр нь танилцах, мэргэжлийн байгууллага, шинжээч, мэргэжилтний дүгнэлт, магадлагаа гаргуулах;

14) албан тушаалтан, иргэнээс тайлбар, мэдүүлэг гаргуулах, хуульд заасан журмын дагуу албадан ирүүлэх;

15) хуулийг биелүүлэх, гэмт явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд санал тавих буюу гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгахыг шаардах;

16) хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэвийн ажиллагааг хангах, уул ажиллагаанд илэрсэн дутагдлыг арилгах талаар хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагын захиргаанд шаардлага тавих;

17) хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажлыг шалгах;

18) хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагын захиргаанаас хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны талаар гаргасан тушаал, шийдвэр хуульд нийцэж байгаа эсэхийг хянах, хууль бус тушаал, шийдвэрт эсэргүүцэл бичих;

19) баривчлах, албадан саатуулах, цагдан хорих байранд ямар ч цагт саадгүй нэвтрэн орох, хоригдож байгаа хүмүүстэй биечлэн уулзах, хууль ёсны үндэслэлгүйгээр хоригдож байгаа этгээдийг нэн даруй суллах.

2. Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавихдаа Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан үндэслэл, журмын дагуу мөрдөн шалгах ажиллагаа явуулж болно.

3. Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх журмыг Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон хууль тогтоомжийн бусад актаар тогтооно.

4. Прокурор ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих чиг үүргийн дагуу дараах үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) ял эдлүүлэх, шүүхийн тогтоолыг биелүүлэх ажиллагааг шалгах;

2) ял эдлүүлэх байгууллагад ямар ч цагт саадгүй нэвтрэх, холбогдох этгээдээс тайлбар гаргуулах;

3) ял эдэлж байгаа хүмүүстэй биечлэн уулзах;

4) ял эдлүүлэх үндэслэл болсон тогтоол, шийдвэр, баримт бичигтэй танилцах;

5) ял эдлүүлэх байгууллагын захиргаанаас ял эдлүүлэх ажиллагааны талаар гаргасан тушаал, шийдвэр хуульд нийцэж байгаа эсэхийг хянах, хууль бус тушаал, шийдвэрт эсэргүүцэл бичих;

6) ял эдлүүлэх дэглэмийг өөрчлөх, ялын төрлийг солих, ял эдлүүлэхээс чөлөөлөх буюу хойшлуулах зэрэг асуудлыг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд оролцож, санал дүгнэлт гаргах;

7) хууль ёсны үндэслэлгүйгээр ял эдэлж байгаа болон сахилгын хорих байранд хууль бусаар хоригдож байгаа хүнийг нэн даруй суллах.

5. Шүүх хуралдаанд оролцох прокурорын бүрэн эрх, түүнийг хэрэгжүүлэх журмыг байцаан шийтгэх хуулиар тогтооно.

6. Прокурор хууль тогтоомж, түүнд нийцүүлэн Улсын ерөнхий прокуророос гаргасан журам, заавар, төрийн албан хаагчийн баримтлах ёс зүйн хэм хэмжээг сахих, хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, албан үүрэгтэй нь холбогдож илэрхий болсон, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцыг хадгалах үүрэгтэй.

*15 дугаар зүйл.* Улсын ерөнхий прокурорын бүрэн эрх

1. Улсын ерөнхий прокурор дараахь үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) прокурорын байгууллагын үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, удирдах;

2) Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг хянан шийдвэрлүүлэхээр Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах;

3) Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргуулахаар Улсын дээд шүүхэд санал оруулах;

4) хууль, түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар Улсын дээд шүүхэд асуудал шилжүүлэх;

5) анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр хуульд нийцээгүй гэсэн доод шатны прокурорын саналыг үндэслэлтэй гэж үзвэл эсэргүүцэл бичих;

6) Улсын дээд шүүхийн хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох;

7) Улсын Их Хурлаас баталсан төсвийг хуваарилах, түүнд багтаан прокурорын газруудын зохион байгуулалтын бүтэц, орон тоог тогтоох;

8) Улсын ерөнхий прокурорын орлогч нарыг томилуулах, чөлөөлүүлэх тухай саналаа Ерөнхийлөгчид оргон мэдүүлэх;

9) харьяа прокурорыг томилох, чөлөөлөх, урамшуулах, шийтгэх;

10) хуулийг хэрэгжүүлэх талаар прокурорын хяналтын болон хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд дагаж мөрдөх аргачилсан заавар гаргах;

11) прокурорын байгууллагын дотоод асуудлаар тушаал гаргах.

2. Улсын ерөнхий прокурор хуулиар тогтоосон бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

*16 дугаар зүйл.* Улсын Их Хуралтай харилцах

1. Улсын ерөнхий прокурор тус улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хууль тогтоомж хэрхэн хэрэгжиж байгаа талаар санал дүгнэлт гаргана.

2. Прокурорын бүрэн эрхэд хамаарах асуудлаар Үндсэн хууль тайлбарлах хүсэлтийг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд гаргаж болно.

*17 дугаар зүйл.* Монгол Улсын Ерөнхийлөгчтэй харилцах

1. Улсын ерөнхий прокурор прокурорын байгууллагын үйл ажиллагааны талаар Ерөнхийлөгчид тогтмол мэдээлж байна.

2. Ерөнхийлөгчийн тавьсан хүсэлтийн дагуу Улсын ерөнхий прокурор өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар дүгнэлт гаргана.

*18 дугаар зүйл.* Засгийн газартай харилцах

1. Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний хүсэлтээр Улсын ерөнхий прокурор өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Засгийн газрын хуралдаанд зөвлөх эрхтэйгээр оролцож, санал дүгнэлт гаргаж болно.

2. Улсын ерөнхий прокурор шаардлагатай гэж үзвэл өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Ерөнхий сайдтай зөвшилцөн Засгийн газрын хуралдаанд асуудал оруулж болно.

*19 дүгээр зүйл.* Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах

1. Улсын ерөнхий прокурор Үндсэн хуулийн жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг хянан шийдвэрлүүлэхээр Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргана.

2. Улсын ерөнхий прокурорын нийтэд гаргасан хүсэлт Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан байна.

*20 дугаар зүйл.* Улсын дээд шүүхэд асуудал шилжүүлэх

Хууль, түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн тухай баримт Улсын ерөнхий прокурор бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад илэрвэл түүнийг шийдвэрлүүлэхээр Улсын дээд шүүхэд шилжүүлнэ.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

*Прокурорын хяналтын эрх зүйн хэлбэр*

*21 дүгээр зүйл.* Эрх зүйн хэлбэрийн төрөл

1. Прокурор бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ эсэргүүцэл, мэдэгдэл, тогтоол, даалгавар, зөвшөөрөл, нэхэмжлэл гаргана.

Тэдгээрийн загварыг Улсын ерөнхий прокурор батална.

2. Прокурорын хяналтын эрх зүйн хэлбэрийн бусад төрлийг хуулиар тогтоож болно.

*22 дугаар зүйл.* Прокурорын эсэргүүцэл

1. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх байгууллагаас эдгээр ажиллагааны талаар гаргасан хууль бус шийдвэрийг хүчингүй болгуулах, зөвтгүүлэхээр тухайн албан тушаалтан буюу дээд шатны албан тушаалтанд прокурор эсэргүүцэл бичнэ. Ийнхүү эсэргүүцэл бичигдсэн шийдвэрийн хүчин төгөлдөр үйлчлэх явдлыг уул эсэргүүцлийг хэлэлцэж эцсийн шийдвэр гарах хүртэл түдгэлзүүлнэ.

2. Прокурорын эсэргүүцлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шийдвэрлэж хариу мэдэгдэнэ. Хэрэв прокурорын эсэргүүцлийг хүлээн авсан албан тушаалтан түүнийг биелүүлэхээс татгалзвал прокурор тухайн шийдвэрийг хүчингүй болгуулах хүсэлтээ шүүхэд гаргана.

3. Прокурорын хүсэлтийг байцаан шийтгэх хуульд заасан журмаар шүүх хянан шийдвэрлэх бөгөөд прокурор шүүхийн зардлаас чөлөөлөгдөнө.

4. Прокурор шүүхийн шийдвэрт эсэргүүцэл бичих, түүнийг шүүхээр хянан шийдвэрлэх журмыг байцаан шийтгэх хуулиар тогтооно.

*23 дугаар зүйл.* Прокурорын мэдэгдэл

1. Прокурор нь хууль зөрчсөн үйл ажиллагаа, түүнд шууд нөлөөлсөн шалтгаан нөхцлийг арилгуулахаар өөрийн эрх хэмжээний хүрээнд мэдэгдэл бичнэ.

2. Прокурорын мэдэгдлийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан, зөрчил, түүний шалтгаан нөхцлийг нэн даруй арилгах арга хэмжээг мэдэгдэлд заасан хугацаанд авч хэрэгжүүлэн албан ёсоор хариу өгнө.

*24 дүгээр зүйл.* Прокурорын тогтоол

Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих чиг үүргийн дагуу хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өөрийн эрх хэмжээний хүрээнд тодорхой асуудлыг шийдвэрлэхийн тулд тогтоол гаргана.

*25 дугаар зүйл.* Прокурорын даалгавар

Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хуулийн заалтыг хангуулах, хуулийг зөв хэрэглэх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг цаг тухайд нь бүрэн бодитой явуулах арга хэмжээний талаар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид бичгээр даалгавар өгнө. Прокурорын даалгаврыг эс зөвшөөрвөл дээд шатны прокурорт давж заалдах журмыг байцаан шийтгэх хуулиар тогтооно.

*26 дугаар зүйл.* Прокурорын зөвшөөрөл

1. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөө, хүний болон гэр бүл, захидал харилцааны нууц, орон байр, өмчийн халдашгүй байдлыг хөндсөн ажиллагаа явуулахад прокурор бичгээр зөвшөөрөл өгнө.

2. Прокурорын зөвшөөрөл энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан ажиллагаа явуулах албан тушаалтны шийдвэрийг баталгаажуулах хэлбэрээр үйлдэгдэнэ.

*27 дугаар зүйл.* Прокурорын нэхэмжлэл

Прокурор төрийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргана.

*28 дугаар зүйл.* Прокурорын шийдвэрийг биелүүлэх, түүнд гомдол гаргах

1. Хуульд заасан үндэслэл, журмын дагуу гаргасан прокурорын шийдвэрийг байгууллага, албан тушаалтан, иргэн заавал биелүүлнэ. Албан тушаалтан, иргэн прокурорын дуудсанаар заавал хүрэлцэн ирж, тавьсан асуудлаар тайлбар өгөх үүрэгтэй.

2. Прокурорын шийдвэрийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан, иргэн түүнийг эс зөвшөөрвөл 7 хоногийн дотор дээд шатны прокурорт гомдол гаргаж болно. Дээд шатны прокурор гомдлыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор хянан шийдвэрлэж бичгээр хариу мэдэгдэнэ.

3. Прокурорын шийдвэрийн талаарх гомдлыг шалгуулах буюу шийдвэрлүүлэхээр тухайн шийдвэрийг гаргасан прокурорт шилжүүлж болохгүй.

4. Энэ хуулийн 26 дугаар зүйлд заасан прокурорын зөвшөөрлийн талаарх гомдлыг тухайн шатны шүүхэд гаргана.

5. Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан буюу хэргийг хэрэгсэхгүй болгосон прокурорын шийдвэрийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, хохирогч буюу түүний хууль ёсны төлөөлөгч эс зөвшөөрвөл дээд шатны прокурорт болон улмаар шүүхэд гомдол гаргаж болно.

6. Улсын ерөнхий прокурорын шийдвэр хуульд нийцээгүй бол өөрөө хүчингүй болгоно.

7. Улсын ерөнхий прокурорын шийдвэрийг хуульд нийцээгүй гэж үзсэн этгээд Улсын дээд шүүхэд гомдол гаргаж болно.

8. Энэ зүйлийн заалтууд шүүгчид хамаарахгүй.

9. Прокурорын шийдвэрийг биелүүлэх талаар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарын хүлээх үүрэг, хариуцлагыг хуулиар тогтооно.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### *Прокурорын үйл ажиллагааны баталгаа*

*29 дүгээр зүйл.* Улс төрийн баталгаа

1. Прокурорын байгууллагад улс төрийн нам, холбоо, эвсэл, хөдөлгөөний үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

2. Прокурор хууль ёсны эрх ашгаа хамгаалах, мэргэшлээ дээшлүүлэх зорилгоор мэргэжлийн болон олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдэх эрх чөлөө эдэлнэ.

3. Прокурор үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөгөө эдлэхдээ өөрийн албан тушаалд хүндэтгэлтэй хандана.

*30 дугаар зүйл.* Эдийн засаг, нийгмийн баталгаа

1. Прокурорын байгууллагын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгаагаар хангана.

2. Прокурорын байгууллагын төсвийг Улсын ерөнхий прокурорын саналыг үндэслэн Улсын Их Хурал баталж, улсын төсөвт тусгайлан тусгана. Прокурорын байгууллагын төсөв нь үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байвал зохино.

3. Хуульд заасныас бусад тохиолдолд прокурорыг ажлаас чөлөөлөх, огцруулах, түүнчлэн өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр ажил, албан тушаалд шилжүүлэхийг хориглоно.

4. Прокурорын цалингийн хэмжээг Улсын Их Хурал тогтооно.

5. Прокурорын байгууллагыг ажлын байр, шаардлагатай тоног төхөөрөмж, тээврийн болон техникийн хэрэгсэл, ажилтнуудыг орон сууцаар хангах зэрэг үйл ажиллагаагаа харьяат бусаар явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд төрийн захиргааны байгууллага бүх талын дэмжлэг үзүүлнэ.

6. Прокурор албан үүргээ гүйцэтгэж байхдаа хөдөлмөрийн чадвараа түр алдсан, тахир дутуу болсон бол түүний авч байсан цалин, тэтгэвэр, тэтгэмжийн зөрүүг, харин хиймэл эрхтэн хийлгэсэн бол түүний зардлыг тэр хариуцна.

7. Прокурор албан үүргээ гүйцэтгэж байхдаа амь насаа алдсан буюу албан үүрэгтэй нь холбогдуулан амь насыг нь хохироосон бол түүний ар гэрт 3 жилийн цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно.

8. Энэ зүйлийн 6, 7 дахь хэсэгт заасан тэтгэвэр, тэтгэмж, авч байсан цалингийн зөрүү, хиймэл эрхтэн хийлгэсний зардал, буцалтгүй тусламжийг улсын төсвөөс олгож, хуульд заасан тохиолдолд хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

*31 дүгээр зүйл. Хууль зүйн баталгаа*

1. Прокурорыг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилснаас бусад тохиолдолд Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нарыг Ерөнхийлөгчийн зөвшөөрөлгүйгээр, бусад прокурорыг Улсын ерөнхий прокурорын зөвшөөрөлгүйгээр албадан саатуулах, цагдан хорих, баривчлах, орон байр, албан тасалгаа болон биед нь халдах, үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно.

2. Прокурорыг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу гэмт хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилсан, эсхүл эрүүгийн хариуцлагад татах хангалттай үндэслэл тогтоогдсон бол энэ тухай Ерөнхий прокурор, түүний орлогчийн талаар Ерөнхийлөгчид, бусад прокурорын талаар Улсын ерөнхий прокурорт 48 цагийн дотор мэдэгдэнэ.

3. Ерөнхийлөгч буюу Улсын ерөнхий прокурор уг асуудлыг 10 хоногийн дотор хянаж прокурорыг эрүүгийн хариуцлагад татах зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ.

4. Прокурорыг эрүүгийн хариуцлагад татсантай холбогдуулан түүний бүрэн эрхийг Улсын ерөнхий прокурор түдгэлзүүлж болно.

5. Прокурорыг албадан саатуулах, цагдан хорих, баривчлах, орон байр, албан тасалгаа болон биед нь халдах, үзлэг, нэгж-

лэг хийх шаардлагатай бол энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан журмын дагуу зөвшөөрөл авна.

6. Бусад байгууллага, албан тушаалтан прокурорын хяналтын ажлыг Улсын ерөнхий прокурорын зөвшөөрөлгүйгээр шалгах буюу албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбогдож илэрхий болсон, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төр, байгууллага, хувь хүний нууцын талаар мэдээлэл өгөхийг прокуророос шаардаж болохгүй.

7. Прокурор бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад гаргасан алдааны улмаас учирсан хохирлыг төр хариуцна.

8. Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нар Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчтэй адил бүрэн эрхийн баталгаа, хангамжтай байна.

*32 дугаар зүйл.* Бусад баталгаа

1. Прокурор хуулиар тогтоосон үүрэгт нь хамааралгүй ажил албан тушаал хавсарч болохгүй. Харин багшлах болон эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэж болно.

2. Прокурор нь амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгөнд нь шууд тулгарсан гэмт халдлагын аюулаас хамгаалахын тулд бие хамгаалах тусгай хэрэгсэл хэрэглэх эрхтэй.

*33 дугаар зүйл.* Прокурорыг үл хүндэтгэгчид хүлээлгэх хариуцлага

Прокурорыг үл хүндэтгэгчид хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

## ТАВДУГААР БҮЛЭГ

### *Прокурорын байгууллагын боловсон хүчин*

*34 дүгээр зүйл.* Прокурор

1. Хууль зүйн дээд боловсролтой, мэргэшлийн шаардлага хангасан, ял шийтгэлгүй, Монгол Улсын иргэнийг прокуророор томилно.

2. Улсын ерөнхий прокурор, түүний орлогчоор хуулийн мэргэжлээр нийтдээ 10-аас доошгүй жил ажилласан, Монгол Улсын 35 нас хүрсэн иргэнийг томилно.

3. Аймаг, нийслэлийн прокуророор хуулийн мэргэжлээр нийтдээ 5-аас доошгүй жил ажилласан Монгол Улсын иргэнийг томилно.

*35 дугаар зүйл.* Прокурорын албан тушаалын бүрэлдэхүүн

1. Улсын ерөнхий прокурорын газарт Улсын ерөнхий прокурор, түүний орлогч, туслах прокурор болон хяналтын прокурор ажиллана. Туслах прокурор нь зохион байгуулалтын бүтцийн нэгж, албыг удирдаж болно.

2. Аймаг, нийслэлийн прокурорын газарт аймаг, нийслэлийн прокурор, түүний орлогч, туслах прокурор болон хяналтын прокурор ажиллана.

3. Сум, сум дундын буюу дүүргийн прокурорын газарт туслах болон хяналтын прокурор ажиллана.

*36 дугаар зүйл.* Прокурорын зэрэг дэв, бэлгэдэл, энгэрийн тэмдэг

1. Прокурор нь төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх, төрийн хууль цаазын шадар зөвлөх, хууль цаазын итгэмжит зөвлөх, хууль цаазын ахлах зөвлөх, хууль цаазын зөвлөхийн зэрэг дэвтэй байна.

2. Төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх, төрийн хууль цаазын шадар зөвлөхийн зэрэг дэвийг Ерөнхийлөгчийн зарлигаар, бусад зэрэг дэвийг Улсын ерөнхий прокурорын тушаалаар олгоно.

3. Зэрэг дэв олгохдоо албан тушаалын ангилал, ажилласан хугацаа, мэргэшлийн түвшинг харгалзана.

4. Прокурорын байгууллага бэлгэдэлтэй байна. Прокурор энгэрийн тэмдэг хэрэглэнэ.

5. Прокурорын зэрэг дэв олгох дүрэм, бэлгэдэл, энгэрийн тэмдгийн загвар, тэдгээрийг хэрэглэх журмыг Ерөнхийлөгч батална.

*37 дугаар зүйл.* Прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг шалгах

1. Прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг Улсын ерөнхий прокурор толгойлсон орон тооны бус мэргэжлийн зөвлөл шалгаж дүгнэнэ.

2. Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Ерөнхийлөгч батална.

*38 дугаар зүйл.* Прокурорыг ажлаас чөлөөлөх

Улсын ерөнхий прокурор дараах үндэслэлээр прокурорыг ажлаас чөлөөлнө:

1) өөрөө хүсэлт гаргасан;

2) өөрийнх нь зөвшөөрснөөр өөр ажил, албан тушаалд томилсон буюу сонгосон;

3) биеийн эрүүл мэндийн байдлаар үүргээ ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон;

4) насны тэтгэвэрт гарсан;

5) мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадварын хувьд эрхэлсэн ажилдаа тэнцэхгүй тухай мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт гарсан.

*39 дүгээр зүйл.* Сахилгын шийтгэл

1. Прокурор хууль болон байгууллагын дотоод журмыг зөрчсөн, прокурорын ёс зүйн хэм хэмжээ, хуульд заасан албан үүргээ үл биелүүлсэн бол тухайн зөрчлийн шинж байдлыг харгалзан Улсын ерөнхий прокурор дараах сахилгын шийтгэл оногдуулна:

1) сануулах;

2) албан тушаал бууруулах;

3) ажлаас халах

2. Прокурорын шийдвэр хүчингүй болсон буюу өөрчлөгдсөн нь түүний гэм буруугаас шалтгаалсан бол сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл болно.

3. Прокурорын сахилгын дүрмийг Ерөнхийлөгч батална.

4. Прокурор гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсноор Улсын ерөнхий прокурор түүнийг ажлаас нь хална.

*40 дүгээр зүйл.* Прокурорын байгууллагын боловсон хүчний сургалт

Прокурорын байгууллагын боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах ажлыг Засгийн газар эрхэлнэ.

*41 дүгээр зүйл.* Прокурорын газрын гүйцэтгэх болон техникийн ажилтан

Прокурорын газарт үйл ажиллагаагаа явуулахад нь шаардагдах [illegible] нөхцөлийг хангах үүрэг бүхий гүйцэтгэх болон техникийн ажилтан ажиллана.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ

### *Бусад зүйл*

*42 дугаар зүйл.* Прокурорын байгууллагын тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас

Прокурорын байгууллага тогтоосон журмаар үйлдсэн тамга тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

*45 дугаар зүйл.* Прокурорын байгууллагын хэвлэл, эрдэм шинжилгээний байгууллага

Прокурорын байгууллага хууль хамгаалах бусад байгууллагатай хамтарсан хэвлэл, сургалт-эрдэм шинжилгээний байгууллагатай байж болно.

| | |
|---|---|
| Монгол Улсын Их Хурлын дарга | **Н. БАГАБАНДИ** |
| Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга | **Н. РИНЧИНДОРЖ** |

| | |
|---|---|
| 1993 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр | Улаанбаатар хот |

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬ

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### *Нийтлэг үндэслэл*

*1 дүгээр зүйл.* Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Засгийн газрын (цаашид «Засгийн газар» гэх) үйл ажиллагааны зарчим, чиг үүрэг, бүрэн эрх, бүтэц, бүрэлдэхүүн, ажлын зохион байгуулалт, түүнчлэн Засгийн газраас бусад байгууллагатай харилцан ажиллах журмыг тогтоож, зохицуулахад оршино.

*2 дугаар зүйл.* Засгийн газрын тухай хууль тогтоомж

Засгийн газрын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

*3 дугаар зүйл.* Засгийн газар, түүний чиг үүрэг

1. Үндсэн хуулийн гучин наймдугаар зүйлд зааснаар Засгийн газар нь Монгол Улсын төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн.

2. Засгийн газар Монгол Улсын хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

*4 дүгээр зүйл.* Засгийн газрыг эмхлэн байгуулах үндэслэл, журам

1. Засгийн газрыг Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6, гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, гучин есдугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36, 37 дугаар зүйлд заасан үндэслэл, журмын дагуу эмхлэн байгуулна.

2. Засгийн газар огцрох, шинээр байгуулагдах, түүний гишүүнийг огцрох, чөлөөлөгдөх, шинээр томилогдох болон Засгийн газарт итгэл хүлээлгэх тухай асуудлыг Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6, гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 38, 39, 40, 41 дүгээр зүйл, энэ хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 22 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 2, 3, 4 дэх хэсэг, хорин долдугаар зүйлийн 6, 7

дахь хэсэгт заасан үндэслэл, журмын дагуу Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

*5 дугаар зүйл.* Засгийн газрын үйл ажиллагааны зарчим

1. Засгийн газрын үйл ажиллагааны үндсэн зарчим бол Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан ёсоор ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх явдал мөн.

2. Засгийн газар нь асуудлыг хамтран хэлэлцэж олонхийн санал бодолд түшиглэн цөөнхийн саналыг хүндэтгэн үзэж шийдвэрлэх, гаргасан шийдвэрийн биелэлтийг дангаар хариуцах, үйл ажиллагааныхаа талаар Улсын Их Хурлын өмнө хамтын хариуцлага хүлээх, нутаг дэвсгэрийн болон салбарын зарчмыг хослуулах үндсэн дээр ажиллана.

## ХОЕРДУГААР БҮЛЭГ

### *Засгийн газрын бүрэн эрх*

*6 дугаар зүйл.* Засгийн газрын бүрэн эрхийн үндэс, хугацаа

1. Засгийн газар нь Үндсэн хуулийн гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндсэн бүрэн эрхийн хүрээнд энэ хууль, бусад хуульд заасан тодорхой бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

2. Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа Үндсэн хуулийн дөчдүгээр зүйлд зааснаар тодорхойлогдоно. Харин Засгийн газар бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө огцорсон тохиолдолд шинээр байгуулагдсан Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа нь өмнөх Засгийн газрын бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна.

*7 дугаар зүйл.* Хуулийн биелэлтийг зохион байгуулж хангах талаархи Засгийн газрын бүрэн эрх

1. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас хуулийн биелэлтийг зохион байгуулж хангах арга замыг тодорхойлон уул ажлыг нэгтгэн удирдана.

2. Үндсэн хууль, бусад хуулийг биелүүлэх зорилгоор тогтоол, захирамж гаргаж биелэлтийг хангана.

3. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын шийдвэр хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд хяналт тавина.

4. Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, улсын үйлдвэрийн газар, байгууллага, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжид зохион шалгаж, шаардлагатай бол тэдгээрийн удирдлагын илтгэл, мэдээллийг хэлэлцэнэ.

5. Нам, олон нийтийн байгууллага, хувийн өмчийн аж ахуйн нэгж хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад хуулиар олгосон эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавина.

6. Шаардлагатай бол нам, олон нийтийн байгууллага, хувийн өмчийн аж ахуйн нэгжийн удирдлагын хүсэлтийг үндэслэн тэдгээрийн мэдээллийг хэлэлцэж болно.

7. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох арга хэмжээ авч, эрх зүйн мэдлэг олгох, сурталчлах, хууль тогтоомж тайлбарлан таниулах ажлыг зохион байгуулна.

8. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийн тухай Улсын Их Хуралд тогтмол мэдээлнэ.

*8 дугаар зүйл.* Эдийн засгийн хөгжил, шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх талаар Засгийн газрын бүрэн эрх

1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл (цаашид «Үндсэн чиглэл» гэх)-ийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

2. Улсын жилийн төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг Улсын Их Хурлаас баталсан Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд нийцүүлэн боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлнэ.

3. Үндсэн чиглэл, улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөний биелэлтийг хангах ажлыг төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаар дамжуулан зохион байгуулна.

4. Эдийн засгийн харилцаат аж ахуйн бүх хэвшлийн хөгжлийн сонирхолд нийцүүлэн зохицуулж, шударга өрсөлдөөнийг дэмжин дангаар ноёрхлыг хязгаарлах, эдийн засгийн тэнцвэрийг сайжруулах арга хэмжээ авна.

5. Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

6. Уугал хөмрөгийг бүрдүүлэх шинжлэх ухаан-техник, технологийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

7. Үндэсний баялаг, төрийн өмчийг хамгаалах арга хэмжээ авч, хуулиар олгосон эрх хэмжээний дотор төрийн өмчийн эд хөрөнгийг захиран зарцуулна.

*9 дүгээр зүйл.* Нийгмийн хөгжлийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх, хүн амын нийгмийн хамгааллын талаархи Засгийн газрын бүрэн эрх

1. Соёл, урлагийг өөрийн олон хэлбэрт түшиглэн хөгжүүлэх бодлого, түүний эдийн засаг, эрх зүйн баталгааг хангах арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлнэ.

2. Ард түмний оюуны өв, түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, уламжлалт зан заншлыг дэмжин хөгжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

3. Бүх шатны боловсролын тогтолцоо, агуулгын нэгдмэл бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

4. Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлнэ. Хуульд тогтоосны дагуу хүн амын эрүүл мэндийг хамгаалах ажилд улс, олон нийтийн байгууллага, иргэдийн хүчийг нэгтгэн зохион байгуулна.

5. Хүн амын бодлого, түүний дотор хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүд, ахмадуудын талаар төрөөс явуулах бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

6. Ажил эрхлэлт, мэргэжлийн сургалт, хөдөлмөрийн асуудлаар оновчтой бодлого боловсруулж хэрэгжүүлэх, иргэдийн хөдөлмөр, ахуй, орон сууцны нөхцлийг сайжруулах, хэрэглэгчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах арга хэмжээ авна.

7. Гэр бүлийг бэхжүүлэх, нийгмийн халамж, нийгмийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох, эх нялхас, тахир дутуу хүмүүс зэрэг нийгмийн эмзэг хэсгийн эрх ашгийг хамгаалах арга хэмжээ авна.

*10 дугаар зүйл.* Салбар, салбар хоорондын болон бүс нутгийн хөгжлийг хангах талаархи Засгийн газрын бүрэн эрх

1. Эдийн засгийн тэргүүлэх чиглэл, салбарыг тодорхойлж, салбар, дэд бүтцийн зохистой харьцааг тогтоон хөгжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

2. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн нийтлэг чиглэлийг шийдвэрлэхэд эдийн засгийн салбаруудын хүч чармайлтыг нэгтгэн чиглүүлж, салбар хоорондын харилцааг зохицуулна.

3. Аймаг, бүс нутгийн харьцангуй жигд хөгжлийг хангах, тэдгээрийн хооронд эдийн засгийн зөв зохистой харилцаа холбоо тогтоон бэхжүүлэх нийтлэг зарчим, журам боловсруулан хэрэгжүүлж, энэ талаар нутгийн өөрөө удирдах байгууллагуудад шаардлагатай туслалцаа үзүүлнэ.

4. Орон нутгийн байгууллага, аж ахуйн нэгжийн бие даасан байдлыг улс орны хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын нийтлэг ашиг сонирхолтой уялдуулан зохицуулна.

*11 дүгээр зүйл.* Хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах талаархи Засгийн газрын бүрэн эрх

1. Байгаль, орчныг хамгаалах эдийн засаг, эрх зүй, зохион байгуулалтын тогтолцоо бүрдүүлж, энэ хүрээн дэх Засгийн газрын болон Засгийн газрын бус (олон нийтийн) байгууллагын үйл ажиллагааг зохицуулна.

2. Байгалийн баялгийг судлах, нөөцийн хэмжээ, эдийн засгийн үнэлгээг тогтоох, хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, экологийн аюулгүй байдлыг хангах, байгаль орчны тэнцвэрт байдал болон үндэсний нийгэм, эдийн засгийн хөгжлийн шаардлагыг хангасан арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлнэ.

3. Байгалийн тэнцвэрт байдлын хяналтын нэгдсэн тогтолцоог бий болгоно.

4. Байгалийн аюул гамшиг, орчны ноцтой бохирдлоос сэргийлэх, тэдгээрээс учирсан хор уршгийг арилгахад улс, олон нийтийн байгууллага, иргэдийн хүчийг нэгтгэн зохион байгуулж, шаардлагатай арга хэмжээ авна.

5. Газар, түүний хэвлий, ус, ойн сан, агаар мандал, ургамал, амьтны аймгийг хамгаалах, зүй зохистой ашиглах төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

6. Улсын тусгай хамгаалалттай газрын хилийн цэс, хамгаалалтын горимыг тогтоож, биелэлтийг нь зохион байгуулна.

*12 дугаар зүйл.* Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх талаархи Засгийн газрын бүрэн эрх

1. Аппаратыг чадваржуулан хямдруулж боловсронгуй болгох шаардлагад нийцүүлэн төрийн захиргааны байгууллагын

тогтолцоо, бүтэц, ерөнхий бүдүүвч боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, энэ талаар гаргасан шийдвэрийг хэрэгжүүлнэ.

2. Төрийн албаны ажилтан бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, дахин мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

3. Захиргааны хяналт, удирдлагын хүрээн дэх хяналт шалгалтыг улсын хэмжээнд зохион байгуулна.

4. Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн захиргааны төв байгууллагын зохион байгуулалтын бүтцийг тогтоох, тэдгээрийн орон тоо, зардлын төсвийн хязгаар, цалингийн санг батлаж зохих шатны удирдах ажилтныг томилж, чөлөөлнө.

5. Төрийн захиргааны төв байгууллагуудын хоорондын болон тэдгээр байгууллага, аймаг, нийслэлийн захиргааны байгууллагын харилцан ажиллагааг нийтлэг зорилтод чиглүүлэн зохицуулна.

6. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн байгууламжийг боловсронгуй болгох шаардлагатай арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлж, нутгийн өөрөө удирдах байгууллагуудаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалтын болон аргачилсан туслалцаа үзүүлж, тэдгээрийн бие даасан ажиллагааг хангах арга хэмжээ авна.

7. Аймаг, нийслэлийн Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа байдлыг хянан шалгаж, тэдгээрийн үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангана. Шаардлагатай бол өөрийн тодорхой бүрэн эрхэд хамаарах тухайлсан асуудлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд шийдвэрлүүлэхээр аймаг, нийслэлийн Засаг даргад шилжүүлж болно.

*13 дугаар зүйл.* Улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангах талаархи Засгийн газрын бүрэн эрх

1. Улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангах болон цэргийн бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

2. Зэвсэгт хүчнийг бэхжүүлэх арга хэмжээ авна.

3. Улсын хилийг хамгаалах ажлыг чиглүүлэн удирдана.

4. Улсын аюулгүй байдлыг хангах арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлнэ.

5. Улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангахад зайлшгүй шаардагдах материаллаг нөөцийн санг бүрдүүлэх, нөхөн сэлбэх арга хэмжээ авна.

6. Төрийн нууцыг хамгаалах ажлыг чиглүүлэн удирдана.

7. Хүн амыг байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, түүний хор уршгийг арилгах арга хэмжээ авч, иргэний хамгаалалтын ажлыг удирдан зохион байгуулна.

*14 дүгээр зүйл.* Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх талаарх Засгийн газрын бүрэн эрх

1. Хүний эрх, эрх чөлөөг хангах эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон шаардлагатай бусад баталгааг бүрдүүлэх, бэхжүүлэх арга хэмжээ авна.

2. Хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх талаар хуульд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3. Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах асуудлаар Засгийн газрын бус байгууллага, олон улсын байгууллагатай хамтарч ажиллана.

4. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авах, хянан шийдвэрлэх ажлыг нэгтгэн удирдана.

5. Хүн амд үзүүлэх хууль зүй, засаг захиргааны үйлчилгээг зохион байгуулна.

6. Төрийн удирдлагын хүрээн дэх мэдээллийн албыг зохион байгуулж, хүн амыг үнэн зөв мэдээллээр хангах нөхцөл бүрдүүлнэ.

7. Нийгмийн хэв журмыг сахин хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

*15 дугаар зүйл.* Төрийн гадаад бодлого хэрэгжүүлэх талаарх Засгийн газрын бүрэн эрх

1. Улс төр, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, хүмүүнлэгийн талаар төрийн гадаад бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

2. Гадаад улсыг хүлээн зөвшөөрөх, гадаад улстай дипломат харилцаа тогтоох, цуцлах саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлнэ.

3. Монгол Улсаас гадаад улс, олон улсын байгууллагад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрыг Улсын Их Хурлын холбогдох шийдвэрийг үндэслэн байгуулах, татан буулгах асуудлыг шийдвэрлэж, тэдгээр байгууллагын бүтэц, орон тоог батлаж, ажилтны цалингийн дундаж нормыг тогтооно.

4. Монгол Улсаас гадаад улс, олон улсын байгууллагад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох, эгүүлэн татах саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.

5. Гадаад улс, олон улсын байгууллагад суух Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох, эгүүлэн татах асуудлыг шийдвэрлэнэ.

6. Нэгдсэн Үндэстний Байгууллага болон Засгийн газар хоорондын олон улсын байгууллагад өөрийн эрх хэмжээний дотор Монгол Улсыг төлөөлнө.

*16 дугаар зүйл.* Гадаад улстай гэрээ, хэлэлцээр байгуулах талаархи Засгийн газрын бүрэн эрх

1. Улсын Их Хуралтай зөвшилцсөний дараа соёрхон батлуулахаар Монгол Улсын өмнөөс олон улсын гэрээ байгуулна.

2. Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батлах, цуцлах, Монгол Улс олон улсын гэрээнд нэгдэн орох тухай саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

3. Өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар гадаад улс, олон улсын байгууллагатай гэрээ, хэлэлцээр байгуулах, цуцлах асуудлыг шийдвэрлэнэ.

4. Байгууллага хоорондын шинжтэй Монгол Улсын олон улсын гэрээний хэлэлцээ хийх болон гэрээнд үсэг зурах журам боловсруулж хэрэгжүүлнэ.

5. Олон улсын гэрээгээр Монголын талын хүлээсэн үүргийн биелэлтийг хянан шалгаж, зохион байгуулна.

6. Олон улсын гэрээнээс үүсэн гарсан асуудлаар Монголын талын эрх, ашиг сонирхлыг хамгаалах арга хэмжээ авна.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### *Засгийн газрын бүтэц*

*17 дугаар зүйл.* Засгийн газрын үндсэн болон дэд бүтэц

1. Засгийн газрын үндсэн бүтцэд Монгол Улсын яам орно. Улсын Их Хурал амьдралын чухал шаардлагыг харгалзан Монгол Улсын тусгай газар (улсын хороо, ерөнхий газар зэрэг)-ыг байгуулж Засгийн газрын үндсэн бүтцэд оруулж болно.

2. Шаардлагатай бол Монгол Улсын сайдын эрхлэх асуудлын хүрээнд үйлдвэрлэлийн зарим салаа мөчрийг улсын хэмжээнд зохицуулах эрх, үүрэг бүхий газрыг Улсын Их Хурлаас батал-

сан бүдүүвчийн дагуу Засгийн газар байгуулан ажиллуулж болно. Ийм газар нь Засгийн газрын дэд бүтцэд хамаарах бөгөөд түүний удирдлагыг Засгийн газрын шийдвэрээр томилж, чөлөөлнө.

*18 дугаар зүйл.* Монгол Улсын яам, тусгай газар

1. Монгол Улсын яам, Засгийн газрын үндсэн бүтцэд орох тусгай газар нь Засгийн газрын үйл ажиллагааны тодорхой хүрээ, салбарыг дагнан эрхлэн төрийн захиргааны төв байгууллага мөн бөгөөд хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулж эрхэлсэн хүрээ буюу салбарын хэмжээнд ажлынхаа үр дүнг Засгийн газар, түүгээр уламжлан Улсын Их Хуралд хариуцна.

2. Монгол Улсын яам, Засгийн газрын үндсэн бүтцэд орох тусгай газрыг түүний чиг үүрэг буюу эрхлэх ажил, бүтэц, орон тоо, зардлын төсвийг урьдчилан боловсруулж Ерөнхий сайдын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хэлэлцэж хуулиар байгуулна.

3. Засгийн газрын бүтцэд дор дурдсан яам ажиллана:

1) Монгол Улсын Байгаль орчны яам
2) Монгол Улсын Барилга, хот байгуулалтын яам
3) Монгол Улсын Батлан хамгаалах яам
4) Монгол Улсын Гадаад харилцааны яам
5) Монгол Улсын Геологи, эрдэс баялгийн яам
6) Монгол Улсын Зам, тээвэр, холбооны яам
7) Монгол Улсын Сангийн яам
8) Монгол Улсын Соёлын яам
9) Монгол Улсын Түлш, эрчим хүчний яам
10) Монгол Улсын Худалдаа, үйлдвэрийн яам
11) Монгол Улсын Хууль зүйн яам
12) Монгол Улсын Хүн амын бодлого, хөдөлмөрийн яам
13) Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуйн яам
14) Монгол Улсын Шинжлэх ухаан, боловсролын яам
15) Монгол Улсын Эрүүл мэндийн яам.

4. Засгийн газрын үндсэн бүтцэд дор дурдсан тусгай газар ажиллана:

1) Монгол Улсын Аюулгүй байдлыг хангах ерөнхий газар
2) Монгол Улсын Статистикийн газар
3) Монгол Улсын Үндэсний хөгжлийн газар
4) Монгол Улсын Цагдаагийн ерөнхий газар
5) Монгол Улсын Радио, телевизийн хэрэг эрхлэх газар

5. Монгол Улсын яам (цаашид «яам» гэнэ)-ыг Засгийн газрын гишүүн—Монгол Улсын сайд тэргүүлж удирдах бөгөөд тэр нь тухайн яамны эрхлэх асуудлаар бодлого боловсруулж хэрэгжүүлэх ажлыг мэргэшлийн үндсэн дээр хариуцсан дэд сайдтай байж болно.

6. Засгийн газрын үндсэн бүтцэд ордог тусгай газар (цаашид «тусгай газар» гэнэ)-ыг Засгийн газраас томилсон дарга тэргүүлж удирдана. Ажлын онцгой шаардлагыг харгалзан тусгай газрын даргыг Засгийн газрын бүрэлдэхүүнд оруулах бол Улсын Их Хурал түүнийг Монгол Улсын сайдаар томилно. Энэ тохиолдолд тэр нь Засгийн газрын бусад гишүүний эрхэлдэггүй тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд тухайн газрынхаа эрхлэх асуудлаар бодлого боловсруулж хэрэгжүүлэх ажлыг мэргэшлийн үндсэн дээр хариуцсан дэд даргатай байж болно. Бусад тусгай газар нь хуулиар, эсхүл Ерөнхий сайдын тогтоосон хуваарийн дагуу Ерөнхий сайд буюу Засгийн газрын аль нэг гишүүний эрхлэх асуудлын хүрээнд ажиллана.

7. Яам, тусгай газрын эрх зүйн байдлыг хуулиар тодорхойлно.

*19 дүгээр зүйл.* Төрийн гүйцэтгэх байгууллагын зарим чиг үүргийг бусад байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлэх

1. Засгийн газар нь төрийн зохицуулалт, мэдээлэл, шинжилгээ, судалгааны зэрэг төрийн гүйцэтгэх байгууллагын тусгай чиг үүрэг буюу дэд салбарын тодорхой чиг үүргийг холбогдох хууль түүнд үндэслэсэн Засгийн газрын шийдвэр, гэрээний үндсэн дээр Засгийн газрын бус агентлаг, түүнтэй адилсах бусад байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг санхүүжүүлж болно.

2. Төрийн гүйцэтгэх байгууллагын тусгай чиг үүрэг буюу дэд салбарын тодорхой чиг үүргийг эрхлэн гүйцэтгэж, тэр тухайдаа улсын төсвөөс санхүүжиж байгаа байгууллага нь Засгийн газрын шийдвэрийг биелүүлж, үг ажлаа Монгол Улсын холбогдох сайд (Засгийн газрын гишүүн) улмаар Засгийн газрын өмнө шууд хариуцна.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### *Засгийн газрын бүрэлдэхүүн*

*20 дугаар зүйл.* Засгийн газрын бүрэлдэхүүн

1. Үндсэн хуулийн гучин есдүгээр зүйлд заасан ёсоор Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ.

2. Засгийн газрын гишүүн нь Монгол Улсын сайд байна.

3. Ерөнхий сайд болон сайд нарын эрхлэх үйл ажиллагааны үндсэн хүрээг энэ хуулиар тогтооно.

4. Монгол Улсын сайд Засгийн газрын гишүүний хувьд доор дурдсан хүрээний удирдлага, зохицуулалт, улсын хяналт шалгалтын асуудлыг эрхэлнэ:

1) Байгаль орчны сайд:

— байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх болон экологийн бодлого; газар, түүний хэвлийн баялаг, ой, ус, ан амьтан, ургамлын нөөцийн мэдээллийн сангийн бүрдүүлэлт; газар зохион байгуулалтын удирдлага; ус, цаг уур, уур амьсгал, байгаль орчны талаарх мэдээлэл; байгалийн болзошгүй гамшгаас хүн амыг сэргийлэх арга хэмжээ; байгалийн аялал, жуулчлалд тавих хяналт;

2) Барилга, хот байгуулалтын сайд:

— барилга, архитектур, хот байгуулалт; барилга, барилгын материалын үйлдвэрлэл; геодези, зураг төслийн бодлого; барилга-техникийн улсын хяналт;

3) Батлан хамгаалахын сайд:

— улсыг батлан хамгаалах, цэргийн бодлого; зэвсэгт хүчин, иргэний хамгаалалт;

4) Гадаад харилцааны сайд:

— төрийн гадаад бодлого; гадаад улс, олон улсын байгууллагатай улс төр, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, техник, хүмүүнлэгийн хамтын ажиллагаа;

5) Геологи, эрдсийн баялгийн сайд:

— геологийн судалгаа, ашигт малтмалын эрэл, хайгуул; эрдсийн баялгийн хамгаалалт, олборлолт, уул уурхай, металлургийн үйлдвэрийг хөгжүүлэх бодлого; эрдэс, түүхий эдийн бааз, түүний ашиглалт;

6) Зам, тээвэр, холбооны сайд:

— зам, тээвэр, холбоог хөгжүүлэх бодлого; бүх төрлийн тээвэр, харилцаа, холбооны үйлчилгээ;

7) Сангийн сайд:

— санхүү, төсөв, татвар, улсын даатгал, гаалийн талаар төрөөс явуулах бодлого; төрийн өмчийн хамгаалалт; бүртгэл, санхүүгийн хяналт шалгалт; нэгдсэн бодох бүртгэлийн арга зүй; улсын гадаад төлбөрийн тэнцэл; гадаад орны болон олон улсын санхүүгийн байгууллагатай харилцах асуудал; Засгийн газраас Монголбанктай хамтран явуулах бодлого;

8) Соёлын сайд:

— түүх, соёлын өвийг хамгаалах, сэргээх, соёл, урлагийг хөгжүүлэх бодлого; хэвлэлийн үйлдвэрлэл; төрөөс сүм хийдтэй харилцах харилцаа;

9) Түлш, эрчим хүчний сайд:

— эрчим хүчний нэгдсэн бодлого; түлш, эрчим хүчний үйлдвэрлэл; улс орны цахилгаанжуулалт;

10) Худалдаа, үйлдвэрийн сайд:

— улс орны үйлдвэр, худалдаа, үйлчилгээний уялдаа; дотоод, гадаад худалдаа, зах зээлийн тэнцвэрт байдал; материалын баялгийн улсын нөөцийн бүрдүүлэлт, хуваарилалт; аялал жуулчлал; гадаад эдийн засгийн хамтын ажиллагааны болон гадаадын хөрөнгө оруулалтын бодлогын хэрэгжилт;

11) Хууль зүйн сайд:

— эрх зүйн бодлого; хууль тогтоомжийн төсөл боловсруулалтын арга зүй, хууль тогтоомжийн системчлэл, мэдээлэл, эрх зүйн сургалт, сурталчилгаа; хууль зүйн туслалцаа; төрийн захиргааны байгууллагын шийдвэрийн хууль зүйн үндэслэлд тавих хяналт; хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн байгууллагын бүртгэл; иргэний харьяалал, цагаачлал, цагдаа, мөрдөн байцаах, нотариат, улсын архив, хорих ял эдлүүлэх байгууллагын болон гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг уялдуулах; Засгийн газраас шүүх, прокурорын байгууллага болон өмгөөлөгчдийн олон нийтийн байгууллагатай харилцах асуудал;

12) Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд:

— хүн ам, хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн сургалт, нийгмийн даатгал, нийгмийн халамжийн талаар төрөөс явуулах бодлого, хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн хууль тогтоомжийн улсын хяналт; хөдөлмөрийн харилцаанд эзэд, үйлдвэрчний эвлэлийн байгууллагын хоорондын харилцааны зохицуулалт;

13) Хүнс, хөдөө аж ахуйн сайд:

— мал аж ахуй, газар тариалан, усжуулалт, хүнсний бодлого; хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл; ургамлын хорио, цээр, мал эмнэлэг, үржлийн алба;

хөдөө аж ахуйн эдэлбэр газрын ашиглалт-үйлдвэрлэлийн технологийн бодлого;

14) Шинжлэх ухаан, боловсролын сайд:

— шинжлэх ухаан, технологи, бүх шатны боловсролыг хөгжүүлэх бодлого; шинжлэх ухаан, технологийн мэдээлэл;

15) Эрүүл мэндийн сайд:

— хүн амын эрүүл мэндийг хамгаалах нийгмийн болон мэргэжлийн арга хэмжээ; эм, эмнэлгийн хэрэгсэл, техникийн үйлдвэрлэл, хангамж; эрүүл ахуй, халдвар судлал; эмнэлгийн үйлчилгээний улсын хяналт; биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлого;

16) Монгол Улсын сайд бөгөөд Үндэсний хөгжлийн газрын дарга:

— Монгол Улсын үндэсний хөгжлийн үзэл баримтлал, засгийн бодлого, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, эдийн засгийн аюулгүй байдал, тэнцвэрт харьцааг хангах макро эдийн засгийн зохицуулалт; хөрөнгө оруулалт, технологи, салбар, салбар хоорондын болон бүс нутгийн хөгжлийн бодлого; эдийн засгийн гадаад хамтын ажиллагаа; патент, улсын статистик, стандартчилал, хэмжил зүй.

5. Улс орны амьдралын чухал асуудлыг дагнан эрхлүүлэх, Засгийн газрын шуурхай үйл ажиллагааг хангахад зайлшгүй шаардлагатай бол Ерөнхий сайдын саналаар Улсын Их Хурал шадар сайд (яамгүй) томилж Засгийн газрын бүрэлдэхүүнд оруулж болно.

6. Ерөнхий сайдыг түр эзгүйд түүний үүргийг шадар сайдын аль нэг нь орлон гүйцэтгэж хариуцлагыг бүрэн хүлээнэ.

7. Ерөнхий сайд, шадар сайд нар нэгэн зэрэг түр эзгүй байх тохиолдолд Ерөнхий сайдын даалгавраар түүний үүргийг аль нэг сайд хариуцна.

*21 дүгээр зүйл.* Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний бүрэн эрхийн хугацаа

1. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний бүрэн эрхийн хугацаа нь Үндсэн хуулийн дөчдүгээр зүйлд заасан Засгийн газрын бүрэн эрхийн хугацаатай адил байх бөгөөд энэ нь Улсын Их Хурал тэдгээрийг томилсноор эхэлж, Ерөнхий сайд болон Засгийн газрын тухайн гишүүнийг шинээр томилсноор дуусгавар болно.

2. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн хуульд заасан үндэслэлээр албан тушаалаас огцорсон, чөлөөлөгдсөн, түүнчлэн

нас нөхсөн тохиолдолд түүний бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болно. Ийнхүү Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн орон гарсан тохиолдолд Улсын Их Хурал 30 хоногийн дотор түүнийг нөхөн томилно. Нөхөн томилогдсон гишүүний бүрэн эрхийн хугацаа нь тухайн Засгийн газрын бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна.

3. Ерөнхий сайдын бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болсон тохиолдолд Ерөнхий сайдыг шинээр томилох хүртэл түүний үүргийг энэ хуулийн 20 дугаар зүйлийн 6, 7 дахь хэсэгт зааснаар орлон гүйцэтгэнэ.

4. Засгийн газрын орон гарсан гишүүнийг нөхөн томилох хүртэл Ерөнхий сайд түүний үүргийг өөрөө гүйцэтгэж, эсхүл Засгийн газрын нэг буюу хэд хэдэн гишүүнд хуваарилан гүйцэтгүүлж болно.

5. Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээр огцорсон нь уул бүрэлдэхүүнээс албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэж ирсэн хүнийг Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээр дахин томилоход саад болохгүй.

*22 дугаар зүйл.* Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн өөрийн хүсэлтээр албан тушаалаас чөлөөлөгдөх, огцрох үндэслэл

1. Биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсноос албан тушаалаас чөлөөлж өгөх тухай хүсэлтээ Ерөнхий сайд Улсын Их Хуралд, Засгийн газрын гишүүн нь Ерөнхий сайдад тус тус өргөн мэдүүлж болно.

2. Ерөнхий сайд хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, Засгийн газарт чиглэл өгөх тухай Ерөнхийлөгчийн зарлигийн хэсгийн талаар зарчмын өөр саналтай бөгөөд уул саналыг Улсын Их Хурал буюу Ерөнхийлөгч хүлээн аваагүйгээс Засгийн газар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, Улсын Их Хурал итгэл хүлээлгээгүй, хөтөлбөрөө Улсын Их Хурлаар хэлэлцүүлснээс хойш 30 хоногийн дотор батлуулж чадаагүй, түүнчлэн хуульд заасан бусад үндэслэл байна гэж үзвэл албан тушаалаас буюу Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ огцрох тухай хүсэлтийг Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно.

3. Засгийн газрын гишүүн өөрийн эрхэлсэн асуудлын хүрээний бодлогын асуудлаар Ерөнхий сайдтай, эсхүл гишүүдийн олонхитой санал зөрсөн учраас бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, түүнчлэн хуульд заасан бусад үндэслэл байна

гэж үзвэл албан тушаалаасаа огцрох хүсэлтээ Ерөнхий сайдад хэдийд ч гаргаж болно. Харин энэ тухай эцсийн шийдвэр гартал үүргээ ажлаа гүйцэтгэж, хариуцлагыг хүлээнэ.

*23 дугаар зүйл.* Ерөнхий сайдын бүрэн эрх

1. Ерөнхий сайд Үндсэн хуулийн дөчин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан ёсоор Засгийн газрыг удирдаж, төрийн хуулийг биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна. Түүний дотор:

1) Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, Засгийн газрын гишүүнийг томилох, албан тушаалаас чөлөөлөх, огцруулах тухай саналаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ;

2) хууль болон Улсын Их Хурлаас баталсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлийн дагуу Засгийн газрын дотоод, гадаад бодлогыг тодорхойлно;

3) Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын үйл ажиллагааг чиглүүлж удирдана;

4) Засгийн газрын үйл ажиллагааны тухай Улсын Их Хурлын чуулганд мэдээлж, авах арга хэмжээний тухай саналаа өргөн мэдүүлнэ;

5) энэ хуулиар тогтоосон үндсэн хүрээнд Засгийн газрын гишүүдийн эрхлэх ажлыг тодруулан хуваарилж, түүний гүйцэтгэлд хяналт тавина. Шаардлагатай бол тодорхой нэмэлт ажил үүрэг хариуцуулж болно. Харин энэ хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан Монгол Улсын сайд нарын эрхлэх асуудлыг нэгээс нөгөөд шилжүүлэх, нэг орон тоонд нэгтгэх, нэгийг олон тоонд тусгаарлан хариуцуулах зэрэг өөрчлөлт оруулах бол энэ тухай саналаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлж шийдвэрлүүлсний үндсэн дээр гүйцэтгэнэ;

6) Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тодорхойлж хуралдааныг товлож, даргална;

7) дотоод, гадаад харилцаанд Засгийн газрыг төлөөлнө;

8) хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

2. Ерөнхий сайд нь Засгийн газрын үйл ажиллагааны ерөнхий асуудлуудын зэрэгцээ улсын аюулгүй байдал, улсын радио телевиз, нутгийн захиргааны зэрэг хүрээн дэх тусгай газар албадыг удирдан зохицуулах асуудлыг тодруулан эрхэлж болно.

3. Ерөнхий сайд Засгийн газрын дотоод, гадаад бодлогын асуудлаар хэлэлцээ хийхдээ Засгийн газрын гишүүд, түүний дотор уг асуудлыг эрхэлсэн гишүүнтэй санал солилцсон буюу

баримтлах бодлогын үндсэн чиглэлийг урьдчилан мэдэгдсэн байвал зохино.

*24 дүгээр зүйл.* Засгийн газрын гишүүний бүрэн эрх

1. Засгийн газрын гишүүн энэ хууль болон хууль тогтоомжийн бусад заалтаар олгосон бүрэн эрхтэй. Түүний дотор:

1) эрхэлсэн асуудлынхаа хүрээнд төрийн бодлогыг боловсруулж, хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэх ажлыг Засгийн газрын өмнөөс эрхлэн гүйцэтгэж, зохих хүрээ, салбарын төвшинд, ажил хэргийн байдал, үр дүнг Ерөнхий сайд, улмаар Улсын Их Хурлын өмнө дангаар, харин Засгийн газрын үйл ажиллагааны талаар хамтын хариуцлага тус тус хүлээнэ;

2) эрхэлсэн асуудлын хүрээн дэх яам, тусгай газар болон энэ хуулийн 17 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан байгууллагын үйл ажиллагааг шууд удирдана;

3) Засгийн газрын хуралдаанд тогтмол оролцон санал бодлоо чөлөөтэй илэрхийлнэ;

4) хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тэргүүлж буй яам, тусгай газрынхаа шууд харьяа төрийн өмчийн байгууллагын дүрэм, удирдлагын орон тоо, цалингийн санг баталж, дарга (эрхлэгч, захирал)-ыг томилж, чөлөөлнө;

5) эрхэлсэн асуудлаараа Улсын Их Хурлын Байнгын хороод, ажлын бусад байгууллагатай шууд харилцаж, Улсын Их Хурлын чуулган, Байнгын хорооны хуралдаанд өөрийн байр суурийг илэрхийлнэ;

6) хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар болон өөрийн шийдвэрийн биелэлтийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгжид шалгаж танилцаж, биелэлтийг нь бүрэн хангах талаар шуурхай даалгавар өгч гүйцэтгүүлнэ;

7) эрхэлсэн асуудлаараа өөрийн бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрыг төлөөлж аль ч байгууллагад чөлөөтэй нэвтэрч холбогдох ажилтантай хүлээгдэлгүй уулзаж болно;

8) хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

2. Монгол Улсын сайд эрх хэмжээнийхээ асуудлаар хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, тэдгээрийг батлан гаргасан бусад шийдвэрт нийцүүлэн тушаал гаргаж, биелэлтийг хангана.

Хэрэв эрхэлсэн асуудлынхаа хүрээнд шийдвэрлэх гэж байгаа асуудал нь бусад хүрээнийхэнтэй шууд холбоотой бол Засгийн газрын холбогдох гишүүдтэй урьдчилан тохиролцож зохи-

цуулсан байвал зохино. Энэ талаар гарсан саналын зөрөөг нөрсдөө зохицуулж чадлагүй тохиолдолд хуульд өөрөөр заагаагүй бол Ерөнхий сайд шууд буюу шаардлагатай бол Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэний үндсэн дээр шийдвэрлэнэ.

3. Засгийн газрын гишүүн нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэх, төрийн нэгтгэлтийн ёс зүйн хам хамжиж чанд сахих, төрийн болон албаны нууцыг хадгалах үүрэгтэй.

4. Засгийн газрын гишүүн шийдвэр, мэдэгдэл гаргах, аливаа хэлбэрээр албан ёсны байр суурь илэрхийлэхдээ Ерөнхий сайдын бодлогыг баримтална. Хэрэв эрхэлсэн асуудлынхаа хүрээнд Ерөнхий сайдын бодлогыг зарчмын хувьд өөрчлөх шаардлагатай гэж үзвэл энэ тухай зохих шийдвэрийн төсөл боловсруулж Ерөнхий сайдад уламжлан шийдвэрлүүлнэ.

5. Засгийн газрын гишүүн нэг хоногоос дээш хугацаагаар гадагш явбал Ерөнхий сайдаас зөвшөөрөл авах бөгөөд очих, холбоо барих хаягаа мэдэгдэнэ.

6. Засгийн газрын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд хуулиар тогтоосон болон Ерөнхий сайдаас хуваарилан хариуцуулсан үүрэгт нь үл хамаарах цалинтай ажил хавсарч болохгүй.

7. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн хамтарсан болон дагнасан хувийн үйлдвэр, аж ахуйн бусад нэгжийн үйл ажиллагаа эрхлэдэг бол бүрэн эрхийнхээ хугацаанд уул нэгжийн ажлыг эрхлэн удирдаж болохгүй.

8. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн өөрийн хувийн аж ахуй болон өмч эзэмшилтэй нь холбоотойгоор орсон орлогыг жил бүр, албан үйл ажиллагаатай нь холбогдуулан бусдаас өгсөн сарын цалингаас илүү үнэтэй бэлгийн талаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тухай бүр мэдэгдэнэ.

*25 дугаар зүйл.* Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэх баталгаа

1. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь төр, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгж, тэдгээрийн албан тушаалтан, иргэд туслалцаа үзүүлэх, гаргасан хууль ёсны шийдвэр, шуурхай даалгаврыг нь биелүүлэх үүрэгтэй.

2. Ерөнхий сайд бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ дараахь баталгаагаар хангагдана:

1) түүний бие, нэр төр, унаа, зориулалтын орон сууц халдашгүй дархан байна;

2) нийслэл болон түүний орчмын газарт өвөл, зуны зориулалтын орон сууцтай байна;

3) албан ёсны болон амралтын айлчлал, төрийн ёслол хүндэтгэлийн болон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон бусад арга хэмжээ, зориулалтын онгоц, зуны орон сууцны зардал, үйлчилгээг улсын төсвөөс санхүүжүүлнэ. Түүний цалин, жилийн зардлын хэмжээг Засгийн газрын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтооно;

4) тусгай зориулалтын унаага болон холбоогоор хангагдана;

5) албан үүргээ хэрэгжүүлэх талаар зөвлөлгөө туслалцаа авч, шуурхай ажил гүйцэтгүүлэх болон хэвлэл, мэдээллийн алба (аппарат)-тай байна.

6) түүнийг Улсын Их Хурлын зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хариуцлагад татах, баривчлах, албадан саатуулах буюу цагдан хорих, шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, бие, орон сууц, албан тасалгаа, унаагад нь халдах, үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно;

7) түүний амь бие, орон сууц, унаага, холбооны хэрэгсэл улсын хамгаалалтад байх бөгөөд эхнэр (нөхөр), насанд хүрээгүй хүүхдийг нь шаардлагатай үед улсын хамгаалалтад авна;

8) түүний эрүүл мэндийг онцлон хамгаална;

9) бүрэн эрхийнхээ хугацаа дууссанаас эхлэн нэгэн бүрэн эрхийнхээс илүүгүй хугацаагаар Улсын Их Хурлаас тогтоосон хангамж эдэлж, улсын хамгаалалтад байна.

2. Засгийн газрын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ дараахь баталгаагаар хангагдана:

1) унаага, холбооны хэрэгслээр хангагдана;

2) төрийн өндөр албан тушаалтны зэрэг дэвд тохируулан Улсын Их Хурлаас тогтоосон цалин, зайлшгүй шаардлагатай бусад хангамж авах буюу эдлэх;

3) гадаадад байх, зорчих хугацаанд дипломат эрх ямба, дархан эрх эдэлнэ;

4) түүнийг гэмт хэрэг үйлдэж байхад нь буюу хэргийн газарт гэмт үйлдлийнх нь нотлох баримттайгаар баривчилсан бол энэ тухай Ерөнхий сайдад 24 цагийн дотор мэдэгдэнэ. Үүнээс бусад тохиолдолд Засгийн газрын гишүүнийг Ерөнхий сайдын зөвшөөрөлгүйгээр цагдан хорих, түүнд шүүхийн журмаар захиргааны шийтгэл оногдуулах, гэр орон, унаага, албан тасалгаа, биед нь үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно;

5) гэмт хэрэг үйлдэж огцорсноос бусад үндэслэлээр бүрэн эрхийн нь хугацаа дуусгавар болоход түүнийг Засгийн газрын гишүүнээр томилогдохоос өмнө ажилд нь эргүүлэн ажиллуулах

буюу хийж болохгүй бол тухайн эрх авцуулахын түүнийг нэ-буурулаагүй байх шийдвэрийг Улсын Их Хурал авна.

3. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд бүрэн эрхийнхээ хугацаанд албан үүргээс бусад улс, олон нийтийн албан дайчилгаанаас чөлөөлөгдөнө.

4. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон захидал харилцааны нууцыг задруулахыг хориглоно.

5. Хуулиар өөр баталгаа тогтоож болно.

## ТАВДУГААР БҮЛЭГ

*Засгийн газраас Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, бусад байгууллагатай харилцах*

*26 дугаар зүйл. Засгийн газраас Улсын Их Хуралтай харилцах*

1. Засгийн газар нь Улсын Их Хурлын итгэлийг хүлээсэн байвал зохино.

2. Засгийн газрын үйл ажиллагааны талаархи олон нийтийн санал болох, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн байр суурийг харгалзан шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Засгийн газар өөрт нь итгэл хүлээлгэж байгаа эсэхийг илэрхийлж өгөхийг хүсч холбогдох тогтоолын төслийг Ерөнхий сайд Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

3. Итгэл хүлээлгэж байгаа эсэх тухай тогтоолын төсөл, түүнчлэн Засгийн газар огцрох тухайгаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр Ерөнхий сайдын боловсруулсан тогтоолын төслийг Засгийн газрын гишүүдийн гуравны хоёроос доошгүйн ирцтэй хуралдаанаар хэлэлцсэн байвал зохино.

4. Улсын Их Хурал өөрт нь итгэл хүлээлгэж байгааг нотолсон болон огцрох тухай хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон бол энэ тухай шийдвэр гарснаас хойш 6 сарын дотор Засгийн газар уг асуудлыг өөрөө санаачлан авч хэлэлцэхгүй.

5. Засгийн газраас Улсын Их Хуралтай өдөр тутам шууд харилцах асуудлыг Ерөнхий сайд, эсхүл ажил үүргийн хуваарь бүхий Засгийн газрын гишүүн эрхэлнэ.

6. Засгийн газар Улсын Их Хуралд жил бүр үйл ажиллагааныхаа тайланг тавьж, цаг үеийн асуудлаар тогтмол мэдээлэл хийж байна.

7. Засгийн газар үйл ажиллагааныхаа хөтөлбөрийн төслийг өөрийн бүрэн эрх эдэлснээс хойш 60 хоногийн дотор, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл зэрэг баримт бичгийн төслийг Улсын Их Хурлаас тогтоосон хугацаанд түүнд өргөн мэдүүлнэ. Хөтөлбөрт Засгийн газраас бүрэн эрхийнхээ хугацаанд эдийн засаг, нийгмийн хөгжил, төрийн удирдлагын тулгамдсан асуудлаар хийж гүйцэтгэх ажлын гол зорилт, хэрэгжүүлэх үндсэн арга хэмжээг тодорхойлно. Харин үндсэн чиглэлд Засгийн газраас тухайн жилд тавих зорилт, хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээ гүйцэтгэх хугацаа, хариуцах эзэнтэй тодорхойлсон байвал зохино.

8. Засгийн газар хуулийн төсөл, төрийн бодлогын зарчмын бусад асуудлаар Улсын Их Хурлаас өөр саналтай байгаа бол Ерөнхий сайд уг саналаа [illegible] Улсын Их Хуралд тавьж болох бөгөөд түүнийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэн шийдвэрлэж хариу өгнө.

9. Засгийн газар хууль санаачлах бүрэн эрхийнхээ дагуу боловсруулсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг Ерөнхий сайд, түүний даалгавраар Засгийн газрын гишүүн Улсын Их Хурлын [illegible] журмын дагуу өргөн мэдүүлнэ.

10. Засгийн газрын гишүүн нь Улсын Их Хурлын гишүүний асуулгын хариуг хууль тогтоомжид заасан журмын дагуу өгөх үүрэгтэй.

*27 дугаар зүйл.* Засгийн газраас Ерөнхийлөгчтэй харилцах

1. Засгийн газар Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэрийг биелүүлэх арга хэмжээ авч, энэ тухай Ерөнхийлөгчид мэдээлж байна.

2. Ерөнхий сайд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэхээр товлосон асуудлаа Ерөнхийлөгчид тухай бүр урьдчилан мэдэгдэнэ.

3. Ерөнхийлөгч Засгийн газрын хуралдаанд [illegible] оролцож, саналаа илэрхийлж болох бөгөөд хэрэв өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Засгийн газарт чиглэл өгөх бол энэ тухай зарлигийн төслийг Ерөнхий сайдад хүргүүлнэ.

4. Ерөнхий сайд уг зарлигийн төслийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж хариу өгнө.

5. Ерөнхий сайд уг зарлигийн төсөлд тодорхойлсон заалтыг Засгийн газар хэрэгжүүлэх боломжгүй гэж үзвэл энэ тухай үндэслэлээ Ерөнхийлөгчид уламжилна.

6. Засгийн газар нь энэ хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу бүрэн эрхийнхээ хугацаа дуусахаас өмнө огцрох тухайгаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, 26 дугаар зүйлд заасны дагуу өөрт нь итгэл хүлээлгэж байгаа эсэхийг илэрхийлж өгөхийг Улсын Их Хурлаас хүсэх тухайгаа Ерөнхийлөгчид урьдчилан мэдэгдэж зөвшилцөнө.

7. Засгийн газар бүрэн эрхийнхээ хугацаа дуусахаас өмнө огцрох, өөрт нь итгэл хүлээлгэж байгаа эсэхийг илэрхийлж өгөхийг хүсэх тухай саналыг Ерөнхийлөгч зөвшөөрөөгүй байдал нь Улсын Их Хурал уг асуудлыг хэлэлцэхэд саад болохгүй.

*28 дугаар зүйл.* Засгийн газраас Засгийн газрын бус (олон нийтийн) байгууллагатай харилцах

1. Засгийн газар нь өөрийн бүрэн эрхэд хамаарах аливаа асуудлаар Улсын Их Хуралд суудал бүхий намын дээд, төв байгууллагатай шууд, тийм суудалгүй нам хийгээд олон нийтийн бусад байгууллагатай төрийн захиргааны зохих төв байгууллагаар уламжлан, харин төвлөрсөн бус (орон нутгийн чанартай) байгууллагатай төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны зохих шатны байгууллагаар дамжуулан харилцана.

2. Улсын хэмжээний зохион байгуулалтын бүтэц бүхий олон нийтийн байгууллагууд нь өөрийн үйл ажиллагааны талаархи асуудлаар удирдах дээд, төв байгууллагаараа уламжлан Засгийн газартай харилцана.

3. Засгийн газар нь олон нийтийн байгууллагаас улс орныг хөгжүүлэх, төр, нийгмийн байгууллыг бэхжүүлэх, төрийн бодлого, хууль тогтоомжийн биелэлтийг хангахад тус дөхөм үзүүлэх талаар гаргасан санал, санаачилгыг дэмжих шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар тэдгээр байгууллагатай харилцан ажиллана.

## ЗУРГАДУГААР БУЛЭГ

*Засгийн газрын ажлын зохион байгуулалт*

*29 дүгээр зүйл.* Засгийн газрын хуралдаан

1. Засгийн газар энэ хууль, бусад хуульд заасан бүрэн эрхийнхээ асуудал, түүнчлэн Улсын Их Хурлаас даалгасан, Ерөнхийлөгчөөс санал болгосон асуудлыг хуралдаанаараа хэлэлцсэний үндсэн дээр шийдвэрлэнэ. Түүний дотор доор дурдсан асуудлыг хуралдаанаараа заавал хэлэлцэнэ:

1) хуулийн төсөл;

2) хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх бусад шийдвэрийн төсөл;

3) Засгийн газарт чиглэл өгөх тухай Ерөнхийлөгчийн зарлигийн төсөл;

4) Засгийн газрын бодлогод өөрчлөлт оруулахаар өөрийн гишүүнээс ирүүлсэн санал (төсөл);

5) Ерөнхий сайд дангаараа шийдвэрлэлгүй бөгөөд Засгийн газрын гишүүдээс ирүүлэх асуудлаа өөрсдөө тохиролцож чадаагүй саналын зөрөөг шийдвэрлэх асуудал.

2. Засгийн газрын хуралдаанд бэлтгэх, асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхдээ дараахь журмыг баримтална:

1) хуралдааныг Ерөнхий сайдын товлосноор хийнэ. Харин Засгийн газрын гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь санал болговол хуралдааныг хийж болно;

2) хуралдааныг энэ хуулийн 26 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд нийт гишүүний гуравны хоёр нь оролцсоноор хүчинтэйд тооцно;

3) хэлэлцэх асуудлыг Засгийн газрын гишүүн, Засгийн газрын үндсэн бүтцэд орсон тусгай газрын дарга, түүнчлэн аймаг, нийслэлийн Засаг дарга тус тус эрх хэмжээний дотор санаачлах эрхтэй. Бусад байгууллага, албан тушаалтан, иргэд хуульд өөрөөр заагаагүй бол Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлын тухай саналаа Засгийн газрын холбогдох гишүүнээр уламжлан тавьж болно;

4) хэлэлцэх асуудлаар гарах шийдвэрийн төсөл, түүний үндэслэлийг Засгийн газрын хариуцах гишүүн, хэрэв хэд хэдэн гишүүн хариуцах бол тэдгээр нь хамтран үзээд бэлтгэл хангагдсан гэж үзвэл хуралдаанд оруулахыг зөвшөөрнө. Төсөл нь хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлигт нийцсэн, гүйцэд боловсрогдсон, зохих тооцоо, холбогдох яам, тусгай газрын виз (санал)-ээр нотлогдсон байвал зохино;

5) хариуцсан гишүүний зөвшөөрсөн төсөл, түүний үндэслэлийг Хэрэг эрхлэх газрын дарга Ерөнхий сайдад танилцуулж, түүний зөвшөөрснөөр нийт гишүүнд уг асуудлыг хэлэлцэхээс ажлын 3-аас доошгүй хоногийн өмнө гардуулсан байвал зохино;

6) асуудлыг Ерөнхий сайдаас тогтоосон дарааллын дагуу хэлэлцэнэ. Харин хэлэлцэх асуудлаар гарах шийдвэрийн төслийг Засгийн газрын гишүүд бүгд зөвшөөрч гарын үсгээ зурсан бол шийдвэрийг хуралдаанаар хэлэлцэхгүйгээр гаргаж болно.

3. Засгийн газрын хуралдааны нарийвчилсан дэгийг энэ хуулийн дагуу Засгийн газар тогтооно.

4. Хуралдааныг Ерөнхий сайдын шийдвэрлэснээр нээлттэй буюу хаалттай явуулж болох бөгөөд хуулиар хамгаалсан нууцад хамаарахаас бусад шийдвэрийг олон нийтэд мэдээлнэ.

*30 дугаар зүйл.* Засгийн газрын шийдвэр

1. Засгийн газар бүрэн эрхийнхээ асуудлаар хуралдаанаас тогтоол, нэг удаагийн чанартай шуурхай асуудлаар Ерөнхий сайд захирамж гаргана.

2. Хуулийн төсөл, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх бусад асуудал, олон улсын гэрээ, яам, тусгай газрын олонхийн эрхлэх ажилд холбогдсон болон хууль тогтоомжид тусгайлан заасан асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад асуудлаар Ерөнхий сайд олонхиос өөр саналтай боловч тухайн асуудлаар гарах шийдвэрийн биелэлтийг хариуцсан сайд (гишүүн)-тай нэг саналтай бол уг асуудлаар шийдвэр гаргаж болно. Ийнхүү шийдвэр гаргасан бол энэ тухай Ерөнхий сайд Улсын Их Хуралд мэдэгдэх үүрэгтэй бөгөөд санал зөрсөн бусад гишүүн Их Хуралд мэдэгдэх эрхтэй. Харин Ерөнхий сайд болон шийдвэрийн биелэлтийг хариуцсан гишүүний аль нэг нь олонхитой нэг саналтай, нөгөө нь өөр саналтай байвал уг асуудлыг дахин боловсруулж хэлэлцэнэ.

4. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн шийдвэрийн төслийг тухайн шийдвэрийн биелэлтийг хариуцсан Засгийн газрын гишүүн хянан үзэж ёсчлон гаргах зөвшөөрөл өгнө.

5. Засгийн газрын тогтоолд түүний биелэлтийг хариуцсан сайд нар, дараа нь Ерөнхий сайд гарын үсэг зурна.

6. Засгийн газрын шийдвэрт Ерөнхий сайд гарын үсэг зурахын өмнө тухайн шийдвэр хууль тогтоомжид нийцэж байгааг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга нотолсон байвал зохино.

7. Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж нь тэдгээрт өөрөөр заагаагүй бол гарсан өдрөөсөө эхлэн хүчин төгөлдөр болно.

8. Хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан Засгийн газрын шийдвэрийг Монгол Улсын нутаг дэвсгэрт нийт байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэн биелүүлэх үүрэгтэй.

*31 дүгээр зүйл.* Засгийн газрын шийдвэрийг нийтлэх

1. Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамжийг тэдгээрт Ерөнхий сайд гарын үсэг зурснаас хойш ажлын 3 хоногийн дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын

[illegible] төрийн төв хэвлэлд албан ёсоор нийтлэхээс гадна Ерөнхий сайдын мэдээллийн албанаас эрхлэн хэвлэх, мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

2. Засгийн газрын тогтоол, бусад шийдвэрийг төв, орон нутгийн сонин, хэвлэлд нийтлэхдээ төрийн төв хэвлэлд нийтлэгдсэн албан ёсны эхийг баримтална.

3. Засгийн газар тогтоол, захирамжаа тэдгээрийн заалтыг хариуцан гүйцэтгэх байгууллагад тараан хүргүүлж, биелэлтийг нь хянан шалгаж, зохион байгуулан үр дүнг хугацаанд нь тооцон байвал зохино.

*32 дугаар зүйл.* Засгийн газрын хуралдааны явцыг баримтжуулах, тэдгээрийг ашиглах, хадгалах

1. Засгийн газрын хуралдааны явцыг баримтжуулах (гараар болон соронзон хальсанд нэгэн зэрэг бичиж албан ёсны тэмдэглэл хөтлөх) ажлыг Засгийн газраас тогтоосон журмын дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газар эрхэлнэ.

2. Засгийн газрын хуралдааны явцын тэмдэглэлд хуралдаанд оролцсон гишүүд, тухайн асуудал бүр дээр тэдгээрийн гаргасан санал, шүүмжлэл, түүнчлэн санал хураалтын дүнг заавал тусгаж Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга гарын үсэг зурна.

3. Засгийн газрын хуралдааны явцын гар тэмдэглэл, соронзон бичлэгийг ашиглах, архивт хадгалах журмыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар тогтооно.

*33 дугаар зүйл.* Засгийн газрын Хэрэг эрхлэх газар

1. Засгийн газрын ажлын алба нь Хэрэг эрхлэх газар мөн.

2. Хэрэг эрхлэх газар нь Засгийн газрын үйл ажиллагааг зохион байгуулалт, эрх зүй, материал-техникийн талаар үйлчлэн хангах, түүнчлэн Засгийн газраас төрийн захиргааны төв байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах, нутгийн захиргааг чиглүүлэн удирдахад туслах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ. Түүний дотор:

1) Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнийг Засгийн газрын хэмжээнд шийдвэрлэж зохион байгуулах болон шаардлагатай бусад мэдээллээр хангаж, мэргэжил, арга зүй, техник-зохион байгуулалтын туслалцаа үзүүлнэ;

2) Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн асуудлыг зохих журмын дагуу бэлтгэж хуралдаанд оруулна;

3) Засгийн газрын хуралдааныг зохион байгуулалт, техникийн бэлтгэлийг хангана;

4) Засгийн газрын шийдвэрийг хэлбэржүүлэн гаргаж нийтэлж мэдээлнэ;

5) Засгийн газрын шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж, гүйцэтгэлд техник хяналт тавьж, үр дүнг нэгтгэн тодорхойлно;

6) Засгийн газрын хуралдааны нарийн тэмдэглэл, Засгийн газарт орж гарах бичиг хэргийн ажиллагааг эрхлэж зохион байгуулна;

7) Засгийн газарт иргэд, байгууллагаас ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг хүлээн авч зохих журмаар шийдвэрлүүлнэ;

8) төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад удирдлагын ходолмөрийг зохион байгуулах талаар арга зүйн шаардлагатай туслалцаа үзүүлнэ;

9) Засгийн газраас аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх болон Засгийн газраас яам, тусгай газар, аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааг удирдахад туслана;

10) хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд тавих хяналт шалгалтыг зохион байгуулна;

11) төрийн албаны ажилтан бэлтгэх, давтан сургах, дахин мэргэшүүлэх, мэргэшлийг дээшлүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг зохион байгуулна.

3. Хэрэг эрхлэх газрын дүрэм, бүтэц, орон тоо, цалингийн санг зардлын төсөвтөө багтаан Засгийн газар батлаж тогтооно.

4. Хэрэг эрхлэх газрын бүтцэд хэрэг эрхлэхтэй холбогдсон нэгжүүдээс гадна нутгийн захиргааны байгууллагыг Засгийн газраас удирдахад туслах болон захидал харилцаа, хэвлэл, мэдээлэл, хяналт шалгалт, төрийн албаны боловсон хүчний асуудал эрхэлсэн бүтцийн хэсэг (хэлтэс, тасаг зэрэг) байж болно. Ерөнхий сайдын ажлын албаны ажилтан Ерөнхий сайдад захирагдах боловч төрийн албан хаагчийн хувьд Хэрэг эрхлэх газарт харьяалагдана.

5. Засгийн газар шаардлагатай бол зөвлөл, ажлын бусад албыг зардлынхаа төсөвт багтаан байгуулан ажиллуулж болно.

*34 дүгээр зүйл. Хэрэг эрхлэх газрын удирдлага*

1. Хэрэг эрхлэх газрыг Засгийн газраас томилсон дарга толгойлно.

2. Хэрэг эрхлэх газрын дарга төрийн албанаа мэргэшсэн албан хаагч байх бөгөөд Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа дуусах нь түүнийг өөрчлөх үндэслэл болохгүй.

3. Хэрэг эрхлэх газрын дарга нь газрынхаа үйл ажиллагааг удирдахын хамт Засгийн газар, Ерөнхий сайдын даалгавраар нэн, тусгай газрын болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарын үйл ажиллагааг зохион байгуулалтын талаар шуурхай зохицуулах ажлыг эрхэлнэ.

4. Хэрэг эрхлэх газрын дарга Ерөнхий сайдад ажлаа хариуцна.

*35 дугаар зүйл.* Засгийн газрын болон түүний байгууллагын аппаратад улс төрийн үйл ажиллагаа явуулахыг хориглох

Засгийн газрын болон түүний байгууллагын аппаратад нам, олон нийтийн байгууллагын шугамаар улс төрийн үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

*36 дугаар зүйл.* Засгийн газрын тамга, тэмдэг

1. Засгийн газар соёмбо бүхий тамга, тогтоосон журмаар үйлдсэн тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

2. Засгийн газрын тамга, тэмдэг хийх, хэрэглэх журмыг Засгийн газар тогтооно.

Монгол Улсын Их Хурлын дарга — Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

993 оны 5 дугаар арын 6-ны өдөр

Улаанбаатар хот

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1993 оны 5 дугаар сарын 10-ны өдөр

Улаанбаатар хот

# ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Гадаадын хөрөнгө оруулалтын тухай Монгол улсын хууль батлагдсантай холбогдуулан 1990 оны 3 дугаар сарын 23-ны өдөр батлагдсан БНМАУ-ын гадаадын хөрөнгө оруулах тухай хуулийг 1993 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Их Хурлын дарга — Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга — М. РИНЧИНДОРЖ

## БУУНЫ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

*1 дүгээр зүйл.* Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшиж байгаа бууны албан татвар ногдуулах, уг албан татварыг улсын төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

*2 дугаар зүйл.* Бууны албан татвар төлөгч

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт хууль тогтоомжид заасан журмын дагуу буу эзэмшиж байгаа:

1) Монгол Улсын иргэн;

2) өмчийн бүх хэлбэрт хамаарагдах аж ахуйн нэгж, байгууллага бууны албан татвар төлөгч байна.

2. Хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт буу эзэмшиж байгаа гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэгэн адил бууны албан татвар (цаашид "албан татвар" гэх) төлнө.

*3 дугаар зүйл.* Албан татвар ногдох буу

Улсыг батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах, цагдаагийн болон ял эдлүүлэх байгууллагын бие бүрэлдэхүүний зэвсэглэлийн зориулалтаар ашиглаж байгаагаас бусад бүх бууны албан татвар ногдоно.

*4 дүгээр зүйл.* Албан татварын хэмжээ

Албан татвар ногдох буу бүрт ногдуулах жилийн албан татвар дор дурдсан хэмжээтэй байна:

| № | Бууны төрөл | Жилийн албан татварын хэмжээ (төгрөгөөр) |
|---|---|---|
| 1. | Үрлэн сумтай буу | 400 |
| 2. | 6, 4 мм хүртэл калибрийн бүх төрлийн буу | 400 |
| 3. | 6, 5 ба түүнээс дээш мм-ийн калибрийн бүх төрлийн буу | 600 |

*5 дугаар зүйл.* Албан татвараас чөлөөлөх

1. Дараах буут албан татвараас чөлөөлнө:

1) музейн үзмэр, урлагийн тоглолтод ашиглаж байгаа болон ангийн зориулалтаар ашиглах боломжгүй болохыг цагдаагийн байгууллага тогтоож цэгмэлэх олгосон;

2) байгаль хамгаалагчийн эзэмшилд байгаа албаны буу;

3) спорт, сургалтын зориулалтаар дагнан ашиглаж байгаа.

2. Хөдөлмөрийн чадваргүй болон албан татвар төлөх орлогогүй иргэнийг харьяалах сум, дүүргийн татварын алба тухайн жилийн албан татвараас чөлөөлж болно.

*6 дугаар зүйл.* Албан татвар төлөгчийн үүрэг

Албан татвар төлөгч дараахь үүрэг хүлээнэ:

1) өөрийн өмч буюу эзэмшилд байгаа буугаа жил бүрийн 12 дугаар сард цагдаагийн байгууллагад бүртгүүлж албан татварыг тогтоосон хугацаанд нь төлөх, цаашид ашиглагдахгүй болсон буугаа зохих журмын дагуу бүртгэлээс хасуулах;

2) буу өвлөх, худалдан авах, бэлэг дурсгалд авах зэргээр өмчлөх болсон тохиолдолд тухайн буугаа эзэмшилдээ авснаас хойш 30 хоногийн дотор цагдаагийн байгууллагад бүртгүүлж цэгмэлэх авах;

3) албан татвар төлөгч шилжин суурьшихдаа буугаа оршин сууж байсан нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын бүртгэлээс хасуулан татварын тооцоо хийж шилжин очсон нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад энэ зүйлийн 2 дахь дэд хэсэгт заасан хугацаанд бүртгүүлэх.

*7 дугаар зүйл.* Цагдаагийн байгууллагын үүрэг

Цагдаагийн байгууллага бууны бүртгэл, хөдөлгөөний мэдээг жил бүрийн 2 дугаар сарын 15-ны дотор тухайн нутаг дэвсгэрийн татварын албанд гаргаж өгнө.

*8 дугаар зүйл.* Албан татвар төлөх хугацаа

Албан татвар төлөгч албан татварыг жил бүрийн 8 дугаар сарын 1-ний дотор улсын төсөвт төлнө.

| | |
|---|---|
| Монгол Улсын Их Хурлын дарга | Н. БАГАБАНДИ |
| Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга | Н. РИНЧИНДОРЖ |

1993 оны 5 дугаар сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ

1993 оны 5 дугаар сарын 11-ний өдөр

Улаанбаатар хот

## ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

БНМАУ-ын Засгийн газрын тухай 1991 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн хууль, Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай 1992 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн хуулийг Монгол Улсын Засгийн газрын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Их Хурлын дарга — Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН**
**ХУУЛЬ**

1993 оны 5 дугаар сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай Монгол Улсын 1992 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн хуулийн 1 дэх хэсгийн 2, 3, 4-ийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

«2) Монгол Улсын шадар сайд
3) Монгол Улсын шадар сайд
4) Монгол Улсын сайд бөгөөд Үндэсний хөгжлийн газрын дарга».

2. Энэ хуулийг Монгол Улсын Засгийн газрын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга — Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ

1993 оны 5 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

## ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 15 дугаар заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1992 оны арван нэгдүгээр сарын 5-нд Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан Монгол Улс, Украин Улсын хоорондын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Гэрээг Засгийн газраас өргөн мэдүүлсний дагуу соёрхон баталсугай.

Монгол Улсын Их Хурлын дарга — Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН**
**ХУУЛЬ**

1993 оны 5 дугаар сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

# ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

БНМАУ-ын Ерөнхийлөгчийн тухай 1991 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн хуулийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

**Монгол Улсын Их Хурлын дарга** — Н. БАГАБАНДИ

**Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга** — Н. РИНЧИНДОРЖ

МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ

| | |
|---|---|
| 1993 оны 6 дугаар сарын 1-ний өдөр | Улаанбаатар хот |

## ОЛОН УЛСЫН КОНВЕНЦ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 15 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Биологийн төрөл зүйлийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын 1992 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн Конвенцийг соёрхон баталсугай.

| | |
|---|---|
| Монгол Улсын Их Хурлын дарга | Н. БАГАБАНДИ |
| Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга | Н. РИНЧИНДОРЖ |

# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУХАЙ ХУУЛЬ

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### *Нийтлэг үндэслэл*

*1 дүгээр зүйл.* Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Ерөнхийлөгч (цаашид «Ерөнхийлөгч» гэх)-ийн бүрэн эрх, халдашгүй байдал, тэдгээрийн баталгааг тогтоох, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

*2 дугаар зүйл.* Ерөнхийлөгчийн тухай хууль тогтоомж

Ерөнхийлөгчийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

*3 дугаар зүйл.* Ерөнхийлөгч

1. Ерөнхийлөгч бол Үндсэн хуулийн гучдугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн.

2. Ерөнхийлөгч төрийн тэргүүний хувьд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хангах ашиг сонирхлын үүднээс хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагууд зүй зохистой харилцан ажиллахад нь Үндсэн хууль болон бусад хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд дэмжлэг нөлөө үзүүлнэ.

3. Ерөнхийлөгч Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгчийн хувьд үндэсний эв нэгдлийн ашиг сонирхлыг дээдэлж, шаардлагатай үед нийгмийн бүлэг, хэсэг, улс төрийн хүчнүүдийн хооронд зөвшилд хүрэхэд нь дэмжлэг үзүүлнэ.

*4 дүгээр зүйл.* Ерөнхийлөгчийг сонгох

1. Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуулийг Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дуусахаас 30-аас доошгүй, 60-аас дээшгүй хоногийн өмнө явуулна.

2. Ерөнхийлөгчийг Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн дагуу сонгоно.

*5 дугаар зүйл.* Ерөнхийлөгч тангараг өргөх

1. Шинэ сонгогдсон Ерөнхийлөгч нь Улсын Их Хурал Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөв-

шөөрсөн хууль гаргаснаас хойш 30 хоногийн дотор Улсын Их Хуралд үндсэн хуулиар тогтоосон тангараг өргөнө.

2. Ерөнхийлөгч тангараг өргөх өдрийг Улсын Их Хурал тогтоол тогтооно.

3. Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолын журмыг Улсын Их Хурал тогтооно.

*6 дугаар зүйл.* Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа

1. Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа Үндсэн хуулийн гучдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасанаар 4 жил байна.

2. Үндсэн хуулийн гучин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасанаар Ерөнхийлөгчийн бүрэн эрх тангараг өргөснөөр эхэлж, шинэ сонгогдсон Ерөнхийлөгч тангараг өргөснөөр дуусгавар болно.

3. Ерөнхийлөгчийн бүрэн эрх дараах тохиолдолд хугацаанаас өмнө дуусгавар болно:

1) биеийн эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсноос үүрэгт ажлаас чөлөөлөгдөхийг хүсэж Улсын Их Хуралд өргөдөл гаргасан бөгөөд уг хүсэлтийг ёсоор болгосон;

2) Үндсэн хуулийн гучин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу огцруулсан;

3) нас нөгчсөн.

*7 дугаар зүйл.* Ерөнхийлөгч ажлаа хариуцах

1. Ерөнхийлөгч Улсын Их Хуралд ажлаа хариуцаж жил тутам үйл ажиллагааныхаа талаар танилцуулж байна.

2. Ерөнхийлөгч тангарагаасаа няцаж Үндсэн хууль, бусад хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчсөн тухай асуудлыг Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны нэгээс доошгүй нь албан ёсоор тавибал Үндсэн хуулийн гучин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурал хэлэлцэж Ерөнхийлөгчийг огцруулах эсэхийг шийдвэрлэнэ.

*8 дугаар зүйл.* Ерөнхийлөгч хавсарч болохгүй ажил, албан тушаал

Үндсэн хуулийн гучин нэгдүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасанаар Ерөнхийлөгч нь Ерөнхий сайд, Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүн, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах бусад ажил, албан тушаал хавсарч болохгүй. Хэрэв Ерөнхийлөгч өөр ажил, албан тушаал эрхэлж байгаа бол тангараг өргөсөн өдрөөсөө эхлэн уул үүргээс чөлөөлөгдөнө.

*9 дүгээр зүйл.* Ерөнхийлөгчийн зарлиг, захирамж

1. Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд Үндсэн хууль, бусад хуульд нийцүүлэн зарлиг, захирамж гаргана.

2. Хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан Ерөнхийлөгчийн зарлигийг Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр дагаж мөрдөнө.

3. Эрх зүйн хэм хэмжээ тогтоосон, нийтээр дагаж мөрдөх зарлиг түүнд өөрөөр заагаагүй бол төрийн төв хэвлэлд албан ёсоор нийтлэгдсэнээс хойш 10 хоногийн дараа, бусад зарлиг, захирамж тэдгээрт өөрөөр заагаагүй бол гарсан өдрөөсөө эхлэн хүчин төгөлдөр болно.

4. Ерөнхийлөгчийн зарлиг хуульд нийцээгүй бол Үндсэн хуулийн гучин дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Ерөнхийлөгч өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно.

*10 дугаар зүйл.* Ерөнхийлөгчийн зарлиг, захирамжийг нийтлэх

1. Ерөнхийлөгчийн зарлиг, захирамжийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын зөвшөөрснөөр төрийн төв хэвлэлд албан ёсоор нийтлэхээс гадна хэвлэл, мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

2. Ерөнхийлөгчийн зарлиг, захирамжийг төв, орон нутгийн сонин хэвлэлд нийтлэхдээ төрийн төв хэвлэлд нийтлэгдсэн албан ёсны эхийг баримтална.

*11 дүгээр зүйл.* Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг Улсын Их Хурлын дарга хэрэгжүүлэх

1. Ерөнхийлөгчийг түр эзгүйд, эсхүл Ерөнхийлөгч огцорсон, нас нөгчсөн, хүсэлтээрээ чөлөөлөгдсөн бол Улсын Их Хурлын дарга хууль тогтоомжид заасны дагуу Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

2. Дараах тохиолдолд Ерөнхийлөгчийг түр эзгүй гэж үзнэ:

1) эрүүл мэндийн хувьд бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсныг эмнэлгийн дүгнэлт үндэслэн Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн;

2) өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон;

3) түр эзгүй гэж Ерөнхийлөгч өөрөө албан ёсоор үзсэн.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1, 3-т заасан тохиолдолд Улсын Их Хурлын дарга Ерөнхийлөгчийн албан ёсоор шилжүүлсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

4. Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 2-т заасан **тохиолдолд болон** Ерөнхийлөгч огцорсон, нас нөгчсөн, хүсэлтээрээ чөлөөлөгдсөн бол Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг Улсын Их Хурлын дарга бүрэн хэрэгжүүлнэ.

5. Энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан тохиолдолд Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг Улсын Их Хурлын дарга хэрэгжүүлэх асуудлыг Улсын Их Хурал чуулганы хуралдаанаараа тухай бүр хэлэлцэж шийдвэр гаргана.

6. Улсын Их Хурлын дарга Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлж байхдаа Ерөнхийлөгчийн зарлиг, захирамжид «Ерөнхийлөгчийн үүрэг гүйцэтгэгч» гэж гарын үсэг зурна.

7. Ерөнхийлөгч ажилдаа эргэж орсон тухай Улсын Их Хуралд мэдэгдсэнээр Ерөнхийлөгчийн түр эзгүй байдал дуусгавар болно.

8. Ерөнхийлөгч огцорсон, нас нөгчсөн, хүсэлтээрээ чөлөөлөгдсөн бол Улсын Их Хурал Ерөнхийлөгчийн сонгуулийг дөрвөн сарын дотор зарлан явуулна.

## ХОЕРДУГААР БҮЛЭГ

### *Ерөнхийлөгчийн бүрэн эрх*

*12 дугаар зүйл.* Төрийн байгуулал, улс орны удирдлагын талаархи Ерөнхийлөгчийн бүрэн эрх

1. Улсын Их Хурлын анхдугаар чуулганыг товлон зарлах буюу улс орны чанартай хойшлуулашгүй чухал асуудлыг хэлэлцүүлэхээр Улсын Их Хурлын ээлжит бус чуулган чуулахыг санаачилна. Ерөнхийлөгчийн санаачилгаар ээлжит бус чуулган чуулах бол Улсын Их Хурлын дарга Ерөнхийлөгчтэй тохиролцсон хугацаанд уул чуулганыг товлон зарлана.

2. Засгийн газар огцорсон, Улсын Их Хурал Ерөнхий сайдыг огцруулах буюу хүсэлтээр нь чөлөөлөх тухай шийдвэр гаргасан, Улсын Их Хурлын анхдугаар чуулганаар Улсын Их Хурлын дарга сонгогдсон, Ерөнхий сайд нас нөгчсөнөөс хойш 14 хоногийн дотор Улсын Их Хуралд олонхи суудал авсан нам буюу намуудын сонгуулийн эвсэл (цаашид «нам» гэх)-тэй, аль ч нам олонхийн суудал аваагүй бол Улсын Их Хуралд суудал авсан намуудтай зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг Улсын Их Хуралд оруулна. Хэрэв Улсын Их Хуралд суудал авсан намуудтай зөвшилцөж

нэгдсэн саналд хүрч чадаагүй бол санал нэгдсэн бөгөөд Улсын Их Хуралд авсан суудлын шийдвэр нь Улсын Их Хурлын нийт суудлын 50-иас дээш хувийг эзэлж байгаа намуудтай зөвшилцсөн нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг Улсын Их Хуралд оруулна.

3. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах тухай Ерөнхий сайдаас тавьсан саналын талаар түүнтэй зөвшилцөнө.

4. Улсын Их Хурлын чуулганд өөрийн таалаар оролцон улс орны дотоод, гадаад байдлын нэн чухал асуудлаар мэдээлж, төрийн бодлогын аливаа асуудлаар Улсын Их Хуралд саналаа оруулна.

5. Хууль санаачлах бүрэн эрхийнхээ дагуу боловсруулсан хуулийн болон түүнтэй холбогдох шийдвэрийн төслийг хууль тогтоомжинд заасны дагуу Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлнэ.

6. Хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар саналаа илэрхийлж болно. Энэ нь уул хуульд хориг тавих бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд саад болохгүй.

7. Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасчлан бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавина.

8. Монголын ард түмний эв нэгдэл, улс орны эдийн засаг, улс төрийн тогтвортой байдлыг хангах, шаардлагатай гэж үзсэн бусад асуудлаар Улсын Их Хуралд болон ард түмэндээ хандан илгээлт гаргана.

9. Ард нийтийн санал асуулга явуулах саналыг хууль тогтоомжинд заасны дагуу Улсын Их Хуралд оруулна.

10. Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзэж өөрөө тарах шийдвэр гаргахыг Улсын Их Хуралд санал болгох тухайгаа зөвшилцөхөөр Улсын Их Хурлын даргад албан ёсоор мэдэгдэнэ. Улсын Их Хурлын дарга уул саналыг зөвшөөрөөгүй нь Ерөнхийлөгч саналаа Улсын Их Хуралд оруулахад саад болохгүй.

11. Үндэсний аюулгүй байдал, эв нэгдлийг хангах болон өөрийн бүрэн эрхэд хамаарах бусад асуудлаар Үндсэн хуульд заасны дагуу Засгийн газарт чиглэл өгнө.

12. Ерөнхийлөгчийн зарлигийн биелэлтийн талаар Засгийн газрын мэдээллийг сонсоно.

13. Засгийн газрын хуралдаанд өөрийн таалаар оролцож санал бодлоо илэрхийлнэ.

14. Улсын Их Хурлаас тодорхойлсон Монгол Улсад дотоод, гадаад бодлогод нийцээгүй үйл ажиллагаа явуулсан болон үйл ажиллагаандаа хөтөлбөрийг хэрэгжүүлээгүй байгаа, түүнчлэн Засгийн газарт чиглэл өгөх тухай Ерөнхийлөгчийн зарлигийг Засгийн газар хэрэгжүүлээгүй нь Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд саад болсон гэж үзвэл Засгийн газрыг огцруулах саналыг Улсын Их Хуралд оруулна.

15. Бүх шатны шүүгчийг хуульд заасны дагуу томилно.

16. Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нарыг томилох тухай саналаа Улсын Их Хуралд оруулна. Улсын Их Хурал уг саналыг татгалзсан бол өөр хүнийг санал болгоно.

17. Төрийн тамгыг хууль тогтоомжид заасны дагуу барина.

*13 дугаар зүйл.* Үндэсний аюулгүй байдлыг хангах, улсыг батлан хамгаалах талаарх Ерөнхийлөгчийн бүрэн эрх

1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлнэ.

2. Үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон мэдээллийг зохих байгууллагаас гаргуулан авч, шаардлагатай асуудлыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаанд санаачлан оруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд үүрэг, даалгавар өгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн биелэлтэд хяналт тавина.

3. Үндэсний аюулгүй байдлыг хангах эрх ашгийн үүднээс шаардлагатай гэж үзвэл улсын аюулгүй байдлыг хангах байгууллагын тодорхой үйл ажиллагаатай танилцаж, мэдээлэл авна.

4. Батлан хамгаалах, улсын болон иргэний засаг, экологийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий байгууллагын эрх баригчийн илтгэл, мэдээллийг сонсоно.

5. Цэргийн номлол, зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалтыг Засгийн газартай тохиролцон тодорхойлж Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

6. Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болбол Улсын Их Хурлын чуулганы чөлөө цагт, хойшлуулашгүй тохиолдолд улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц болон дайны байдал зарлах, түүнчлэн цэрэг хөдөлгөх захирамж өгнө. Энэ тухай Ерөнхийлөгчийн зарлигийг нэн даруй ард нийтэд зарлан мэдэгдэнэ. Онц байдал, дайны байдал зарласан Ерөнхийлөгчийн зарлигийг Улсын Их Хурал уул зарлиг гарснаас хойш долоо хоногийн

дотор хэлэлцэж батлах буюу хүчингүй болгоно. Хэрэв Улсын Их Хурал шийдвэр гаргаагүй бол уул зарлиг хүчингүй болно.

7. Ерөнхийлөгч Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна.

8. Зэвсэгт хүчний ерөнхий штабын даргыг батлан хамгаалахын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөж томилно.

9. Бүх нийтийн буюу хэсэгчилсэн цэргийн дайчилгааг хууль тогтоомжид заасны дагуу зарлана.

10. Зэвсэгт хүчний нийтлэг дүрмүүдийг батална.

11. Зэвсэгт хүчний дайны үеийн бүтэц, зохион байгуулалт, зэвсэгт хүчнийг дайнд ашиглах ерөнхий төлөвлөгөөг баталж, цэргийг байлдааны бэлэн байдлын зэргүүдэд шилжүүлэх, байлдааны ажиллагаа эхлэх шийдвэр гаргана.

12. Дайн бүхий байдал, дайны байдал зарласан тохиолдолд Ерөнхийлөгч зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хувьд хэрэгжүүлэх бүрэн эрхийг хуулиар тогтооно.

*14 дүгээр зүйл.* Гадаад харилцааны талаархи Ерөнхийлөгчийн бүрэн эрх

1. Гадаад харилцаанд Монгол Улсыг бүрэн эрхтэй төлөөлж, мэдэгдэл, хэлэлцээ хийх, хууль тогтоомжид заасны дагуу Улсын Их Хуралтай зөвшилцөн Монгол Улсын нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулна.

2. Гадаад улсад айлчлах болон айлчлалын дүнгийн талаар Улсын Их Хуралд мэдээлэл хийнэ.

3. Монгол Улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг хууль тогтоомжид заасны дагуу Улсын Их Хуралтай зөвшилцөн томилох буюу эгүүлэн татна.

4. Монгол Улсад суух гадаад улсын бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүний итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичгийг Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6-д заасныар хүлээн авна.

5. Тодорхой асуудлаар өөрийн бие төлөөлөгчийг гадаад улсад түр хугацаагаар томилон ажиллуулна.

*15 дугаар зүйл.* Ерөнхийлөгчийн бусад бүрэн эрх

1. Хууль тогтоомжид заасны дагуу улсын цол, цэргийн дээд цол хүртээх, одон, медалиар шагнах, хүртээсэн цол, шагнасан одон, медалийг хасна.

2. Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8-д зааснаар уучлал үзүүлнэ.

3. Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

4. Үзэл бодол, улс төрийн хийгээд шударга ёсны бусад үйл ажиллагаанныхаа улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн үндэслэл бүхий хүсэлт гаргасан тохиолдолд Монгол Улсад орогнох эрх олгох асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

5. Ерөнхийлөгчид бусад тодорхой бүрэн эрхийг зөвхөн хуулиар олгож болно.

6. Ерөнхийлөгч Үндсэн хуулиар олгосон үндсэн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах тодорхой бүрэн эрх олгох талаар саналаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

*Ерөнхийлөгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх баталгаа*

*16 дугаар зүйл.* Ерөнхийлөгч бүрэн эрхээ хэрэгжүүлэх баталгаа

1. Ерөнхийлөгч бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ дараахь баталгаагаар хангагдана:

1) түүний бие, нэр төр, ордон, өргөө, унаа халдашгүй дархан байна;

2) нийслэл хотод ордон, өвөл, зуны өргөөтэй байх бөгөөд тэдгээрийн зардал, үйлчилгээг улс хариуцна;

3)албан ёсны айлчлал, бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон төрийн ёслол, хүндэтгэлийн болон бусад арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлнэ. Түүний цалин, жилийн зардлын хэмжээг Улсын Их Хурал тогтооно;

4) тусгай зориулалтын холбоо, аюулгүй байдлыг хангахаар тоноглогдсон унаагын хэрэгслээр хангагдана;

5) түүний амь бие, ордон, өргөө, холбоо, унаагын хэрэгсэл улсын хамгаалалтад байх бөгөөд эхнэр (нөхөр), насанд хүрээгүй хүүхдийг нь шаардлагатай үед улсын хамгаалалтад авна;

6) түүний эрүүл мэндийг онцлон хамгаална.

2. Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хугацаанд албан татвараас бусад албан дайчилгаанаас чөлөөлөгдөнө.

3. Ерөнхийлөгч хамтарсан болон дагнасан хувийн үйлдвэр, аж ахуйн бусад нэгжийн үйл ажиллагаа эрхэлдэг бол бүрэн эрхийнхээ хугацаанд уул нэгжийн ажлыг эрхлэн удирдаж болохгүй.

4. Ерөнхийлөгч өөрийн хувийн аж ахуй болон өмч эзэмшилтэй нь холбоотойгоор орсон орлогыг жил бүр, албан үйл ажиллагаатай нь холбогдуулан бусдаас өгсөн сарын цалингаас илүү үнэтэй бэлгийн талаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт тухай бүр мэдэгдэнэ.

5. Ерөнхийлөгч бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон захидал харилцааны нууцыг задруулахыг хориглоно.

6. Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хугацааг дуусгаснаас эхлэн Засгийн газрын гишүүний тухайн үеийн цалинтай тэнцэх сул цалин насан турш авч, нэгэн бүрэн эрхийнхээс илүүгүй хугацаагаар Улсын Их Хурлаас тогтоосон бусад хангамж эдэлж, улсын хамгаалалтад байна.

7. Хуулиар бусад баталгаа тогтоож болно.

*17 дугаар зүйл.* Ерөнхийлөгчийн ажлын алба

1. Ерөнхийлөгчийн ажлын алба нь Ерөнхийлөгчийн Тамгын газар мөн.

2. Тамгын газрын дүрэм, бүтэц, орон тоо, цалингийн санг зардлынхаа төсөвт багтаан Ерөнхийлөгч баталж тогтооно.

3. Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, зөвлөхийг томилно.

4. Зөвлөх нь Ерөнхийлөгчид захирагдах боловч төрийн албан хаагчийн хувьд Тамгын газарт харьяалагдана.

5. Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дууссан нь Тамгын газрын дарга, зөвлөхөөс бусад ажилтныг ажлаас нь өөрчлөх үндэслэл болохгүй.

6. Ерөнхийлөгч үйл ажиллагаагаа явуулахад туслах үүрэг бүхий орон тооны бус зөвлөл, ажлын хэсэг байгуулж болно. Ерөнхийлөгч шаардлагатай гэж үзсэн бусад асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, хамтлагаар судалгаа хийлгэж болно. Үүнд холбогдох хөрөнгийг Ерөнхийлөгчийн жилийн зардалд тусгана.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### *Бусад зүйл*

*18 дугаар зүйл.* Ерөнхийлөгчийн тамга, хэвлэмэл хуудас

Ерөнхийлөгч тогтоосон журмаар үйлдсэн тамга, төрийн сүлд бүхий хэвлэмэл хуудас хэрэглэнэ

*19 дүгээр зүйл.* Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1993 оны 6 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга — Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

1993 оны 6 дугаар сарын 5-ны өдөр — Улаанбаатар хот

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

1993 оны 6 дугаар сарын 10-ны өдөр — Улаанбаатар хот

## ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

*1 дүгээр зүйл.* Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар гэмт хэрэгт тооцогдохгүй болсон хэрэгт 1993 оны 8 дугаар сарын 1-нээс өмнө ял шийтгүүлсэн хүмүүсийг эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялаас чөлөөлнө.

*2 дугаар зүйл.* Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар хүчингүй болсон ялаар шийтгүүлсэн хүмүүсийг 1993 оны 8 дугаар сарын

1-ний өдрөөс эхлэн тухайн төрлийн үндсэн болон нэмэгдэл ялаас чөлөөлнө.

*3 дугаар зүйл.* 1993 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө ял шийтгүүлсэн этгээдэд шүүхээс оногдуулсан ял нь Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулийн зохих зүйлд хасагт заасныг оногдуулж болох тухайн төрлийн ялын дээд хэмжээнээс хүнд байгаа бол уг ялыг шүүхийн магадлалаар Эрүүгийн хуулийн заалтад нийцүүлэх арга хэмжээ авна.

*4 дүгээр зүйл.* Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар гэмт хэрэгт тооцогдохгүй болсон Эрүүгийн хэргийн хэрэг бүртгэх, урьдчилан мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагааг хэрэгсэхгүй болгоно.

*5 дугаар зүйл.* Энэ хуулийн 1, 2 дугаар зүйлд заасныг эдлэх ялаас чөлөөлөгдсөн, түүнчлэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар гэмт хэрэгт тооцогдохгүй болсон хэрэгт шийтгүүлж ялаа эдэлж дууссан буюу хугацаанаас өмнө суллагдсан хүмүүсийг ял шийтгэлгүйд тооцно.

*6 дугаар зүйл.* Энэ хуулийг 1993 оны 8 дугаар сарын 1-нээс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга — Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ

1993 оны 6 дугаар сарын 14-ний өдөр — Улаанбаатар хот

# МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ЦЭРГИЙН ҮҮРГИЙН БОЛОН ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт «татлага явуулах» гэсний дараа «ээлж», гэж нэмсүгэй.

2. Мөн хуулийн 14 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 6 дахь хэсэг нэмсүгэй:

«6. Цэргийн жинхэнэ албанд ээлжит татлагын сэлгэлттэй уялдуулан байлдагч, түрүүч нарыг цэргийн албаны хугацаа дуусахаас өмнө нийтээр халах зөвшөөрлийг Улсын Их Хурал олгоно»

3. Энэ хууль 1993 оны 6 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Монгол Улсын Их Хурлын
дарга — Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын
Тамгын газрын Ерөнхий
нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН**
**ХУУЛЬ**

| | |
|---|---|
| 1993 оны 6 дугаар сарын 14-ний өдөр | Улаанбаатар хот |

# ШҮҮХ БАЙГУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Шүүхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Аймаг, хотын шүүхийг давж заалдах шатны шүүх болгон эрхлэн байгуулж, тэдгээрийн байршил, нутаг дэвсгэрийн харьяаллыг доор дурдсанаар тогтоосугай:

| Шүүхийн нэр | Байрших газрын нэр | Нутаг дэвсгэрийн харьяалал |
|---|---|---|
| 1. Архангай аймгийн давж заалдах шатны шүүх | Цэцэрлэг хот | аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж |
| 2. Баян-Өлгий аймгийн давж заалдах шатны шүүх | Өлгий хот | аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж |
| 3. Баянхонгор аймгийн давж заалдах шатны шүүх | Баянхонгор хот | аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж |
| 4. Булган аймгийн давж заалдах шатны шүүх | Булган хот | аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж |
| 5. Говь-Алтай аймгийн давж заалдах шатны шүүх | Алтай хот | аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж |
| 6. Дорноговь аймгийн давж заалдах шатны шүүх | Сайншанд хот | аймгийн болон Чойр хотын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж |
| 7. Дорнод аймгийн давж заалдах шатны шүүх | Чойбалсан хот | аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж |
| 8. Дундговь аймгийн давж заалдах шатны шүүх | Мандалговь хот | аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж |
| 9. Завхан аймгийн давж заалдах шатны шүүх | Улиастай хот | аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж |

| | | |
|---|---|---|
| 10. Өвөрхангай аймгийн давж заалдах шатны шүүх | Арвайхээр хот | аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж |
| 11. Өмнөговь аймгийн давж заалдах шатны шүүх | Даланзадгад хот | аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж |
| 12. Сүхбаатар аймгийн давж заалдах шатны шүүх | Баруун-Урт хот | аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж |
| 13. Сэлэнгэ аймгийн давж заалдах шатны шүүх | Сүхбаатар хот | аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж |
| 14. Төв аймгийн давж заалдах шатны шүүх | Зуунмод хот | аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж |
| 15. Увс аймгийн давж заалдах шатны шүүх | Улаангом хот | аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж |
| 16. Ховд аймгийн давж заалдах шатны шүүх | Ховд хот | аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж |
| 17. Хөвсгөл аймгийн давж заалдах шатны шүүх | Мөрөн хот | аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж |
| 18. Хэнтий аймгийн давж заалдах шатны шүүх | Өндөрхаан хот | аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж |
| 19. Дархан хот дахь давж заалдах шатны шүүх | Дархан хот | Дархан хотын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж |
| 20. Эрдэнэт хот дахь давж заалдах шатны шүүх | Эрдэнэт хот | Эрдэнэт хотын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж |
| 21. Нийслэлийн давж заалдах шатны шүүх | Улаанбаатар хот | нийслэлийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж |

2. Одоо ажиллаж байгаа хосаг, район орон нутгийн хотын шүүхийг дор дурдсанаар сум болон сум дундын, дүүргийн шүүх болгон өөрчлөн байгуулж, тэдгээрийн байршил, нутаг дэвсгэрийн харьяаллыг тогтоосугай:

| Шүүхийн нэр | Байршил газрын нэр | Нутаг дэвсгэрийн харьяалал |
|---|---|---|
| | Нэг. Сумын шүүх | |
| 1. Дорнод аймаг дахь сумын шүүх | Чойбалсан хот | Чойбалсан хот |
| 2. Чойр хот дахь сумын шүүх | Чойр хот | Чойр хотын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж |

Хоёр. *Сум дундын шүүх*

| | | |
|---|---|---|
| 1. Архангай аймаг дахь сум дундын шүүх | Цэцэрлэг **хот** | аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж |
| 2. Баян-Өлгий аймаг дахь сум дундын шүүх | **Өлгий хот** | аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж |
| 3. Баянхонгор аймаг дахь сум дундын шүүх | Баянхонгор **хот** | аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж |
| 4. Булган аймаг дахь сум дундын шүүх | Булган **хот** | аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж |
| 5. Говь-Алтай аймаг дахь сум дундын шүүх | **Алтай хот** | аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж |
| 6. Дорноговь аймаг дахь сум дундын 1 дүгээр **шүүх** | Сайншанд **хот** | Алтанширээ, Өргөн, Эрдэнэ, Дэлгэрэх, Иххэт, Айраг, Даланжаргалан, Сайхандулаан, Мандах сум, Сайншанд хот, Замын-Үүд, Хөмүү Улаан хороо |
| 7. Дорноговь аймаг дахь сум дундын 2 дугаар **шүүх** | Зүүнбаян **сум** | Зүүнбаян, Хатанбулаг, Улаанбадрах, Хөвсгөл сум |
| 8. Дорнод аймаг дахь сум дундын шүүх | **Чойбалсан** хот | Чойбалсан хотоос бусад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх **нэгж** |
| 9. Дундговь аймаг дахь сум дундын шүүх | **Мандалговь** хот | аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж |
| 10. Завхан аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүх | Улиастай **хот** | Алдархаан, Баянхайрхан, Баянтэс, Отгон, Завханмандал, Дөрвөлжин, Сонгино, Яруу, Асгат, Тэс, Сантмаргац, Түдэвтэй, Ургамал, Цагаанхайрхан, Эрдэнэхайрхан, Цагаанчулуут, Шилүүстэй, Цэцэн-Уул сум, Улиастай хот |
| 11. Завхан аймаг дахь сум дундын 2 дугаар шүүх | Булнай **сум** | Булнай, Их-Уул, Идэр, Нөмрөг, Тэлмэн сум |
| 12. Өмнөговь аймаг дахь сум дундын шүүх | Даланзадгад хот | аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж |
| 13. Өвөрхангай аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүх | Арвайхээр **хот** | Баруунбаян-Улаан, Богд, Уянга, Тарагт, Гучин-Ус, Зүүнбаян-Улаан, Нарийнтээл, Хайрхандулаан, Сант, Төгрөг, Баянгол сум, Арвайхээр хот |

| | | |
|---|---|---|
| 14. Өвөрхангай аймаг дахь сум дундын 2 дугаар шүүх | Хархорин сум | Хархорин, Хужирт, Бүрд, Өлзийт, Бат-Өлзийт, Есөнзүйл, Баян-Өндөр сум |
| 15. Сүхбаатар аймаг дахь сум дундын шүүх | Баруун-Урт хот | аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж |
| 16. Сэлэнгэ аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүх | Сүхбаатар хот | Алтанбулаг, Баруунбүрэн, Зүүнбүрэн, Ерөө, Орхон, Орхонтуул, Сант, Түшиг, Шаамар, Хүдэр, Жавхлант, Сайхан, Цагааннуур, Хушаат сум, Сүхбаатар хот, Дулаанхаан, Ерөө хороо |
| 17. Сэлэнгэ аймаг дахь сум дундын 2 дугаар шүүх | Зүүнхараа | Мандал, Зүүнхараа, Баянгол сум, Түнхэл хороо |
| 18. Төв аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүх | Зуунмод хот | Алтанбулаг, Баян-Өнжүүл, Баянжаргалант, Баян, Баянцогт, Баянцагаан, Баянхангай, Баяндэлгэр, Бүрэн, Эрдэнэ, Дэлгэрхаан, Мөнгөнморьт, Сэргэлэн, Лүн, Өндөрширээт, Эрдэнэсант, Архуст, Аргалант сум, Зуунмод хот |
| 19. Төв аймаг дахь сум дундын 2 дугаар шүүх | Баянчандмань сум | Баянчандмань, Борнуур, Батсүмбэр, Жаргалант, Сүмбэр, Цээл, Угтаалцайдам, Заамар сум |
| 20. Увс аймаг дахь сум дундын шүүх | Улаангом хот | аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж |
| 21. Ховд аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүх | Ховд хот | Ховд, Буянт, Дарви, Дуут, Зэрэг, Манхан, Мянгад, Чандмань, Эрдэнэбүрэн, Дөргөн сум, Ховд хот |
| 22. Ховд аймаг дахь сум дундын 2 дугаар шүүх | Булган | Булган, Алтай, Үенч, Цэцэг, Мөст, Мөнххайрхан сум |
| 23. Хөвсгөл аймаг дахь сум дундын шүүх | Мөрөн хот | аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж |
| 24. Хэнтий аймаг дахь сум дундын шүүх | Өндөрхаан хот | аймгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж |
| 25. Дархан хот дахь сум дундын шүүх | Дархан хот | Дархан хотын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж |
| 26. Эрдэнэт хот дахь сум дундын шүүх | Эрдэнэт хот | Эрдэнэт хотын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бүх нэгж |

Гурав. Дүүргийн шүүх

| | | |
|---|---|---|
| 1. Багануур, Багахангай дүүргийн шүүх | Багануур дүүрэг | Багануур, Багахангай дүүрэг |
| 2. Баянгол дүүргийн шүүх | Баянгол дүүрэг | Баянгол дүүрэг |
| 3. Баянзүрх, Гачуурт дүүргийн шүүх | Баянзүрх дүүрэг | Баянзүрх, Гачуурт дүүрэг |
| 4. Налайх дүүргийн шүүх | Налайх дүүрэг | Налайх дүүрэг |
| 5. Сонгинохайрхан, Жаргалант дүүргийн шүүх | Сонгинохайрхан дүүрэг | Сонгинохайрхан, Жаргалант дүүрэг |
| 6. Сүхбаатар дүүргийн шүүх | Сүхбаатар дүүрэг | Сүхбаатар дүүрэг |
| 7. Хан-Уул, Туул дүүргийн шүүх | Хан-Уул дүүрэг | Хан-Уул, Туул дүүрэг |
| 8. Чингэлтэй дүүргийн шүүх | Чингэлтэй дүүрэг | Чингэлтэй дүүрэг |

3. Энэ хууль хүчин төгөлдөр болтол одоогийн ажиллаж байгаа шүүхүүд бүрэн эрхээ хэрэгжүүлж байсугай.

4. Энэ хууль хүчин төгөлдөр болох үед аймаг, хотын болон Бүх цэргийн тусгай шүүхэд хянан хэлэлцэгдэж байгаа хэрэг, маргааныг аймаг, нийслэлийн шүүхэд, харин район, орон нутгийн хотын шүүх, түүнчлэн Улаанбаатар төмөр замын шүүх, Цэргийн тусгай шүүхэд хянан хэлэлцэгдэж байгаа хэрэг, маргааныг сум болон сум дундын, дүүргийн шүүхэд тухайн хэрэг, маргааны нутаг дэвсгэрийн харьяаллын дагуу шилжүүлсүгэй.

5. Энэ хууль 1993 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

6. Шүүх байгуулах тухай хууль хүчин төгөлдөр болсонтой холбогдуулан «Шүүх, прокурор байгуулах тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1975 оны 2 дугаар сарын 3-ны өдрийн 25 дугаар зарлигийн Улаанбаатар төмөр замд шүүх байгуулах заалт, «Цэргийн тусгай шүүх, прокурорыг байгууллагыг өөрчлөн байгуулах тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1988 оны 1 дүгээр сарын 16-ны өд-

рийн 6 дугаар зарлигийн 1 дэх хэсэг, 3 дахь хэсгийн цэргийн тусгай шүүхтэй холбогдсон заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Их Хурлын дарга — **Н. БАГАБАНДИ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга — **Н. РИНЧИНДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ

1993 оны 6 дугаар сарын 17-ны өдөр — Улаанбаатар хот

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БҮРЭН ЭРХИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин наймдугаар зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн 41 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Пунсалмаагийн Очирбатыг Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсүгэй.

2. Энэ хууль батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Монгол Улсын Их Хурлын дарга — **Н. БАГАБАНДИ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга — **Н. РИНЧИНДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1993 оны 2 дугаар сарын 5-ны өдөр | Дугаар 16 | Улаанбаатар хот |

# МОНГОЛ УЛСЫН ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Хавсралт хуулийн гуравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нарыг шинээр томилох хүртэл БНМАУ-ын Ардын Их Хурлаас томилсон Улсын ерөнхий прокурор, түүний харьяа прокурорууд Үндсэн хууль болон Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуульд нийцүүлэн бүрэн эрхээ хэрэгжүүлж байхаар тогтоосугай.

2. Прокурорын байгууллагыг хууль зүйн дээд боловсролтой боловсон хүчнээр хангах, одоо ажиллаж байгаа хууль зүйн дунд боловсролтой боловсон хүчнийг давтан сургах асуудлыг 1995 онд багтаан шийдвэрлэхийг Засгийн газар (П. Жасрай)-т даалгасугай.

3. Прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг хуульд нийцүүлэн шинэчлэх саналаа 1993 оны 4 дүгээр сарын 1-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, түүнд заасан журам, дүрмийг боловсруулан гаргах, батлуулах ажлыг 1993 онд багтаан гүйцэтгэхийг Улсын ерөнхий прокурор (Г. Бахдал)-т даалгасугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан доор дурдсан зарим зарлиг, тогтоолыг 1993 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай:

1. «Прокурорын байгууллагын прокурор, мөрдөн байцаах ажилтанд цол олгох тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1974 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 358 дугаар зарлиг;

2) «Прокурорын байгууллагын прокурор, мөрдөн байцаагч нарыг сайшаан урамшуулах, тэдэнд сахилгын арга хэмжээ авах

журмын тухай дүрмийг батлах тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1988 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 54 дүгээр зарлиг;

3) «Улс, хоршоологийн сахилгыг бэхжүүлэх талаарх хууль тогтоомжийн биелэлтэд тавих прокурорын хяналтыг хүчтэй болгох тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын 1987 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн тогтоол;

4) «Зохицуулах зөвлөл байгуулах тухай» БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1989 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 11 дүгээр тогтоол.

Дарга **Н. БАГАБАНДИ**

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга **Н. РИНЧИНДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
**ТОГТООЛ**

1993 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

## АЖИЛД ТОМИЛОХ, АЖЛААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Банкны хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монголбанкны тэргүүн дэд ерөнхийлөгчөөр Очирбатын Чулуунбатыг, дэд ерөнхийлөгчөөр Балбарын Аюушийг тус тус томилсугай.

2. Намнангийн Янзанг өөрийн нь хүсэлтийг үндэслэн Монголбанкны дэд ерөнхийлөгчийн үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

Дарга **Н. БАГАБАНДИ**

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга **Н. РИНЧИНДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1993 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

# МОНГОЛ УЛСЫН МАЛЫН УДМЫН САН, ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасугай:

1) Засгийн газрын болон яам, тусгай газрын гаргасан холбогдох эрх зүйн актыг Монгол Улсын Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуульд нийцүүлэх;

2) Малын даатгалын тухай хуулийн төслийг боловсруулж 1993 онд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

3) цөм болон торгон сүргийг 1993 оны 5 дугаар сарын 1-ний дотор улсын бүртгэлд бүртгэж баталгаажуулах.

Дарга — Н. БАГАБАНДИ

Төрийн тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1993 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр — Дугаар 31 — Улаанбаатар хот

# ОРОН НУТГААС ТАВЬСАН САНАЛ, ХҮСЭЛТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын болон Засгийн газрын зарим гишүүд орон нутагт ажиллах явцад байгууллага, иргэдээс тавьсан санал, хүсэлтийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Улсын Их Хурлын дор дурдсан Байнгын хороо, харьяа байгууллагад даалгасугай:

1) Монгол Улсын Үндсэн хуулийн зарим зүйл, заалтын шинжлэх ухаан, эрх зүйн тайлбар гаргах ажлыг энэ онд багтаан;

— хуулийн төсөл боловсруулах, орган барих тухай хуулийн төсөл боловсруулах ажлыг энэ оны 4 дүгээр сард багтаан;

— согтуурал, хээл хахууль авах, албан тушаалаа урвуулан ашиглах, насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэрэгт татан оруулах явдалтай тэмцэх талаарх хууль тогтоомжийн биелэлтийг шалгуулах ажлыг энэ оны эхний хагаст багтаан холбогдох Байнгын хороодтой хамтран тус тус зохион байгуулахыг Хууль зүйн байнгын хороо (С. Төмөр)-нд;

2) нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргын тамгын газрын ажилтнуудыг бэлтгэх, давтан сургах, арга зүйн удирдлагаар хангах талаар авах арга хэмжээг энэ оны 4 дүгээр сард багтаан тодорхойлох. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн заалтуудын хэрэгжилтийг судлан үзэж, түүний дагуу авах арга хэмжээний тухай саналаа Улсын Их Хурлын 1993 оны намрын чуулганд танилцуулахыг Хурал, захиргааны байнгын хороо (Д. Дашцэдэн)-нд;

3) өмч хувьчлалын ажил эхлэхээс өмнө хөдөө аж ахуйн байгууллагын авсан богино хугацаатай зээлийн өрийн асуудлыг судлан үзэж, цаашид авах арга хэмжээний тухай санал боловсруулж, энэ оны 4 дүгээр сард багтаан Улсын Их Хуралд оруулж шийдвэрлүүлэхийг Төсөв, санхүү, мөнгө, зээлийн бодлогын байнгын хороо (А. Баавархүү), Монголбанк (Д. Моломжамц)-нд;

2. Улсын Их Хурлаас батлан гаргасан зарим хуулийг тусгай товхимол болгон хэвлүүлж байхыг Улсын Их Хурлын Тамгын газар (Н. Ринчиндорж)-т даалгасугай.

3. Цаг агаарын онц хүндрэлтэй аймгуудын талаар болон орон нутгийн байгууллага, иргэдээс тавьсан санал, хүсэлтийг судлан үзэж зайлшгүй шаардлагатай арга хэмжээг ойрын үед авч хэрэгжүүлэхийг Засгийн газар (П. Жасрай)-т даалгасугай.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж, дүнг Улсын Их Хурлын 1993 оны намрын чуулганд танилцуулахыг Улсын Их Хурлын дэд дарга (Ж. Гомбожав)-д үүрэг болгосугай.

Дарга Н. БАГАБАНДИ

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Н. РИНЧИНДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1993 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр | Дугаар 32 | Улаанбаатар хот |

# МОНГОЛ УЛСЫН ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ ТОГТООЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын прокурорын байгууллагын тухай хуулийг дахин хэлэлцэж баталсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын прокурорын байгууллагын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын 1993 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 16 дугаар тогтоолын 3 дахь заалтад «Прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг хуульд нийцүүлэн шинэчлэх саналаа 1993 оны 4 дүгээр сарын 1-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлж . . .» гэснийг «Прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг хуульд нийцүүлэн шинэчлэх саналаа 1993 оны 6 дугаар сарын 1-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлж . . .» гэж өөрчлөсүгэй.

| | |
|---|---|
| Дарга | Н. БАГАБАНДИ |
| Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга | Н. РИНЧИНДОРЖ |

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1993 оны 5 дугаар сарын 8-ний өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

# МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТИЙН ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 1993 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 2 дугаар дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1990 оны 99 дүгээр зарлигаар батлагдсан «Хамт олны хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэх дүрэм»-ийн 5, 6, 9, 12 дугаар зүйлийн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн аравдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, дөчин долдугаар зүйлд харшилж байгаа тул Монгол Улсын Үндсэн хуулийн Хавсралт хуулийн тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасаар хүчингүй болох ёстой байжээ гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээж авах боломжгүй гэж үзсүгэй.

Дарга — Н. БАГАБАНДИ

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1991 оны 7 дугаар сарын 8-ны өдөр | Дугаар 34 | Улаанбаатар хот |

# МОНГОЛБАНКНЫ ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Банкны хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монголбанкны дүрмийг хавсралтын ёсоор батласугай.

2. Монголбанкны дүрэм батлагдсантай холбогдуулан «Түр дүрэм батлах тухай» Улсын Бага Хурлын даргын 1991 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 44 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

| | |
|---|---|
| Дарга | Н. БАГАБАНДИ |
| Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга | Н. РИНЧИНДОРЖ |

Монгол Улсын Их Хурлын 1993 оны 5 дугаар сарын 8-ний өдрийн 34 дугаар тогтоолын хавсралт

## МОНГОЛБАНКНЫ ДҮРЭМ

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### *Нийтлэг үндэслэл*

1. Энэ дүрэм нь Монголбанкны эрх үүргийг тодорхойлж, түүний үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна.

2. Монголбанк үйл ажиллагаандаа Монгол Улсын Банкны хууль, хууль тогтоомжийн бусад акт болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

3. Монголбанкны үндсэн зорилт нь төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, төгрөгийн тогтвортой байдлыг хангах, банк хоорондын төлбөр тооцоог шуурхай болгох, улсын валютын нөөц аюулсийн нөөцийг үр ашигтай хадгалах, банкны харилцагчийн ашиг сонирхлыг хамгаалах, хүүгийн нэгдсэн бодлого явуулах, арилжааны банкны үйл ажиллагаанд хяналт тавьж, түүнийг уялдуулан зохицуулахад оршино.

4. Монголбанкны төв Улаанбаатар хотод байрлана.

5. Монголбанк хуулийн этгээд бөгөөд тогтоосон журмаар хийсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ. Өөрийн билэгдэл тэмдэгтэй байж болно.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### *Монголбанкны удирдлага, ажилтан*

6. Монголбанкыг Монгол Улсын Их Хурлаас томилсон Ерөнхийлөгч толгойлж, Монголбанкны үйл ажиллагааг Улсын Их Хурлын өмнө биечлэн хариуцаж тайлагнана.

7. Монголбанкны Ерөнхийлөгч дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) Монголбанк, түүний салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг зохицуулан удирдах;

2) Монголбанкны төвийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо, ажиллагсадын цалин, хөдөлмөрийн хөлсний хэмжээг тог-

гоох, ашиглах томилох, ажлаас халах, тэдгээрийг урамшуулах, сахилгын шийтгэл оногдуулах;

3) Монголбанкны салбар, төлөөлөгчийн газрыг өөрийн болон гадаад улсын нутаг дэвсгэрт байгуулах, татан буулгах, тэдгээрийн удирдлагыг томилох, чөлөөлөх асуудлыг шийдвэрлэх, төсөв, цалингийн санг нь батлах;

4) төрийн мөнгөний бодлогын хэрэгжилт, эдийн засгийн байдлын талаар Монголбанкны дүгнэлт, саналыг Улсын Их Хурал, Засгийн газарт улирал бүр танилцуулах;

5) Монголбанкны жилийн өмнөх төлбөрийн баталгаа гаргах;

6) Монголбанкны үйл ажиллагаатай холбогдох асуудлаар тушаал гаргах, биелэлтийг хангуулах. Банкны хууль болон энэхүү дүрмийн хүрээнд банкны үйл ажиллагааны талаар нийт арилжааны банкинд дагаж мөрдөх дүрэм, заавар гаргах;

7) мөнгө, зээлийн бодлогыг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай асуудлаар Засгийн газартай хамтарч шийдвэр гаргах;

8) банкны мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх арга хэмжээ авах;

8. Монголбанкны Ерөнхийлөгчийн хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан тушаалыг холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, арилжааны банк дагаж мөрдөнө.

9. Монголбанкны Ерөнхийлөгч, тэргүүн дэд ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгчийг дор дурьдсан тохиолдолд албан тушаалаас нь чөлөөлөх асуудлыг Улсын Их Хурал шийдвэрлэнэ:

1) арилжааны банкны хувьцаа эзэмшигч болсон;

2) Монголбанкны эрх ашигт харш үйлдэл (эс үйлдэл) гаргасан;

3) биеийн эрүүл мэндийн байдал болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар албан үүргээ цаашид гүйцэтгэх боломжгүй гэж үзэж уг албан тушаалаас чөлөөлөх хүсэлт гаргасан;

4) үүрэгт ажлаа хангалтгүй гүйцэтгэсэн;

5) гэмт хэрэг үйлдсэнийг нь шүүх тогтоосон.

10. Монголбанкны Ерөнхийлөгчийн дэргэд тус банкны зорилт, бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон аливаа асуудлыг хэлэлцэж, зөвлөх эрх бүхий Зөвлөл ажиллана.

Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батална.

11. Монголбанкны ажилтан дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

1) аливаа аж ахуйн нэгж, байгууллагын ашиг сонирхлыг төлөөлөх;

2) өөртөө болон тэр бүх, төрөл төрөгсөд, ажил төрлийн болон бусад танил хүмүүст ашигтай давуу байдал бий болгох;

3) аливаа банк, аж ахуйн нэгж, байгууллага, иргэний данс, түүний гүйлгээтэй холбогдсон албан баримтыг хуульд заасанаас бусад тохиолдолд бусдад танилцуулах.

12. Монголбанкны ажилтан төрийн албан хаагчийн нэгэн адил хууль тогтоомжид заасан нийгмийн баталгаагаар хангагдана.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

*Монголбанкны үйл ажиллагаа*

13. Монголбанк мөнгөн тэмдэгт үйлдвэрлэх, хадгалах, гүйлгээнд гаргах, гүйлгээнээс татах, хүүгийн нэгдсэн бодлого явуулах, банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах, улсын валютын үнэт зүйлсийн нөөцийг хадгалах, нэмэгдүүлэх, төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг тогтоох, банк хоорондын валютын зах зохион байгуулах, арилжааны банкуудад зээл олгох, тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, үйл ажиллагаанд нь хяналт тавих замаар төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

14. Монголбанк төсвийн орлого, зарлагатай холбогдсон гүйлгээний ажлыг зохион байгуулж болно.

15. Монголбанкин дахь улсын валютын гадаад нөөц дараах хэлбэрээс бүрдэнэ:

1) мөнгөжсөн алт болон бусад үнэт металл;

2) өөрийн болон гадаад улсын банкны дансанд байгаа валют;

3) олон улсын хэмжээнд нөөцөд тооцогдох энэ зүйлийн 1, 2-д заасанаас бусад үнэт зүйлийн актив;

4) гадаадад чөлөөтэй тооцогдох вексель болон баталгаа бичиг;

5) гадаад орны зах зээл дээр борлогддог үнэт цаас;

6) олон улсын санхүүгийн байгууллагаас гаргасан үнэт цаас.

16. Монголбанк улсын валютын гадаад нөөцийн хөрөнгийг харьцуулан хадгалах бөгөөд уг хөрөнгийг харилцан тохиролцсон өөрийн болон гадаад улсын банкинд хадгалуулж болно.

17. Монголбанкны активын дансанд байгаа чөлөөт валют, үнэт металл, Олон улсын валютын сангийн тооцооны нэгж (SDR)-ийн төгрөгөөр илэрхийлэгдсэн үнэ нь төгрөгийн ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан өөрчлөгдсөн тохиолдолд гарсан орлого, зарлагыг тусгай дансанд бүртгэнэ. Тусгай дансны үл-

дэгдлийг Монголбанкны жилийн үр ашгийн тооцоонд оруулахгүй.

18. Монголбанк гадаад валютын гүйлгээнд хяналт тавих бөгөөд Монгол Улсад гадаад валютын зах байгуулан ажиллуулж болно.

19. Монголбанк тус улсын нутаг дэвсгэрт гадаадын банк, түүний салбар, төлөөлөгчийн газрыг байгуулах үйл ажиллагааг зохицуулах асуудлаар Засгийн газарт санал оруулна.

20. Монголбанк өөрийн бүх гүйлгээг холбогдох дансанд бүртгэж, сар бүрийн эцэст тайлан тэнцэл гаргана.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### *Монголбанкны үүрэг, эрх*

21. Монголбанк дараах үүрэг хүлээнэ:

1) төрийн мөнгөний бодлогын талаар санал боловсруулан зохих журмын дагуу батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

2) мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах, гүйлгээнээс татах үйл ажиллагааг зохион байгуулах, арилжааны банкинд гүйлгээнээс татан мөнгөний хэмжээг тогтоон өгч биелэлтэд нь хяналт тавих;

3) мөнгөний эргэлтийг түргэтгэх, төлбөр тооцоог шуурхай болгох, төлбөр тооцооны арга хэлбэрийг боловсронгуй болгох арга хэмжээ авах;

4) төрийн мөнгөний бодлогын хэрэгжилтийг арилжааны банкуудад шалгаж холбогдох арга хэмжээ авах;

5) төгрөгийн гадаад улсын валюттай харьцах ханшийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

6) валютын үнэт металл, үнэт чулуу, тэдгээрээр хийсэн эдлэл, соёлын дурсгалт зүйлийг худалдан авч улсын санг баяжуулах, тэдгээрийг засаж сэлбэх, худалдах, хадгалах, хадгалуулах, үзэсгэлэн гаргах;

7) олон улсын валютын болон банк, санхүүгийн байгууллагад гишүүнээр элсэх, хамтран ажиллах, тэдгээрийн үйл ажиллагаанд оролцох;

8) гадаад улсын Төв банк болон бусад банктай ажил хэргийн холбоо тогтоон, хамтран ажиллах

9) эх үүсвэртээ баттай ажил, үйлчилгээ явуулж байгаа арилжааны банкны заавал байх нөөцөд төвлөрүүлсэн хөрөнгөд хүү төлж байх.

22. Монголбанк дараах эрх эдэлнэ:

1) мөнгөн гүйлгээ, эмиссийн ажиллагаатай холбогдсон мэдээлэл, судалгааны материалыг арилжааны банкнаас гаргуулж авах, эдгээр мэдээ материалын хураангуй нэгтгэлийг хэвлэлд нийтлэх;

2) мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд зээл тооцоо, мөнгөн гүйлгээний үйлчилгээг хошуучлан болгон хэрэглэх, өөрийн үйлчилгээнд хүү, шимтгэлийн хэмжээг тогтоох;

3) төгрөгийн тогтвортой байдлыг хангах мөнгөний бодлогыг журамтай явуулах зорилгоор арилжааны банкинд олгох зээлийн хэмжээнд хязгаарлалт тогтоох;

4) бүх төрлийн үнэт цаасны гүйлгээ хийх, худалдах, худалдан авах;

5) алтан зоос буюу гулууз алт, бусад үнэт металлыг худалдах, худалдан авах, арилжих;

6) гадаад валютыг худалдах, худалдан авах, арилжих гадаадын банкинд данс нээх, гүйлгээ хийх;

7) гадаад улсын Засгийн газар, банк, байгууллага, олон улсын байгууллагын хүсэлтээр тэдний нэр дээр данс нээх, гүйлгээ хийх;

8) Банкны хууль болон түүнтэй нийцүүлж Монголбанкнаас гаргасан шийдвэрийг арилжааны банк зөрчсөн бол уг зөрчлийг арилгуулахаар шаардлага тавих, зээл олгох, бэлэн мөнгөөр хангахыг зогсоох, гадаад төлбөр тооцоо эрхлэх зөвшөөрлийг цуцлах, зохих хууль тогтоомжийн дагуу мөнгөн торгууль ногдуулах, банкны үйл ажиллагааг түдгэлзүүлэх буюу зогсоох, банк байгуулах зөвшөөрлийг хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авах;

9) аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн банкны үйл ажиллагаатай холбогдсон баримт материалыг шалган үзэх;

10) заавал байх нөөцийн доод хэмжээг хангаагүй арилжааны банкинд уг хэмжээг хангах хүртэлх хугацаанд нэмэгдүүлсэн хүү ногдуулж байх.

## ТАВДУГААР БҮЛЭГ

### *Монголбанкны сан хөмрөг*

23. Монголбанк нэг тэрбум төгрөгийн дүрмийн сантай байх бөгөөд энэ нь түүний хүлээх үүргийн баталгаа болно.

| | | |
|---|---|---|
| 2. Баян-Өлгий аймгийн давж заалдах шатны шүүх | 1 | 3 |
| 3. Баянхонгор аймгийн давж заалдах шатны шүүх | 1 | 3 |
| 4. Булган аймгийн давж заалдах шатны шүүх | 1 | 3 |
| 5. Говь-Алтай аймгийн давж заалдах шатны шүүх | 1 | 3 |
| 6. Дорноговь аймгийн давж заалдах шатны шүүх | 1 | 4 |
| 7. Дорнод аймгийн давж заалдах шатны шүүх | 1 | 4 |
| 8. Дундговь аймгийн давж заалдах шатны шүүх | 1 | 3 |
| 9. Завхан аймгийн давж заалдах шатны шүүх | 1 | 4 |
| 10. Өвөрхангай аймгийн давж заалдах шатны шүүх | 1 | 4 |
| 11. Өмнөговь аймгийн давж заалдах шатны шүүх | 1 | 3 |
| 12. Сүхбаатар аймгийн давж заалдах шатны шүүх | 1 | 3 |
| 13. Сэлэнгэ аймгийн давж заалдах шатны шүүх | 1 | 4 |
| 14. Төв аймгийн давж заалдах шатны шүүх | 1 | 4 |
| 15. Увс аймгийн давж заалдах шатны шүүх | 1 | 4 |
| 16. Ховд аймгийн давж заалдах шатны шүүх | 1 | 3 |
| 17. Хөвсгөл аймгийн давж заалдах шатны шүүх | 1 | 4 |
| 18. Хэнтий аймгийн давж заалдах шатны шүүх | 1 | 3 |
| 19. Дархан хот дахь давж заалдах шатны шүүх | 1 | 4 |
| 20. Эрдэнэт хот дахь давж заалдах шатны шүүх | 1 | 3 |
| 21. Нийслэлийн давж заалдах шатны шүүх | 1 | 14 |
| ДҮН | 21 | 83 |

Монгол Улсын Их Хурлын 1993 оны
45-р тогтоолын 2 дугаар хавсралт

## СУМ БОЛОН СУМ ДУНДЫН, ДҮҮРГИЙН ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН ОРОН ТОО

| Шүүхийн нэр | Шүүгчийн орон тоо | |
|---|---|---|
| | ерөнхий шүүгч | шүүгч |
| *Нэг. Сумын шүүх* | | |
| 1. Дорнод аймаг дахь сумын шүүх | 1 | 3 |
| 2. Чойр хот дахь сумын шүүх | 1 | 3 |
| *Хоёр. Сум дундын шүүх* | | |
| 1. Архангай аймаг дахь сум дундын шүүх | 1 | 6 |
| 2. Баян-Өлгий аймаг дахь сум дундын шүүх | 1 | 6 |
| 3. Баянхонгор аймаг дахь сум дундын шүүх | 1 | 6 |
| 4. Булган аймаг дахь сум дундын шүүх | 1 | 5 |
| 5. Говь-Алтай аймаг дахь сум дундын шүүх | 1 | 5 |
| 6 Дорноговь аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүх | 1 | 5 |
| 7. Дорноговь аймаг дахь сум дундын 2 дугаар шүүх | 1 | 3 |
| 8. Дорнод аймаг дахь сум дундын шүүх | 1 | 7 |
| 9. Дундговь аймаг дахь сум дундын шүүх | 1 | 5 |
| 10. Завхан аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүх | 1 | 6 |
| 11. Завхан аймаг дахь сум дундын 2 дугаар шүүх | 1 | 3 |
| 12. Өмнөговь аймаг дахь сум дундын шүүх | 1 | 6 |
| 13. Өвөрхангай аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүх | 1 | 4 |

| | | |
|---|---|---|
| 14. Өвөрхангай аймаг дахь сум дундын 2 дугаар шүүх | 1 | 3 |
| 15. Сүхбаатар аймаг дахь сум дундын шүүх | 1 | 5 |
| 16. Сэлэнгэ аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүх | 1 | 5 |
| 17. Сэлэнгэ аймаг дахь сум дундын 2 дугаар шүүх | 1 | 3 |
| 18. Төв аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүх | 1 | 6 |
| 19. Төв аймаг дахь сум дундын 2 дугаар шүүх | 1 | 3 |
| 20. Увс аймаг дахь сум дундын шүүх | 1 | 6 |
| 21. Ховд аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүх | 1 | 3 |
| 22. Ховд аймаг дахь сум дундын 2 дугаар шүүх | 1 | 2 |
| 23. Хөвсгөл аймаг дахь сум дундын шүүх | 1 | 7 |
| 24. Хэнтий аймаг дахь сум дундын шүүх | 1 | 7 |
| 25. Дархан хот дахь сум дундын шүүх | 1 | 7 |
| 26. Эрдэнэт хот дахь сум дундын шүүх | 1 | 5 |
| Гурав. *Дүүргийн шүүх* | | |
| 1. Багануур, Багахангай дүүргийн шүүх | 1 | 3 |
| 2. Баянгол дүүргийн шүүх | 1 | 8 |
| 3. Баянзүрх, Гачуурт дүүргийн шүүх | 1 | 7 |
| 4. Налайх дүүргийн шүүх | 1 | 2 |
| 5. Сонгинохайрхан, Жаргалант дүүргийн шүүх | 1 | 7 |
| 6. Сүхбаатар дүүргийн шүүх | 1 | 6 |
| 7. Хан-Уул, Туул дүүргийн шүүх | 1 | 6 |
| 8. Чингэлтэй дүүргийн шүүх | 1 | 6 |
| ДҮН | 36 | 180 |

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1993 оны 6 дугаар сарын 23-ны өдөр | Дугаар 46 | Улаанбаатар хот

# ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хууль батлагдсантай холбогдуулан дараахь арга хэмжээг 1993 оны 9 дүгээр сарын 1-ний дотор авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай:

1) Эрүүгийн байцаан шийтгэх болон Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль, бусад холбогдох хууль тогтоомжийг Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуультай нийцүүлэх асуудлыг боловсруулж Улсын Их Хуралд оруулах;

2) Эрүүгийн хуулийг 1987 оны 7 дугаар сарын 1-нээс хойшхи нэмэлт, өөрчлөлтийг тусгаж бүрэн эхээр нь хэвлүүлэх;

3) Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулийг сурталчлах ажлыг зохион байгуулах;

4) цаазаар авах ял шийтгэгдэж, амь үрэгдсэн этгээдийг өршөөх ялыг эдлүүлэх бэлтгэлийг хангах.

2. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулийг хууль хамгаалах байгууллагын ажилтнуудад тайлбарлан таниулах ажлыг зохион байгуулахыг Засгийн газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорт даалгасугай.

3. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай 1993 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуулийн 1, 2, 4 дүгээр зүйлд заасан ажиллагааг 1993 оны 9 дүгээр сарын 1-ний дотор, 3 дугаар зүйлд заасан

шилдэглэлийг 10 дугаар сарын 1-ний дотор багтаан хэрэгжүүлэхийг Засгийн газар, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорт даалгасугай.

Дарга — Н. БАГАБАНДИ

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1993 оны 6 дугаар сарын 24-ний өдөр — Дугаар 47 — Улаанбаатар хот

# МОНГОЛ УЛСЫН ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Зохиогчийн эрхийн тухай хууль батлагдсантай холбогдуулан доор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасугай:

1) Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасныг үндэслэн шинээр байгуулах зохиогчийн эрхийн байгууллагыг санхүүжүүлэх болон зохиогчийн эрхэд хамаарах бүтээл бүртгэх журмыг тогтоох, уг байгууллагын зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэх, тухайн байгууллагатай гэрээ байгуулах ажлыг энэ оны 9 дүгээр сарын 1-ний дотор багтаан хийх;

2) зохиогчийн эрхийг хамгаалах олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орох асуудлыг судлах;

3) энэ хуулийн биелэлтийн талаар 1994 оны 4 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд мэдээлэл хийх.

2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байнгын хороо (Ж. Батсуурь)-нд даалгасугай.

**Дарга** **Н. БАГАБАНДИ**

**Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга** **Н. РИНЧИНДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1993 оны 6 дугаар сарын 25-ны өдөр

Дугаар 43

Улаанбаатар хот

## СУМ БАЙГУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин долдугаар зүйлийн 3 дахь хэсэг, тавин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Архангай аймагт Цахир сум байгуулж, төвийг нь Хан-Уул гэж нэрлэсүгэй.

Цахир сумын хилийн цэсийг 1 дүгээр хавсралтаар, Тариат, Хангай сумын хилийн цэсийг 2, 3 дугаар хавсралтаар шинэчлэн баталсугай.

3. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу Цахир сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг байгуулах, Засаг даргыг томилох, Засаг даргын тамгын газрыг зохион байгуулах арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгасугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1977 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 75 дугаар зарлигийн 2 дугаар хавсралтын 8, 11 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

Дарга — Н. БАГАБАНДИ

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

Улсын Их Хурлын 1993 оны 48 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

## ЦАХИР

Загастайн даваа (2607,0), Загастайн гялгар уул (3130,8), 2705,0; 2924,5; 2829,5 тоотууд, Солонготын даваа (2575,0), 2873,6; 2946,3; 2768,7; 2808,0; 2856,6; 2546,0 тоотууд, Төмбөн уул (2599,0), 2299,4 тоот, Салтын дээд үзүүр (2309,4), Онгорхой дэрвээж, Авгалдай толгой (2245,0), Эмгэнт нуурааас 2,4 км-т хойт Тэрхийн гол гарч, Эмгэнт нуурын баруун эхээр Хар чулуут (2378,7), Буйруутын даваа (2527,0), Рэнчинлхүмбэ уул (2888,0), Онхотын дээд даваа (2629,0), Бодонт уул (3011,3), 2652,0; Ушиг (3182,0), Зурх (3227,9), Хужиртын голын 2531 тоот, 2934,0 Өлгийн голын зүүн нуруувы 2920,4 тоотууд, Хар усны даваа (2787,0), Өлгийн голын хойт хярын 3145,0 тоот, Хонгорын зүүн хяр (3338,7), Хонгорын даваа (3158,0), Хэргэлээтийн зүүн нуруувы 3123,4; 3142,0 тоотууд, Хэргэлээтийн даваа (2949,0), 3308,0 тоот, Бумбат уул (3261,9), 3321,0 тоот, Бумбатын даваа (2913,0), Туулай уул (3270,2), Хойт Тэрхийн эхний нуруувы 3312,1; 3178,0; 3156,4; 3241,5; 3222,9 тоотууд, Буянт даваа (2887,0), Тэвэгатайн нуруувы 3010,0; 3096,4; 3234,4; 2985,0; 3011,1; 2868,4 тоотууд, Марц уул (3205,3), 3165,0; 2643,0; 2837,0; 2885,4; 2842,0 тоотууд Загастайн даваа (2607,0).

---

Улсын Их Хурлын 1993 оны 48 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

# ТАРИАТ

2768,7 тоот, Нарийны нурууны 2799,2; 2901,0; 2802,0; 2656,2 тоотууд, Сээрийн даваа 2462,0 тоот, Ороохын даваа, Шарил уул (2877,1), 2650,6; 2764,4 тоотууд, Гурван даваа 2435,5; 1866,0 тоотууд, Өвөр нарийн голын баруун хамраар, Нарийн даваа (2150,0), Байцын даваа (2210,0), Гүртийн булуу уул (2906,6), Улаан булуу уул (2870,2), 2672,8 тоот, Харцатын даваа 2765,4 тоот, Алтайлын даваа (2455,5), Ногоон нуурын булуу уул (2874,7), Асгат булуу уул (2949,7), Гурван Яргайтын нуруугаар Нам уул (2442,2), Нам даваа (2367,5), 1521,3 тоот, Чулуут голын хойт эргээр өгсөн, Өндөр толгойн баруун суга (Чулуут-шаргачин голын уулзвараас доош 2,0 км), Чулуут голын урд эргээр өгсөн, Чулуут-Суман голын уулзвар, Дагвын гозгор (2096,3), Бөхөн нуруу (2300,1), Хүрэмийн даваа, Үст хоцын даваа, Барчингийн гозгор (2268,9), Халзан бүрэгтэй (2245,4), Онгийн даваа, Цагаан хадны булуу уул (2567,9), Шавартын давааны хойт гозгор (2418,5), Шавартын даваа, Хөхдавааны гозгор (2804,0), Хялалзахын овоо (2501,8), Өлзийт жалгын үзүүр, Тарвагатайн толгой, Овоон жалгын гозгор (2306,8), Цагаанчулуутын гозгор (2575,0), Мөстийн гозгор (2586,0), Цуврайн даваа, Ороохын гозгор (2628,5), Ноот даваа (өвөр давааны эхний даваа), Жаргалантын даваа, Цагаан өвөлийн гозгор (2391,4), Туулагч (дахилт 2461,2, Өлийн даваа, Баясгалант (2770,6), 2257,3 тоот, Мааньтын гарам, Шар шувуутын дорлж, Эмгэнтийн булуу (2601,0), Хар чулуут (2378,7), Эмгэнт нуурын баруун захаар хойт Тархийн гол гарч, Авгалдай толгой (2245,0), Онгорхой дорлж, Салтын дээд үзүүр (2309,4), 2299,4 тоот, Төмбөн уул (2599,0), 2546,0; 2856,6; 2808,0; 2768,7 тоотууд.

Улсын Их Хурлын 1993 оны 48 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

# ХАНГАЙ

Хар чулуут (2378,7), Эмгэнтийн булуу (2601,0), Шар шувуутын дэрлэж, Маньтын гарам, 2257,3 тоот, Баясгалант (2770,6), Өлийн даваа, Тууллагч (дахилт 2461,2), Цагаан өврийн гозгор (2391,4), Жаргалантын даваа, Ноот даваа (Өвөр даваагийн эхний даваа), Ороохын гозгор (2628,5), Цуврайн даваа, Мөстийн гозгор (2586,0), Цагаанчулуутын гозгор (2575,0), Овоон жалгын гозгор (2306,8), Тарвагатайн толгой, Өлзийт жалгын уэуур, Хиллаазахын овоо (2501,8), Хөх давааны гозгор (2804,0), Дайхын нуруу (2875,5), Хиллаазахын даваа, 2856,3 тоот, Эрдэнэ толгойтын шовх (2946,3), Бэрчийн уул (3037,7), Нам даваа, 3380,5 тоот, Гилгар уул (3327,6), Зүүн голын эхний хяр, 3000,8 тоот, Хавчигийн даваа, Хан жаргалантын нурууны 3119,1 тоот, Хайрхан даваа (2690,6), 3015,0 тоот, Хөх давааны урд нуруу, Хар халны даваа (2751,0), Уитаа ямаатын нурууны 3248,5 тоот, Нуурын даваа (2891,0), Арцатын голын эхний өндөр, Уитаа ямаатын эхний нурууны 3333,3; 3325,0; 3136,4 тоотууд, Шар усны даваа (2728,0), Алаг толгойн ам, Өгөөмөрийн өгсөл, Үнэгтийн зүүн нуруу (2842,0), Тээлийн даваа (2766,0), Цагаан жалгын эхний нуруу (3186,0), Билүүтийн голын эх, Хашлагатын голын зүүн нурууны 3025,0 тоот, Хашлагатын голын эхний 3346,8 тоот, Огтор эрээн уул (3317,7), Өнцгийн голын зүүн нурууны 2920,4 тоот, 2904,0 тоот, Хужиртын голын 2531,0 тоот, Зүрх (3227,9), Ужиг (3182,0), 2652,0 тоот, Бодонч уул (3011,3), Онхотын дээд даваа (2629,0), Равчинлхүмбэ уул (2888,0), Буйруутын даваа (2527,0), Хар чулуут уул (2378,3).

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1993 оны 6 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 49 | Улаанбаатар хот |

# МОНГОЛ УЛСЫН ПАТЕНТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Патентийн тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө олгосон шинэ бүтээлийн зохиогчийн гэрчилгээг шинэ бүтээлийн анхдагч огноонос хойш 20 жил, бүтээгдэхүүний загварын зохиогчийн гэрчилгээг бүтээгдэхүүний загварын анхдагч огноонос хойш 10 жилийн хугацаа өнгөрөөгүй байвал зохиогч, эсхүл түүнээс эрх шилжүүлэн авсан хувь хүн, хуулийн этгээдийн хүсэлтээр патентаар солихыг зөвшөөрсүгэй.

2. Монгол Улсын Патентийн тухай хуульд холбогдолтой журам, зааврыг батлан гаргах, хуулийг хэрэгжүүлэх талаар холбогдох бусад арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газар (П. Жасрай)-т даалгасугай.

| | |
|---|---|
| Дарга | Н. БАГАБАНДИ |
| Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга | Н. РИНЧИНДОРЖ |

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

| | | |
|---|---|---|
| 1993 оны 7 дугаар сарын 1-ний өдөр | Дугаар 50 | Улаанбаатар хот |

# М. ЭНХСАЙХАНЫГ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНЭЭС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 2-т заасныг үндэслэн Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Улсын Их Хурлын гишүүн Мэндсайханы Энхсайханыг гаргасан хүсэлтийг нь харгалзан Монгол Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлсүгэй.

**Дэд дарга** — **Э. ГОМБОЖАВ**

**Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга** — **Н. РИНЧИНДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1993 оны 7 дугаар сарын 1-ний өдөр | Дугаар 31 | Улаанбаатар хот |

# НИЙГМИЙН ДЭГ ЖУРАМ ХАНГАХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАН ЗОХИОН БАЙГУУЛАХ ТҮР ЗӨВЛӨЛ БАЙГУУЛАХ ТУХАЙ

Нийгмийн дэг журам, сахилга бат, зохион байгуулалтыг бэхжүүлэх, «Монгол Улсад нийгмийн дэг журам хангах талаар төрөөс явуулах үйл ажиллагааны үндсэн чиглэл»-ийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэхтэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн гаргасан саналыг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийгмийн дэг журам хангах талаар төр, олон нийт, аж ахуйн болон бусад байгууллагаас зохиох ажил, иргэдийн үүсгэл санаачилгыг нэгтгэн уялдуулан зохицуулах, энэ ажлын байдалд хяналт тавих, явц, үр дүнг нийтэд сурталчлах зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэд Нийгмийн дэг журам хангах ажлыг зохицуулан зохион байгуулах түр зөвлөл байгуулж, уг зөвлөлийн бүрэлдэхүүн болон дүрмийг Монгол Улсын Ерөнхийлөгч баталж мөрдүүлэх нь зүйтэй гэж үзсүгэй.

2. Нийгмийн дэг журам хангах ажлыг зохицуулан зохион байгуулах зөвлөлийн орон тооны бус салбар зөвлөлийг дэргэдээ байгуулж ажиллуулахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд даалгасугай.

3. Нийгмийн дэг журам хангах ажлыг зохицуулан зохион байгуулах түр зөвлөлийн ажлын явц, үр дүнгийн талаар Улсын Их Хурлын 1993 оны намрын чуулганд мэдээлэл хийхийг түр зөвлөлд даалгасугай.

| | |
|---|---|
| **Дарга** | Н. БАГАБАНДИ |
| **Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга** | Н. РИНЧИНДОРЖ |

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1993 оны 7 дугаар сарын 1-ний өдөр | Дугаар 52 | Улаанбаатар хот |

# ЗАРИМ ХҮНИЙГ ҮҮРЭГТ АЖЛААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 5 дахь заалт, Шүүхийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 8 дугаар зарлигаар Улсын дээд шүүхийн шүүгчээр томилогдсон Баасайн Дангаасүрэнг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүний, Рэгзэнгийн Жамъянчойжилыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний үүрэгт ажлаас тус тус чөлөөлсүгэй.

| | |
|---|---|
| Дарга | Н. БАГАБАНДИ |
| Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга | Н. РИНЧИНДОРЖ |

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

1993 оны 7 дугаар сарын 8-ний өдөр | Дугаар 53 | Улаанбаатар хот

# УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН А. ГАНБААТАРЫН БҮРЭН ЭРХИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ

А. Ганбаатарыг Улсын Их Хурлын гишүүнээр нөхөн сонгогдсонд тооцсон тухай Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хорооны 1993 оны 09 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 26 дугаар тойргоос Улсын Их Хурлын гишүүнээр нөхөн сонгогдсон Адъяагийн Ганбаатарын Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсүгэй.

Дарга — Н. БАГАБАНДИ

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1993 оны 7 дугаар сарын 9-ний өдөр

Дугаар 54

Улаанбаатар хот

## «50 ТӨГРӨГ», «100 ТӨГРӨГ»-ИЙН ДЭВСГЭРТИЙГ ХУУЛЬ ЁСНЫ ТӨЛБӨРИЙН ХЭРЭГСЭЛД ТООЦОХ, ГҮЙЛГЭЭНД ГАРГАХЫГ ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. «Мөнгөн тэмдэгтийн хэв загварыг батлах тухай» Улсын Бага Хурлын 1992 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 32 дугаар тогтоолын дагуу хэвлэгдсэн «50 төгрөг», «100 төгрөг»-ийн дэвсгэртийг Монгол Улсын хууль ёсны төлбөрийн хэрэгсэлд тооцсугай.

2. Бэлэн мөнгөний гүйлгээний байдал, хэрэгцээг харгалзан Монгол Улсын Банкны хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн «50 төгрөг», «100 төгрөг»-ийн дэвсгэртийг гүйлгээнд гаргахыг Монголбанк (Д. Моломжамц)-д зөвшөөрсүгэй.

3. Энэ тогтоолыг 1993 оны 7 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тогтоосугай.

Дарга — Н. БАГАБАНДИ

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1993 оны 7 дугаар сарын 9-ний өдөр | Дугаар 55 | Улаанбаатар хот |

# ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТИЙН ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 1993 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 5 дугаар дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 52 дугаар зарлиг, мөн оны 5 дугаар сарын 1-ний өдрийн 73 дугаар зарлиг нь Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, 7, гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтыг зөрчөөгүй гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээж авах нь зүйтэй гэж үзсүгэй.

| | |
|---|---|
| Дарга | Н. БАГАБАНДИ |
| Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга | Н. РИНЧИНДОРЖ |

| | | |
|---|---|---|
| 2. Баян-Өлгий аймгийн давж заалдах шатны шүүх | 1 | 3 |
| 3. Баянхонгор аймгийн давж заалдах шатны шүүх | 1 | 3 |
| 4. Булган аймгийн давж заалдах шатны шүүх | 1 | 3 |
| 5. Говь-Алтай аймгийн давж заалдах шатны шүүх | 1 | 3 |
| 6. Дорноговь аймгийн давж заалдах шатны шүүх | 1 | 4 |
| 7. Дорнод аймгийн давж заалдах шатны шүүх | 1 | 4 |
| 8. Дундговь аймгийн давж заалдах шатны шүүх | 1 | 3 |
| 9. Завхан аймгийн давж заалдах шатны шүүх | 1 | 4 |
| 10. Өвөрхангай аймгийн давж заалдах шатны шүүх | 1 | 4 |
| 11. Өмнөговь аймгийн давж заалдах шатны шүүх | 1 | 3 |
| 12. Сүхбаатар аймгийн давж заалдах шатны шүүх | 1 | 3 |
| 13. Сэлэнгэ аймгийн давж заалдах шатны шүүх | 1 | 4 |
| 14. Төв аймгийн давж заалдах шатны шүүх | 1 | 4 |
| 15. Увс аймгийн давж заалдах шатны шүүх | 1 | 4 |
| 16. Ховд аймгийн давж заалдах шатны шүүх | 1 | 3 |
| 17. Хөвсгөл аймгийн давж заалдах шатны шүүх | 1 | 4 |
| 18. Хэнтий аймгийн давж заалдах шатны шүүх | 1 | 3 |
| 19. Дархан хот дахь давж заалдах шатны шүүх | 1 | 4 |
| 20. Эрдэнэт хот дахь давж заалдах шатны шүүх | 1 | 3 |
| 21. Нийслэлийн давж заалдах шатны шүүх | 1 | 14 |
| ДҮН | 21 | 83 |

Монгол Улсын Их Хурлын 1993 оны
45-р тогтоолын 2 дугаар хавсралт

## СУМ БОЛОН СУМ ДУНДЫН ДҮҮРГИЙН ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН ОРОН ТОО

| Шүүхийн нэр | Шүүгчийн орон тоо | |
|---|---|---|
| | ерөнхий шүүгч | шүүгч |
| **Нэг. *Сумын шүүх*** | | |
| 1. Дорнод аймаг дахь сумын шүүх | 1 | 3 |
| 2. Чойр хот дахь сумын шүүх | 1 | 3 |
| **Хоёр. *Сум дундын шүүх*** | | |
| 1. Архангай аймаг дахь сум дундын шүүх | 1 | 6 |
| 2. Баян-Өлгий аймаг дахь сум дундын шүүх | 1 | 6 |
| 3. Баянхонгор аймаг дахь сум дундын шүүх | 1 | 6 |
| 4. Булган аймаг дахь сум дундын шүүх | 1 | 5 |
| 5. Говь-Алтай аймаг дахь сум дундын шүүх | 1 | 5 |
| 6 Дорноговь аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүх | 1 | 5 |
| 7. Дорноговь аймаг дахь сум дундын 2 дугаар шүүх | 1 | 3 |
| 8. Дорнод аймаг дахь сум дундын шүүх | 1 | 7 |
| 9. Дундговь аймаг дахь сум дундын шүүх | 1 | 5 |
| 10. Завхан аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүх | 1 | 6 |
| 11. Завхан аймаг дахь сум дундын 2 дугаар шүүх | 1 | 3 |
| 12. Өмнөговь аймаг дахь сум дундын шүүх | 1 | 6 |
| 13. Өвөрхангай аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүх | 1 | 4 |

| | | |
|---|---|---|
| 14. Өвөрхангай аймаг дахь сум дундын 2 дугаар шүүх | 1 | 3 |
| 15. Сүхбаатар аймаг дахь сум дундын шүүх | 1 | 5 |
| 16. Сэлэнгэ аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүх | 1 | 5 |
| 17. Сэлэнгэ аймаг дахь сум дундын 2 дугаар шүүх | 1 | 3 |
| 18. Төв аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүх | 1 | 6 |
| 19. Төв аймаг дахь сум дундын 2 дугаар шүүх | 1 | 3 |
| 20. Увс аймаг дахь сум дундын шүүх | 1 | 6 |
| 21. Ховд аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүх | 1 | 3 |
| 22. Ховд аймаг дахь сум дундын 2 дугаар шүүх | 1 | 2 |
| 23. Хөвсгөл аймаг дахь сум дундын шүүх | 1 | 7 |
| 24. Хэнтий аймаг дахь сум дундын шүүх | 1 | 7 |
| 25. Дархан хот дахь сум дундын шүүх | 1 | 7 |
| 26. Эрдэнэт хот дахь сум дундын шүүх | 1 | 5 |
| Гурав. *Дүүргийн шүүх* | | |
| 1. Багануур, Багахангай дүүргийн шүүх | 1 | 3 |
| 2. Баянгол дүүргийн шүүх | 1 | 8 |
| 3. Баянзүрх, Гачуурт дүүргийн шүүх | 1 | 7 |
| 4. Налайх дүүргийн шүүх | 1 | 2 |
| 5. Сонгинохайрхан, Жаргалант дүүргийн шүүх | 1 | 7 |
| 6. Сүхбаатар дүүргийн шүүх | 1 | 6 |
| 7. Хан-Уул, Туул дүүргийн шүүх | 1 | 6 |
| 8. Чингэлтэй дүүргийн шүүх | 1 | 6 |
| ДҮН | 36 | 180 |

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1993 оны 6 дугаар сарын 23-ны өдөр | Дугаар 46 | Улаанбаатар хот |

# ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хууль батлагдсантай холбогдуулан дараахь арга хэмжээг 1993 оны 9 дүгээр сарын 1-ний дотор авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай:

1) Эрүүгийн байцаан шийтгэх болон Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн хууль, бусад холбогдох хууль тогтоомжийг Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуультай нийцүүлэх асуудлыг боловсруулж Улсын Их Хуралд оруулах;

2) Эрүүгийн хуулийг 1987 оны 7 дугаар сарын 1-нээс хойших нэмэлт, өөрчлөлтийг тусгаж бүрэн эхээр нь хэвлүүлэх;

3) Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулийг сурталчлах ажлыг зохион байгуулах;

4) цаазаар авах ял шийтгэгдэж, амь уучлагдсан этгээдийн хорих ялыг эдлүүлэх бэлтгэлийг хангах.

2. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулийг хууль хамгаалах байгууллагын ажилтнуудад тайлбарлан таниулах ажлыг зохион байгуулахыг Засгийн газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорт даалгасугай.

3. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай 1993 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн хуулийн 1, 2, 4 дүгээр зүйлд заасан ажиллагааг 1993 оны 9 дүгээр сарын 1-ний дотор, 3 дугаар зүйлд заасан

ажиллагааг 10 дугаар сарын 1-ний дотор багтаан хэрэгжүүлэхийг Засгийн газар, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорт даалгасугай.

Дарга **Н. БАГАБАНДИ**

Төрийн газрын Ерөнхий нарийн бичгийн дарга **Н. РИНЧИНДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1993 оны 6 дугаар сарын 24-ний өдөр | Дугаар 47 | Улаанбаатар хот |

# МОНГОЛ УЛСЫН ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Зохиогчийн эрхийн тухай хууль батлагдсантай холбогдуулан доор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасугай:

1) Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасныг үндэслэн шинээр байгуулах зохиогчийн эрхийн байгууллагыг санхүүжүүлэх болон зохиогчийн эрхэд хамаарах бүтээл бүртгэх журмыг тогтоох, уг байгууллагын зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэх, тухайн байгууллагатай гэрээ байгуулах ажлыг энэ оны 9 дүгээр сарын 1-ний дотор багтаан хийх;

2) зохиогчийн эрхийг хамгаалах олон улсын гэрээ, конвенцэд нэгдэн орох асуудлыг судлах;

3) энэ хуулийн биелэлтийн талаар 1994 оны 4 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд мэдээлэл хийх.

2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байнгын хороо (Ж. Батсуурь)-нд даалгасугай.

Дарга — Н. БАГАБАНДИ

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1993 оны 6 дугаар сарын 25-ны өдөр — Дугаар 48 — Улаанбаатар хот

## СУМ БАЙГУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин долдугаар зүйлийн 3 дахь хэсэг, тавин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Архангай аймагт Цахир сум байгуулж, товчийг нь Хан-Уул гэж нэрлэсүгэй.

Цахир сумын хилийн цэсийг 1 дүгээр хавсралтаар, Тариат Хангай сумын хилийн цэсийг 2, 3 дугаар хавсралтаар шинэчлэн баталсугай.

3. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу Цахир сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг байгуулах, Засаг даргыг томилох, Засаг даргын тамгын газрыг зохион байгуулах арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгасугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1977 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 75 дугаар зарлигийн 2 дугаар хавсралтын 8, 11 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**Дарга** — **Н. БАГАБАНДИ**

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

Улсын Их Хурлын 1993 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

## ЦАХИР

Загастайн даваа (2607,0), Загастайн гялгар уул (3130,8), 2705,0; 2924,5; 2829,5 тоотууд, Солонготын даваа (2575,0), 2873,6; 2946,3; 2768,7; 2808,0; 2856,6; 2546,0 тоотууд, Тэмбон уул (2599,0), 2299,4 тоот, Салтын дээд узүүр (2309,4), Онгорхой доролж, Авгалдай толгой (2245,0), Эмгэнт нуураас 2,4 км-т хойт Тэрхийн гол гарч, Эмгэнт нуурын баруун захаар Хар чулуут (2378,7), Буйруутын даваа (2527,0), Рэнчиндумбэ уул (2888,0), Онхотын дээд даваа (2629,0), Бодонт уул (3011,3), 2652,0; Ужиг (3182,0), Зурх (3227,9), Хужиртын голын 2531 тоот, 2904,0 Өнгийн голын зүүн нуруугы 2920,4 тоотууд, Хярусны даваа (2787,0), Өнгийн голын хойт хярын 3145,0 тоот, Хонгорын зүүн хяр (3338,7), Хонгорын даваа (3158,0), Хянгалзаатийн зүүн нуруугы 3123,4; 3142,0 тоотууд, Хоргэлзэтийн даваа (2949,0), 3308,0 тоот, Бумбат уул (3261,9), 3321,0 тоот, Бумбатын даваа (2913,0), Туулай уул (3270,2), Хойт Тэрхийн эхний нуруугы 3312,1; 3178,0; 3156,4; 3241,5; 3222,9 тоотууд, Буянт даваа (2887,0), Тарвагатайн нуруугы 3010,0; 3096,4; 3234,4; 2985,0; 3011,1; 2868,4 тоотууд, Марц уул (3205,3), 3165,0; 2643,0; 2837,0; 2885,4; 2842,0 тоотууд Загастайн даваа (2607,0).

Улсын Их Хурлын 1993 оны 43 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

# ТАРИАТ

2768,7 тоот, Нарийны нуруунц 2799,2; 2901,0; 2802,0; 2656,2 тоотууд, Сээрийн давaa 2462,0 тоот, Ороохын давaa, Шарил уул (2877,1), 2650,6; 2764,4 тоотууд, Гурван давaa 2435,5; 1866,0 тоотууд, Өвөр нарийн голын баруун хамраар, Нарийн давaa (2150,0), Байцын давaa (2210,0), Гүртийн булуу уул (2906,6), Улаан булуу уул (2870,2), 2672,8 тоот, Харцатын давaa 2765,4 тоот, Алтайдын давaa (2455,5), Ногоон нуурын булуу уул (2874,7), Асгат булуу уул (2949,7), Гурван Яргайтын нуруугаар Нам уул (2442,2), Нам давaa (2367,5), 1521,3 тоот, Чулуут голын хойт эргээр өгсөн, Өндөр толгойн баруун суга (Чулуут-шаргачин голын уулзвараас доош 2,0 км), Чулуут голын урд эргээр өгсөн, Чулуут-Сумын голын уулзвар, Дагвын гозон (2096,3), Бахын нуруу (2300,1), Хүрэмийн давaa, Үст хонхын давaa, Барчингийн гозгор (2268,9), Халзан бүрэгтэй (2245,4), Онгийн давaa, Цагаан хадны булуу уул (2567,9), Шавартын давааны хойт гозгор (2418,5), Шавартын давaa, Хөхдавааны гозгор (2804,0), Хялгасын овоо (2501,8), Өлзийт жалгын уулзвар, Тарвагатайн толгой, Овоон жалгын гозгор (2306,8), Цагаанчулуутын гозгор (2575,0), Мөстийн гозгор (2586,0), Цуврайн давaa, Ороохын гозгор (2628,5), Ноот давaa (өвөр давааны эхний давaa), Жаргалантын давaa, Цагаан өврийн гозгор (2391,4), Тууллагч (лахилт 2461,2, Өлийн давaa, Баясгалант (2770,6), 2257,3 тоот, Маанытын гарам, Шар шуумтын доролж, Эмгэнтийн булуу (2601,0), Хар чулуут (2378,7), Эмгэнт нуурын баруун захаар хойт Тэрхийн гол гарч, Авгалдай толгой (2245,0), Онгорхой доролж, Салтын дээд уулзвар (2309,4), 2299,4 тоот, Тэмбөн уул (2599,0), 2546,0; 2856,6; 2808,0; 2768,7 тоотууд.

Улсын Их Хурлын 1993 оны 45 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

# ХАНГАЙ

Хар чулуут (2378,7), Эмээлтийн булуу (2601,0), Шар шувуутын доролж, Маанийн гарам 2257,5 тоот, Баясгалант (2770,6), Өлийн даваа, Туулагч (дахилт 2461,2), Цагаан өврийн гозгор (2591,4), Жаргалантын даваа, Ноот даваа (Өвөр даваа-ны эхний даваа), Ороохын гозгор (2628,5), Цуврайн даваа, Мостийн гозгор (2586,0), Цагаанчулуутын гозгор (2575,0), Оробн жалгын гозгор (2306,8), Тарвагатайн толгой, Өлзийт жалгын уууур, Хилалахын овоо (2501,8), Хөх давааны гозгор (2804,0), Дайхын нуруу (2875,5), Хилалзахын даваа, 2850,3 тоот, Эрдэнэ толгойтын шовх (2946,3), Бэрчиы уул (3037,7), Нам даваа, 3380,5 тоот, Галгар уул (3327,6), Зүүн голын эхний хяр, 3000,8 тоот, Хачигийн даваа, Ханжаргалантын нурууны 3119,1 тоот, Хайрхан даваа (2690,6), 3015,0 тоот, Хөх давааны урд нуруу, Хар халны даваа (2751,0), Унтаа ямаатын нурууны 3248,5 тоот, Нуурын даваа (2891,0), Арцатын голын эхний өндөр, Унтаа ямаатын эхний нурууны 3333,3; 3325,0; 3136,4 тоотууд, Шар усны даваа (2728,0), Алаг толгойн ам, Өгөөмөрийг өгсөө, Үнэгтийн зүүн нуруу (2842,0), Тээлийн даваа (2766,0), Цагаан жалгын эхний нуруу (3186,0), Билуутийн голын эх, Хашлагатын голын зүүн нурууны 3025,0 тоот, Хашлагатын голын эхний 3346,8 тоот, Огтор эрээн уул (3317,7), Өнцгийн голын зүүн нурууны 2920,4 тоот, 2904,0 тоот, Хужиртын голын 2531,0 тоот, Зүрх (3227,9), Ужиг (3182,0), 2652,0 тоот, Бодонч уул (3011,3), Онхотын дэвд даваа (2629,0), Рэнчинлхүмбэ уул (2888,0), Буйруутын даваа (2527,0), Хар чулуут уул (2378,3).

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН**
**ТОГТООЛ**

| | | |
|---|---|---|
| 1993 оны 6 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 49 | Улаанбаатар хот |

# МОНГОЛ УЛСЫН ПАТЕНТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Патентийн тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө олгосон шинэ бүтээлийн зохиогчийн гэрчилгээг шинэ бүтээлийн анхдагч огноонoос хойш 20 жил, бүтээгдэхүүний загварын зохиогчийн гэрчилгээг бүтээгдэхүүний загварын анхдагч огноонoос хойш 10 жилийн хугацаа өнгөрөөгүй байвал зохиогч, эсхүл түүнээс эрх шилжүүлэн авсан хувь хүн, хуулийн этгээдийн хүсэлтээр патентаар солихыг зөвшөөрсүгэй.

2. Монгол Улсын Патентийн тухай хуульд холбогдолтой журам, зааврыг батлан гаргах, хуулийг хэрэгжүүлэх талаар холбогдох бусад арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газар (П. Жасрай)-т даалгасугай.

| | |
|---|---|
| **Дарга** | **Н. БАГАБАНДИ** |
| Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга | **Н. РИНЧИНДОРЖ** |

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1993 оны 7 дугаар сарын 1-ний өдөр | Дугаар 50 | Улаанбаатар хот |

# М. ЭНХСАЙХАНЫГ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНЭЭС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 2-т заасныг үндэслэн Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Улсын Их Хурлын гишүүн Мэндсайханы Энхсайханыг гаргасан хүсэлтийг нь харгалзан Монгол Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлсүгэй.

**Дэд дарга** — **Э. ГОМБОЖАВ**

**Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга** — **Н. РИНЧИНДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1993 оны 7 дугаар сарын 1-ний өдөр

Дугаар 51

Улаанбаатар хот

# НИЙГМИЙН ДЭГ ЖУРАМ ХАНГАХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАН ЗОХИОН БАЙГУУЛАХ ТҮР ЗӨВЛӨЛ БАЙГУУЛАХ ТУХАЙ

Нийгмийн дэг журам, сахилга бат, зохион байгуулалтыг бэхжүүлэх, «Монгол Улсад нийгмийн дэг журам хангах талаар төрөөс явуулах үйл ажиллагааны үндсэн чиглэл»-ийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэхтэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн гаргасан саналыг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийгмийн дэг журам хангах талаар төр, олон нийт, аж ахуйн болон бусад байгууллагаас зохиох ажил, иргэдийн үүсгэл санаачилгыг нэгтгэж уялдуулан зохицуулах, энэ ажлын байдалд хяналт тавих, явц, үр дүнг нийтэд сурталчлах зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэд Нийгмийн дэг журам хангах ажлыг зохицуулан зохион байгуулах түр зөвлөл байгуулж, уг зөвлөлийн бүрэлдэхүүн болон дүрмийг Монгол Улсын Ерөнхийлөгч баталж мөрдүүлэх нь зүйтэй гэж үзсүгэй.

2. Нийгмийн дэг журам хангах ажлыг зохицуулан зохион байгуулах зөвлөлийн орон тооны бус салбар зөвлөлийг дэргэдээ байгуулж ажиллуулахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд даалгасугай.

3. Нийгмийн дэг журам хангах ажлыг зохицуулан зохион байгуулах түр зөвлөлийн ажлын явц, үр дүнгийн талаар Улсын Их Хурлын 1993 оны намрын чуулганд мэдээлэл хийхийг түр зөвлөлд даалгасугай.

**Дарга** — **Н. БАГАБАНДИ**

**Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга** — **Н. РИНЧИНДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1993 оны 7 дугаар сарын 1-ний өдөр | Дугаар 52 | Улаанбаатар хот |

## ЗАРИМ ХҮНИЙГ ҮҮРЭГТ АЖЛААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн 5 дахь заалт, Шүүхийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 8 дугаар зарлигаар Улсын дээд шүүхийн шүүгчээр томилогдсон Баасайн Дангаасүрэнг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүний, Рэгзэнгийн Жамьянчойжилыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний үүрэгт ажлаас тус тус чөлөөлсүгэй.

| | |
|---|---|
| Дарга | Н. БАГАБАНДИ |
| Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга | Н. РИНЧИНДОРЖ |

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН**
**ТОГТООЛ**

1993 оны 7 дугаар сарын 8-ний өдөр | Дугаар 53 | Улаанбаатар хот

# УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН А. ГАНБААТАРЫН БҮРЭН ЭРХИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ

А. Ганбаатарыг Улсын Их Хурлын гишүүнээр нөхөн сонгогдсонд тооцсон тухай Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хорооны 1993 оны 09 дүгээр тогтоолыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 26 дугаар тойргоос Улсын Их Хурлын гишүүнээр нөхөн сонгогдсон Адъяагийн Ганбаатарын Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсүгэй.

Дарга — **Н. БАГАБАНДИ**

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга — **Н. РИНЧИНДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1993 оны 7 дугаар сарын 9-ний өдөр | Дугаар 54 | Улаанбаатар хот |

# «50 ТӨГРӨГ», «100 ТӨГРӨГ»-ИЙН ДЭВСГЭРТИЙГ ХУУЛЬ ЁСНЫ ТӨЛБӨРИЙН ХЭРЭГСЭЛД ТООЦОХ, ГҮЙЛГЭЭНД ГАРГАХЫГ ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. «Мөнгөн тэмдэгтийн хэв загварыг батлах тухай» Улсын Бага Хурлын 1992 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 32 дугаар тогтоолын дагуу хэвлэгдсэн «50 төгрөг», «100 төгрөг»-ийн дэвсгэртийг Монгол Улсын хууль ёсны төлбөрийн хэрэгсэлд тооцсугай.

2. Бэлэн мөнгөний гүйлгээний байдал, хэрэгцээг харгалзан Монгол Улсын Банкны хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн «50 төгрөг», «100 төгрөг»-ийн дэвсгэртийг гүйлгээнд гаргахыг Монголбанк (Д. Моломжамц)-д зөвшөөрсугай.

3. Энэ тогтоолыг 1993 оны 7 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тогтоосугай.

Дарга Н. БАГАБАНДИ

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Н. РИНЧИНДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1993 оны 7 дугаар сарын 9-ний өдөр | Дугаар 55 | Улаанбаатар хот

# ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТИЙН ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 1993 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 5 дугаар дүгнэлтийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 52 дугаар зарлиг, мөн оны 5 дугаар сарын 1-ний өдрийн 73 дугаар зарлиг нь Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, 7, гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтыг зөрчөөгүй гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээж авах нь зүйтэй гэж үзсүгэй.

Дарга — Н. БАГАБАНДИ

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1993 оны 7 дугаар сарын 9-ний өдөр | Дугаар 56 | Улаанбаатар хот |

# Г. ГАНБОЛДЫГ ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮНЭЭР ТОМИЛОХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурлын гишүүн Гаанжуурын Ганболдыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилсугай.

Дарга — Н. БАГАБАНДИ

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга — Н. РИНЧИНДОРЖ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1993 оны 7 дугаар сарын 9-ний өдөр

Дугаар 57

Улаанбаатар хот

# УЛСЫН ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН 1992 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 10 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын 1992 оны улсын төвлөрсөн төсвийн орлогын гүйцэтгэлийг 6442075,5 мянган төгрөг, зарлагын гүйцэтгэлийг 5568569.9 мянган төгрөг, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн хөрөнгийн гүйцэтгэлийг 2175577,6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс улсын төвлөрсөн төсөвт татан авсан хөрөнгийн гүйцэтгэлийг 203846,2 мянган төгрөгөөр тус тус баталсугай.

Дарга — **Н. БАГАБАНДИ**

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга — **Н. РИНЧИНДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 1993 оны 7 дугаар сарын 9-ний өдөр | Дугаар 58 | Улаанбаатар хот |

# МОНГОЛ УЛСЫН 1993 ОНЫ УЛСЫН ТӨВЛӨРСӨН ТӨСӨВТ ТОДОТГОЛ ХИЙХ ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар Монгол Улсын 1993 оны улсын төвлөрсөн төсөвт тодотгол хийх тухай хуулийн төслийг хэлэлцэх явцад Байнгын хороод болон гишүүдээс гаргасан санал, дүгнэлтийг харгалзан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар (П. Жасрай)-т даалгасугай:

1) төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, орлогын нэмэгдэл эх үүсвэр бий болгох замаар төсвийн алдагдлын харьцангуй хэмжээг хадгалах чиглэл баримтлан зайлшгүй нэмэгдэж гарах зарим зардлыг санхүүжүүлэх;

2) Монгол Улсын 1993 оны улсын төвлөрсөн төсөвт тодотгол хийх тухай хуулийн биелэлтийн явцын талаар энэ оны 10 дугаар сард багтаан Улсын Их Хуралд илтгэх.

2. Монгол Улсын 1993 оны улсын төвлөрсөн төсвийн хууль, 1993 оны улсын төвлөрсөн төсөвт тодотгол хийх тухай хуулийн биелэлт болон төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлд хяналт тавьж, Улсын Их Хурлын гишүүдийг эдгээр асуудлын явцын талаар мэдээллээр хангаж байхыг Төсөв, санхүү, мөнгө, зээлийн бодлогын байнгын хороо (А. Базархүү)-нд даалгасугай.

| | |
|---|---|
| Дарга | Н. БАГАБАНДИ |
| Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга | Н. РИНЧИНДОРЖ |

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 1993 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр | Дугаар 59 | Улаанбаатар хот |

## ЗАРИМ ХҮНД МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Соёл, урлагийн байгууллагын урын санг баяжуулах, сонгодог урлагийг сурталчлах, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь өндөр үнэлж доор дурдсан хүмүүст Монгол Улсын ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН цол олгосугай.

### МОНГОЛ УЛСЫН УРЛАГИЙН ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН ЦОЛООР:

Вандангийн БОРОЛДОЙ — Дорнод аймгийн хөгжимт жүжгийн театрын хөгжмийн багш, хөгжмийн зохиолч

### МОНГОЛ УЛСЫН СОЁЛЫН ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН ЦОЛООР:

Данзанваанчигийн УХНАА — Улсын филармонийн дарга

### МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ЖҮЖИГЧИН ЦОЛООР:

Маравшийн НАЙДАЛМАА — Монголын урлагийн үндэсний их сургуулийн багш

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
**ЗАРЛИГ**

| | | |
|---|---|---|
| 1993 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр | Дугаар 60 | Улаанбаатар хот |

## Г. ДОЛГОРСҮРЭНД МОНГОЛ УЛСЫН АРДЫН ЗҮТГЭЛТЭН ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Монгол ардын бүжгийн их уламжлалыг залуу үед зааж сургах, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулж байгааг нь өндөр үнэлж Хөгжмийн коллежийн багш Гарамын ДОЛГОРСҮРЭНД Монгол Улсын АРДЫН БАГШ цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
**ЗАРЛИГ**

| | | |
|---|---|---|
| 1993 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр | Дугаар 61 | Улаанбаатар хот |

## ЗАРИМ ХҮНД МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ БАГШ ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Боловсролын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж өсвөрийн болон залуу үеийг сургаж хүмүүжүүлэх, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх үйлсэд оруулж байгаа хувь нэмрийг

нэ өндөр үнэлж доор дурдсан хүмүүст Монгол Улсын Гавьяат багш цол олгосугай.

1. Мүберекийн АМАНТАЙ — Баян-Өлгий аймгийн Өлгий хотын 10 жилийн 11 сургуулийн бага ангийн багш
2. Лувсаншагдарын БАЛЖИД — Нийслэлийн 112 дугаар цэцэрлэгийн эрхлэгч
3. Балсангийн БОР — Монгол Улсын Үндэсний их сургуулийн багш
4. Содномжамцын НОРОВСАМБУУ — Мөн сургуулийн тэнхимийн эрхлэгч
5. Ширнэнгийн ОТГОН — Нийслэлийн 10 жилийн 37 дугаар сургуулийн газар зүйн багш

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

1993 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр — Дугаар 62 — Улаанбаатар хот

## ЗАРИМ БАГШ, СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭГЧИЙГ ОДОН, МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ

Боловсролын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж өсвөрийн болон залуу үеийг сурган хүмүүжүүлэх, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж доор дурдсан багш, сурган хүмүүжүүлэгчийг Монгол Улсын одон, медалиар шагнасугай.

## ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Магадсамбын БАНЗРАГЧ — Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 10 жилийн 1 дүгээр сургуулийн математикийн багш
2. Гүнчингийн ДАШДАВАА — Хөгжмийн коллежийн багш
3. Дүүрэнгийн РЭНЦЭН — Нийслэлийн 10 жилийн 6 дугаар дунд сургуулийн хөдөлмөр амралтын зуслангийн захирал, агроном
4. Сумъягийн СУГАР — Монголын урлагийн үндэсний их сургуулийн тэнхимийн эрхлэгч
5. Сундуйн ЦЭВЭЛМАА — Хөгжмийн коллежийн багш

## АЛТАН ГАДАС ОДОНГООР:

1. Гончигийн БАЗАР — Техникийн их сургуулийн багш
2. Даваажавын БАЗАРДОРЖ — Монгол Улсын тидэсний их сургуулийн багш
3. Мөнхнасангийн БАЯНТӨР — Мед сургуулийн тэнхимийн эрхлэгч
4. Чойжавын БЯМБАА — Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 10 жилийн 3 дугаар сургуулийн бага ангийн багш
5. Шаравын ГАВАА — Нийслэлийн 10 жилийн 6 дугаар сургуулийн химийн багш
6. Лхамын ГАНТӨМӨР — Мед сургуулийн хичээлийн эрхлэгч
7. Бямбын ӨЛЗИЙБАТ — Мед сургуулийн түүх-газарзүйн багш

8. Гэндэнгийн СУМАА — Өмнөговь аймгийн Баяндалай сумын дунд сургуулийн газар зүйн багш

9. Чоймболын ТОГООХҮҮ — Мөн аймгийн Даланзадгад сумын 10 жилийн 2 дугаар сургуулийн захирал

10. Нямринчингийн ТӨМӨРБААТАР — Техникийн их сургуулийн механик технологийн сургуулийн захирал

11. Нанзадын ЦЭВЭЭН — Нийслэлийн 10 жилийн 1 дүгээр сургуулийн монгол хэл-уран зохиолын багш

12. Бадамын ЦЭРЭНДУЛАМ — Мөн сургуулийн эмнэлийн эрхлэгч

## ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Самдангийн АЛИМАА — Нийслэлийн 10 жилийн 6 дугаар сургуулийн орос хэлний багш

2. Содовжамцын БААСАНДАРЬ — Нийслэлийн 110 дугаар цэцэрлэгийн нярав

3. Цэвээнжавын БАЗАРГҮР — Нийслэлийн 10 жилийн 6 дугаар дунд сургуулийн биеийн тамирын багш

4. Баямбаагийн БАТАА — Налайх дүүргийн 8 жилийн 4 дүгээр сургуулийн монгол хэл-уран зохиолын багш

5. Готовын БҮЖИЙ — Нийслэлийн 164 дүгээр цэцэрлэгийн тогооч

6. Намжилын ГАНЗОРИГ — Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 10 жилийн 2 дугаар сургуулийн биеийн тамирын багш

7. Очирын ГЭРЭЛ — Техникийн их сургуулийн тэнхимийн эрхлэгч

8. Навааны ДАГВАДОРЖ — Нийслэлийн 10 жилийн 6 дугаар сургуулийн физик-математикийн багш

| | |
|---|---|
| 9. Аюурганийн ДОРЖГОТОВ | — Монгол Улсын үндэсний их сургуулийн багш |
| 10. Шаравын ДУГАР | — Нийслэлийн 164 дүгээр цэцэрлэгийн ахлах тогооч |
| 11. Түндэвийн ДУЛМАА | — Нийслэлийн 10 жилийн 1 дүгээр сургуулийн орос хэлний багш |
| 12. Гомбодоржийн ЛХАГВА | — Мөн сургуулийн бага ангийн багш |
| 13. Чултэмийн МАГВАН | — Өмнөговь аймгийн Баяндалай сумын 10 жилийн дунд сургуулийн монгол хэл-уран зохиолын багш |
| 14. Балангаравын МӨНХТУЯА | — Мөн аймгийн Даланзадгад сумын 10 жилийн 2 дугаар сургуулийн бага ангийн багш |
| 15. Цэндийн ОТГОНСҮРЭН | — Нийслэлийн 49 дүгээр цэцэрлэгийн тогооч |
| 16. Содномдаржаагийн ОЮУНЦЭЦЭГ | — Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 10 жилийн 2 дугаар сургуулийн монгол хэл-уран зохиолын багш |
| 17. Авдангийн СОСОРБАРАМ | — Монголын урлагийн үндэсний их сургуулийн багш |
| 18. Сүнрэвийн ШООВДОР | — Нийслэлийн 49 дүгээр цэцэрлэгийн туслах багш |

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр — Дугаар 63 — Улаанбаатар хот

## ЗАРИМ ХҮНИЙГ ОДОН, МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ

Улсын филармонийн симфони найрал хөгжимд олон жил үр бүтээлтэй ажиллаж, сонгодог болон эстрадын урлагийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулж байгааг нь үнэлж, доор дурдсан хүмүүсийг Монгол Улсын одон, медалиар шагнасугай.

### АЛТАН ГАДАС ОДОНГООР:

1. Пүрэвжавын ЖҮГДЭРНАМЖИЛ — Улсын филармонийн симфони найрал хөгжимд хөгжимчин
2. Цэрэнжавын БАТСАЙХАН — Мөн хөгжимд хөгжимчин
3. Тогоруугийн ОЮУНЖАРГАЛ — Мөн хөгжимд хөгжимчин
4. Гончигдоржийн ГОМБО-ОЧИР — Мөн хөгжимд хөгжимчин

### ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Пүрэвгэлийн ГАНБААТАР — Мөн хөгжимд хөгжимчин
2. Ранжавын БААСАН — Мөн хөгжимд хөгжимчин
3. Бадамдоржийн ГАНБАТ — Мөн хөгжимд хөгжимчин
4. Нямаагийн ТУУЛАЙХҮҮ — Мөн хөгжимд хөгжмийн удирдаач

Монгол Улсын Ерөнхийлөгч — П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ

1993 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр | Дугаар 64 | Улаанбаатар хот

## Б. ДОЖИЙ, Д. ГАНБААТАР НАРЫГ ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР НЭХЭН ШАГНАХ ТУХАЙ

Улсын цирк олон жил үр бүтээлтэй ажиллаж байсныг нь үнэлж улсын циркийн мал маллагч Батын ДОЖИЙ, Улсын циркийн жүжигчин Дагвадоржийн ГАНБААТАР нарыг ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН одонгоор тус тус нэхэн шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ

1993 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр | Дугаар 65 | Улаанбаатар хот

## ЗАРИМ ХҮНИЙГ ОДОН, МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ

Улсад олон жил үр бүтээлтэй ажиллаж, үүрэгт ажлаа хариуцлагатай гүйцэтгэн амжилт гаргаж байгааг үнэлж Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын дор дурдсан хүнийг Монгол Улсын одон, медалиар шагнасугай.

## ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

Данзантийн ДАВААДОРЖ — Төр, засгийн үйлчилгээний авто баазын жолооч

## АЛТАН ГАДАС ОДОНГООР:

1. Ошлтын ПҮРЭВ — Төрийн ордны сантехникийн механикч
2. Түвийн ПҮРЭВ — Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын нэгтгэл бодогч
3. Естийн ҮРЖИНСҮРЭН — Төрийн ордны лифтийн үйлчлэгч

## ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Цэвэгдоржийн ДАШДАВАА — Төрийн ордны үйлчлэгч
2. Нямжилын ДОРЖПАЛАМ — Пропускийн товчооны үйлчлэгч
3. Бадарчийн НАНСАЛМАА — Хэвлэх үйлдвэрийн генераторчин
4. Яндагийн ӨНӨРБАЯР — Зохион байгуулах ангийн оёдолчин
5. Навааны ЧОЙМБОЛ — Үйлчилгээний авто баазын засварын мастер

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр | Дугаар 66 | Улаанбаатар хот

### Л. БАТСҮХИЙГ АЛТАН ГАДАС ОДОНГООР ШАГНАХ ТУХАЙ

Хэвлэл, мэдээллийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгааг үнэлж Монгол Улсын төрийн төв хэвлэл «Ардын эрх» сонины менежер-сурвалжлагч Лувсандамдингийн БАТСҮХИЙГ АЛТАН ГАДАС одонгоор шагнасугай.

**Монгол Улсын Ерөнхийлөгч** **П. ОЧИРБАТ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр | Дугаар 67 | Улаанбаатар хот

### С. ГОНГОР, Д. ЭНХТАЙВАН НАРЫГ «ШУДАРГА ЖУРАМ» МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ

Эр зориг, авхаалж самбаа гарган усны аюулаас гурван хүний амь аварч иргэний хүмүүнлэг үүргээ нэр төртэй биелүүлснийг үнэлж Нийслэлийн Налайх дүүргийн Шилний үйлдвэрийн Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга Сахилгын ГОНГОР, Гэрэлтүүлэг, чимэглэлийн компанийн ажилчин Дугарсүрэнгийн

ЭНХТАЙВАН нарыг «ШУДАРГА ЖУРАМ» медалиар тус тус шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр | Дугаар 68 | Улаанбаатар хот

## Ч. БЯМБААГ «ШУДАРГА ЖУРАМ» МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ

Эр зориг, авхаалж самбаа гарган гадны аюулаас хоёр хүүхдийн амь аварч иргэний хүмүүжлээ үүргээ нэр төртэй биелүүлснийг үнэлж Нийслэлийн Баянзүрх дүүргийн Цагдаагийн хэлтсийн цагдаа Чойжинниямын БЯМБААГ «ШУДАРГА ЖУРАМ» медалиар шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 1993 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр | Дугаар 69 | Улаанбаатар хот |

## ЗАРИМ ХҮНИЙГ НАЙРАМДАЛ МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ

Монгол Улсад олон жил үр бүтээлтэй ажиллаж манай орны геологийн судалгааг хөгжүүлэх, геологчдын мэргэшлийг дээшлүүлэхэд оруулсан хувь нэмрийг үнэлж Оросын Холбооны Улсын «Геологоразведка» концерны төлөөлөгчийн газрын захирал Борис Ефимович МИЛЕЦКИЙ, Эрхүү хотын «Сосновгеология» үйлдвэрийн ангийн дарга Юрий Борисович МИРОНОВ нарыг НАЙРАМДАЛ медалиар шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ

| | | |
|---|---|---|
| 1993 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр | Дугаар 70 | Улаанбаатар хот |

## ЗАРИМ ХҮНИЙГ АЛБАН ТУШААЛААС НЬ ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, өөрийнх нь хүсэлтийг үндэслэн Дамбын Сандуйжавыг Улсын дээд шүүхийн гишүүний албан

тушаалаас 1992 оны 7 дугаар сарын 26-ны өдрөөс, Жамсрангийн Оюунчимэгийг Улаанбаатар хотын төмөр замын тусгай шүүхийн гишүүний албан тушаалаас 1992 оны 4 дүгээр сарын 9-ний өдрөөс, Доржийн Ваанчигийг Өвөрхангай аймгийн Шүүхийн даргын, Тогтохын Байгалмаагийг Говь-Алтай аймгийн шүүхийн даргын, Дашдондогийн Сэсээрийг Сэлэнгэ аймгийн шүүхийн орлогч даргын, Ахинаагийн Бямбажавыг Эрдэнэт хотын шүүхийн орлогч даргын, Манараадын Нүрзэдийг Улаанбаатар хотын шүүхийн гишүүний, Гунгаагийн Тогоочийг Сүхбаатар аймгийн хэсгийн шүүхийн шүүгчийн, Өрлөөгийн Ичинхорлоог Хөвсгөл аймгийн хэсгийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас 1993 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс тус тус чөлөөлсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч — П. ОЧИРБАТ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 5 дугаар сарын 1-ний өдөр — Дугаар 73 — Улаанбаатар хот

## ЗАРЛИГТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

«Дэлхийн монголчуудын «Их чуулган» зохион байгуулах тухай» Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 52 дугаар зарлигийн 2 дугаар зүйлийг «2. Дэлхийн монголчуудын «Их чуулган»-ыг 1993 оны 9 дүгээр сарын 13—20-нд Улаанбаатар хотноо чуулуулахад санхүүгийн болон зохион байгуулалтын дэмжлэг туслалцаа үзүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосугай» гэж өөрчлөн найруулсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч — П. ОЧИРБАТ

Монгол Улсын Ерөнхий сайд — П. ЖАСРАЙ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 6 дугаар сарын 3-ны өдөр

Дугаар 75

Улаанбаатар хот

### Ю. ЖАРГАЛД ХОШУУЧ ГЕНЕРАЛ ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Барилгын цэргийн ерөнхий газрын дарга хурандаа Юлтын Жаргалд хошууч генерал цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 6 дугаар сарын 3-ны өдөр

Дугаар 76

Улаанбаатар хот

### УЛСЫН МӨРДӨН БАЙЦААХ БАЙГУУЛЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ ТАЛААР ЧИГЛЭЛ ӨГӨХ ТУХАЙ

Улсын мөрдөн байцаах байгууллагыг бэхжүүлэх талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосугай:

1) улсын мөрдөн байцаах байгууллагыг үйл ажиллагааны хувьд бие даалгаж хараат бус байдлыг хангах асуудлыг судалж, тогтолцоог нь боловсронгуй болгох арга хэмжээг энэ оны III улиралд багтаан авч шийдвэрлэх;

2) улсын мөрдөн байцаах байгууллагыг төсөв хөрөнгө, техник хэрэгсэл, ажиллах нөхцөлөөр хангах арга хэмжээг тусгайлан боловсруулж хэрэгжүүлэн үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах нөхцлийг бүрдүүлэх;

3) улсын мөрдөн байцаах байгууллагын ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх тогтолцоог бүй болгож ажиллагсдын нийгмийн баталгааг хангах арга хэмжээ авах.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

Монгол Улсын Ерөнхий сайд П. ЖАСРАЙ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 6 дугаар сарын 4-ний өдөр — Дугаар 77 — Улаанбаатар хот

## А. А. БЕЛИНКИН, Л. И. ЖУКОВСКАЯ НАРЫГ ОДОНГООР ШАГНАХ ТУХАЙ

Манай улсын түлш, эрчим хүчний салбарыг хөгжүүлэх үйлсэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Оросын Холбооны Улсын Санктпетрбург хот дахь «Гипрошахт» институтийн зураг төслийн ерөнхий инженер Анри Арнольдович БЕЛИНКИНИЙГ «ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГ»-ийн одонгоор, Москва хот дахь «Внииэнергопром» институтийн ерөнхий технологич Лидия Ивановна ЖУКОВСКАЯГ «АЛТАН ГАДАС» одонгоор шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

199[illegible] оны 6 дугаар сарын 4-ний өдөр — Дугаар 78 — Улаанбаатар хот

### Т. В. СТЕПАНОВАГ «АЛТАН ГАДАС» ОДОНГООР ШАГНАХ ТУХАЙ

Монгол Улсад олон жил бүр бүтээлтэй ажиллаж амжилт гаргасан байгааг нь үнэлж Төрийн ордны гуанзны тогооч Татьяна Васильевна СТЕПАНОВА-г «АЛТАН ГАДАС» одонгоор шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

199[illegible] оны 6 дугаар сарын 4-ний өдөр — Дугаар 79 — Улаанбаатар хот

### Г. ЭНХ-АМГАЛАНГ «ШУДАРГА ЖУРАМ» МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ

Эр зориг, шалмаг самбаа гарган усны аюулаас хүүхдийн амь насыг аварч иргэний хүмүүнлэг үүргээ нэр төртэй биелүүлснийг нь үнэлж Цагдаагийн ерөнхий газрын Дотоодын цэргийн 05 дугаар хорооны байлдагч Галаарайдын ЭНХ-АМГАЛАНГ «ШУДАРГА ЖУРАМ» медалиар шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

1993 оны 5 дугаар сарын 26-ны өдөр — Дугаар 03 — Улаанбаатар хот

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн бүх гишүүдийн хуралдааныг Цэцийн дарга Г. Совд даргалж, гишүүн Г. Нямдоо, Л. Баасан, Ц. Цолмон, Н. Жанцан, Ж. Чойжанцан, Б. Дангаасүрэн нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Б. Цэндээхүүг оролцуулан хийв.

Цэцийн хуралдаанаар БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1990 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 99 дүгээр зарлигаар батлагдсан «Хамт олны хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх дүрэм»-ийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуульд харшилж байгаа тухай иргэн Дондовын Лхамжавын өргөдлөөр үүссэн маргааныг Үндсэн хуулийн цэцийн 1993 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд: «БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1990 оны 99 дүгээр зарлигаар батлагдсан «Хамт олны хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэх дүрэм»-ийн 5, 6, 9, 12 дугаар зүйлийн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, 47 дугаар зүйлд харшилж байгаа тул Үндсэн хуулийн Хавсралт хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар хүчингүй болгох ёстой байжээ» гэсэн 2 дугаар дүгнэлттэй маргааныг эцэслэн хэлэлцэв.

Цэцийн хуралдаанд маргагч талуудыг төлөөлж Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Ц. Шаравдорж, Ж. Бямбажав, өргөдөл гаргасан иргэн Д. Лхамжав нар оролцов.

Монгол Улсын иргэн Дондовын Лхамжав Үндсэн хуулийн цэцэд гаргасан өргөдөлдөө: «БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1990 оны 99 дүгээр зарлигаар батлагдсан «Хамт олны хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх дүрэм» нь Монгол Улсын Үндсэн хуульд харшилж байна. Хэрэв энэхүү дүрэм нь Үндсэн хуульд харшилж байгаа нь тодорхой бол Үндсэн хуулийн Хавсралт хуулийн 5 дугаар зүйлийн 3, 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдөр хүчингүй болох ёстой. Гэтэл Засгийн газар ажил хаялт бүрийн эсрэг дээрх дүрмийг баримтална гэж удаа дараа мэдэгдсээр байна

Харин энэхүү дүрэм Үндсэн хуульд нийцээгүй, тэр тусмаа хориглосон бол шүүх түүнийг баримтлан хэрэг шийдвэл Үндсэн хуулийн Хавсралт хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь заалтыг зөрчих болно. Нэг үгээр хэлбэл энэ дүрмийг тойрон олон хүн хэлэлцэж маргаан дагдсаар байгаа тул Үндсэн хуулийн цэцэд хэлэлцэн дээрх дүрэм нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт гаргаж өгнө үү» гэжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 1993 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 2 тоот дүгнэлтээрээ: «БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1990 оны 99 дүгээр зарлигаар батлагдсан «Хамт олны хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх дүрэм»-ийн 5, 6, 12 дугаар зүйлд тусгагдсан хөндлөнгийн шүүхтэй холбоотой заалтууд, мөн дүрмийн 9 дүгээр зүйлийн ажил хаялт хориглосон субъектуудыг Монгол Улс нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээрээс хэт өргөтгөсөн, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлд хөдөлмөрийн хамтын маргааныг шийдвэрлэх эрх хэмжээ олгосон заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, 47 дугаар зүйлтэй харшилж байгаа тул Үндсэн хуулийн Хавсралт хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасаар хүчингүй болох ёстой байжээ. Харин эдгээр заалтуудыг холбогдох эрх бүхий байгууллагууд үйл ажиллагаандаа одоо болтол хэрэглэж, удирдлага болгосоор байгааг харгалзан Монгол Улсын Их Хурал Үндсэн хууль зөрчсөн дээрх заалтуудыг тухайлан хүчингүй болгох нь зүйтэй. Харин хөдөлмөрийн хамтын маргааны зохигч болох Монгол Улсын Засгийн газар, түүний үйл ажиллагаанд хяналтгүй байгаа нь Үндсэн хуулийн үзэл санаанд нийцэхгүй байна гэсэн хэсгийг хэрэгсэхгүй болгожээ.

Үндсэн хуулийн цэцийн энэхүү дүгнэлтийг авч хэлэлцээд гаргасан Монгол Улсын Их Хурлын 1993 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 33 дугаар тогтоол: «БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1990 оны 99 дүгээр зарлигаар батлагдсан «Хамт олны хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх дүрэм»-ийн 5, 6, 9, 12 дугаар зүйлийн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, 47 дугаар зүйлд харшилж байгаа тул Монгол Улсын Үндсэн хуулийн Хавсралт хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар хүчингүй болох ёстой байжээ гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээж авах боломжгүй гэж үзсүгэй» гэжээ.

Цэцийн хуралдаанд оролцсон Д. Ламжав мэдүүлэхдээ: «Би маргаан байгаа асуудлаар Цэцийн урьдах хуралдаан

болон Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны хуралд тодорхой ярьсан, түүнчлэн тайлбараа бичгээр гаргаж та бүхэнд хүргүүлсэн учраас энэ удаа цаг хэмнэж дэлгэрэнгүй ярих шаардлагагүй гэж үзэж байна. Үндсэн хуулийн цэцэд гаргасан өргөдлийн дагуу асуудлыг шийдвэрлэнэ гэдэгт итгэж байгаагаа нэрхийлээд тодруулах асуудал байвал мэтгэлцээний явцад ярилцах саналтай байна» гэв.

Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Ц. Шаравдорж Цэцийн хуралдаанд мэдүүлэхдээ: «Энэ асуудлаар Хууль зүйн байнгын хороо, Улсын Их Хурлын чуулганд тодорхой ярилцсан учраас товч тайлбар хэлье. Хамт олны хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх үүрэг бүхий хөндлөнгийн шүүх нь Үндсэн хуульд заасан шүүхийн тогтолцоонд хамаарагдахгүй, уг хэлэлцэн шийдвэрлэх асуудал нь шүүхийн эрх мэдлийн биш, хөндлөнгийн шүүхийн үйл ажиллагаа нь Эрүү, иргэний байцаан шийтгэх хуулийн дагуу явагддаггүй. Түүнчлэн хөндлөнгийн шүүх гэсэн ойлголт дэлхийн олон улс, орны практикт байдаг байна. Иймч учраас Үндсэн хуулийн дагуу байгуулагдсан шүүх, хөндлөнгийн шүүхийн хоорондын зарчмын олон ялгаа байдгийг хорооны дүгнэлтэд тодорхой дурдсан. Хөндлөнгийн шүүх гэдгийг шүүх гэдэг утгаар нь бус үйл ажиллагааны асуудлаар нь ойлгох нь зүйтэй учир энэ талаарх дүгнэлтийг хүлээж авах боломжгүй юм.

Дүрмийн 9 дүгээр зүйлд ажил хаяж болохгүй субъектуудыг өргөтгөж заажээ гэх үндэслэлгүй бөгөөд тодорхой улс орны онцлогт тохируулан тогтоож болох талтай. Нэгдсэн орсон олон улсын гэрээг үг үсгээр биелүүлэх албагүй, ерөнхий зарчимд л тааруулж байх ёстой учраас Үндсэн хуульд харшлахгүй гэж үзнэ.

Засгийн газар нь гүйцэтгэх дээд байгууллагын хувьд тодорхой салбар хариуцсан байгууллагын шийдвэрийн талаар гарсан гомдлыг хянан шийдвэрлэдэг нийтлэг журамтай. Иймд «Хамт олны хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх дүрэм»-ийн 5, 6, 9, 12 дугаар заалтууд Үндсэн хуульд харшлахгүй гэж үзэж байна» гэв.

Үндсэн хуулийн цэцийн бүх гишүүд хуралдааны хавтас материалд авагдсан нотолгоонуудыг нэгбүрчлэн судлан үзэж, маргалдаж байгаа асуудлаар талууд мэтгэлцэх зарчмын дагуу явагдлаа.

ХЯНАВАЛ:

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн бүх гишүүдийн хуралдаанаар хянан хэлэлцсэн баримтуудаас дүгнэж үзэхэд БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1990 оны 99 дүгээр зарлигаар батлагдсан «Хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэх дүрэм»-ийн 5, 6, 9, 12 дугаар зүйлийн заалтууд нь Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, 47 дугаар зүйлийн заалттай нийцэхгүй байна гэж үзэх үндэстэй байна. Тухайлбал, дээрх дүрмийн 5, 6, 12 дугаар зүйлд заасан хөдөлмөрийн шүүхтэй холбоотой заалт нь Үндсэн хуулийн 47 дугаар зүйлийн заалттай, мөн дүрмийн 9 дүгээр зүйлд аймаг болохгүй субъектуудыг зэрэгцүүлсэн, түүнчлэн үйлдвэрийн газар, байгууллагад үүссэн хамт олны маргааныг хамтын маргаан шийдвэрлэх комисс шийдвэрлэж чадахгүй бол хөдөлмөрийн хамт олон өөрийн хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хамгаалуулах асуудлыг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлд тавих бөгөөд уг асуудлыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шийдвэрлэж хамт олонд хариу өгнө гэсэн заалтууд нь Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3, 47 дугаар зүйл, Үндсэн хуулийг хэрэгжүүлэх журмын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалттай тус тус нийцэхгүй байна.

«Хамт олны хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэх дүрэм»-ийн 5, 6, 9, 12 дугаар зүйлийн заалтууд нь Үндсэн хуулийн зохих зүйлүүдийн заалттай зөрчилдөж байгаа учраас 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөр тасалбар болон хүчингүй болох ёстой байжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 3, 4, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг удирдлага болгон Үндсэн хуулийн цэцийн бүх гишүүдийн хуралдаанаас ТОГТООХ нь:

1. БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1990 оны 99 дүгээр зарлигаар батлагдсан «Хамт олны хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэх дүрэм»-ийн 5, 6, 12 дугаар зүйлийн хөдөлмөрийн шүүхтэй холбоотой заалтууд, 9 дүгээр зүйлийн «Батлан хамгаалах, улсын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журам сахиулах үүрэг бүхий ..., байгууллагад ажил хаяхыг хориглоно» гэснээс бусад хэсгийг тус тус хүчингүй болгосугай.

2. «Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн тухай» Монгол Улсын Их Хурлын 1993 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 33 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

3. Энэ тогтоол эцсийн шийдвэр тул гармагцаа хүчин төгөлдөр болно.

Дарга Г. СОВД

Гишүүд Г. НЯМДОО
А. БААСАН
Ц. ЦОЛМОН
Н. ЖАНЦАН
Ж. ЧОЙЖАНЦАН
Б. ДАНГААСҮРЭН

## УЛСЫН ИХ ХУРЛЫН ХҮН АМ ЗҮЙ, ЭРҮҮЛ МЭНД, ХӨДӨЛМӨР НИЙГЭМ ХАНГАМЖИЙН БАЙНГЫН ХОРОО ЮУ ЭРХЭЛДЭГ ВЭ?

Хүн ам зүй, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгэм хангамжийн байнгын хороо нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна. Тус байнгын хороо нь нийт 12 гишүүнтэй. Эдгээрийн 7 нь үндсэн гишүүд бөгөөд тэдний дотор академич 1, дэд доктор 2, хуульч 1, эдийн засагч 1, хүний эмч 3, инженер 1, сэтгүүлч 2 байна. Гишүүдийн дундаж нас 42 болно. Хорооны гишүүд эрүүл мэнд, хууль, эдийн засаг, шинжлэх ухааны болон олон нийтийн төв байгууллагууд, аж ахуйн нэгж, хөдөлмөрийн хамт олны дунд олон жил алба хашиж байсан, амьдралын дадлага, туршлагатай хүмүүс юм.

Байнгын хороо нь төрөөс хүн ам зүй, иргэдийн эрүүл мэнд, хөдөлмөр, нийгэм хангамжийн асуудлаар баримтлах нэгдсэн бодлогыг тодорхойлон боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх асуудлаар хууль зүйн үндсийг тогтоох, биелэлтэд нь хяналт тавих үндсэн чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Хууль санаачлагаас Улсын Их Хуралд өргөн барьсан болон тус хорооны гишүүдийн санаачилгаар хүн амын бодлого, эрүүл мэнд, спорт, биеийн тамир, хөдөлмөр, нийгэм хангамж зэрэг нийгмийн чухал асуудалтай холбоотой хууль, тогтоомжийн төслийг Байнгын хороо урьдчилан хэлэлцэж дүгнэлт гаргах, гүйцээн боловсруулж Улсын Их Хуралд оруулах үүрэг хүлээдэг.

Байнгын хороо нь төрөөс хүн амын талаар баримтлах бодлогын үндсийг боловсруулж хэрэгжилтэнд хяналт тавих, зах зээлийн эдийн засгийн нөхцөл дэх нийгэм хангамжийн шинэ тогтолцоог бүрдүүлэх, зах зээлд шилжих, шилжилтийн үед иргэдийн эрүүл мэнд, нийгмийн хамгааллалтыг бууруулахгүй байх [illegible] тогтолцоо бүрдүүлэх зорилт дэвшүүлэн ажиллаж байна. Энэ зорилтын үүднээс 1993 оны намрын чуулганаар иргэдийн нийгэм хангамжийн шинэ тогтолцоог бий болгохтой холбогдсон багц хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.

Мөн эрүүл мэндийн даатгал, тэтгэвэр, ажил эрхлэлтийн болон [illegible] даатгалын тухай хуулиудад нийгэм хангамжийн шинэ тогтолцооны үндсэн асуудлууд тусгагдах болно. Түүнчлэн Монгол Улсын төрөөс хүн амын талаар баримтлах нэгдсэн бодлогыг боловсруулж, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх ажлын хэсэг тус хорооны дэргэд ажиллаж байна.

Байнгын хорооны үндсэн үйл ажиллагааны нэг чухал чиглэл нь иргэдийн нийгмийн асуудлаар гарсан хууль тогтоомж, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих ажил байдаг. Энэ талаар Хүн амын бодлого, хөдөлмөрийн яам, Эрүүл мэндийн яамны сайд нар, бусад холбогдох ажилтнуудын мэдээлэл, илтгэл, сонсголыг хэлэлцэн дүгнэлт гаргах, санал, шаардлага тавих, тухайн салбарыг удирдах болосон хүчнийг шалгаж сонгох, томилох, чөлөөлөх асуудалд санал, дүгнэлт гаргаж Улсын Их Хурлаар оруулж хэлэлцүүлэх зэргээр хуульд заагдсан эрхээ хэрэгжүүлж байна.

Иргэд, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл гомдлыг шуурхай шийдвэрлэх, хууль тогтоомж Улсын Их Хурлын бусад шийдвэрийг сурталчлах, ажил төрлийн холбоо бүхий яам, төр, олон нийтийн байгууллагатай болон орон нутагт ажиллах, сонгогч иргэдтэй холбоотой байх зэрэг нь тус Байнгын хорооны үйл ажиллагааны чухал хэсэг юм.

Г. ЗУУНАЙ (Хүн ам зүй, эрүүл мэнд, хөдөлмөр нийгэм хам[illegible] дарга, [illegible])

# ХҮН АМ ЗҮЙ, ЭРҮҮЛ МЭНД, ХӨДӨЛМӨР, НИЙГЭМ ХАНГАМЖИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ҮНДСЭН ГИШҮҮДИЙН НАМТАР

## *ЖАНААВЫН БЯМБАЖАВ*

1953 онд Архангай аймгийн Жаргалант сумын нутагт төрсөн, халх, 1971 онд Өмнөговь аймгийн төвийн арван жилийн дунд сургууль, 1977 онд Эрхүү хотын Улсын Их Сургуулийг тус тус төгссөн. Хуульч мэргэжилтэй.

Ж. Бямбажав 1971—1972 онд Улаанбаатар хотын Найрамдлын районы прокурорын шүүхийн хяналт эрхэлсэн туслахаар, 1972—1986 онд Улсын прокурорын газарт хэлтсийн прокурор, хэлтсийн дарга, 1986—1990 онд Монголын өмгөөлөгчдийн холбооны Төв зөвлөлийн тэргүүлэгчдийн даргаар тус тус ажиллаж байв.

1990 онд Улсын Бага Хурлын гишүүн, 1992 онд Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон байна.

Ж. Бямбажав хуульчийн байгууллагын ажил, хүүхдийн талаар төрөөс баримтлах бодлого, чиглэл, ариун цэврийн улсын хяналт, түүний хууль тогтоомжийн хэрэгжилт, нийгмийн дэг журмын эрх зүйн үндэс, бодлогын асуудлыг ажил үүргийн дагуу хариуцан ажиллаж байна.

## *ШИЙЛЭГИЙН БАТБАЯР*

1943 онд Өвөрхангай аймгийн Нарийнтээл суманд төрсөн, халх. 1952 онд Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын бага сургууль, 1956 онд Уянга сумын дунд сургууль, 1957 онд Улаанбаатар хотын арван жилийн 23 дугаар сургууль, 1957—1964 онд Эдийн засгийн дээд сургуулийг тус тус төгсч, аж үйлдвэрийн эдийн засагч мэргэжил эзэмшсэн **байна**. 1966—1973 онд ШУА-ийн Эдийн засгийн хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан, эрдэмтэн нарийн бичгийн дарга, 1974—1983 онд ХЦХҮХ-ны Хөдөлмөрийн институтийн захирал, мөн хорооны орлогч дарга, нэгдүгээр орлогч дарга, 1988—1990 онд Улаанбаатар хотын АДХ-ын ГЗ-ны нэгдүгээр орлогч дарга, 1990—1992 онд МҮЭ-ийн холбооны Төв зөвлөлийн даргаар тус тус ажиллаж байжээ.

1972 онд МАХН-д гишүүнээр элсэж, 1930 онд Москва хотноо Хөдөлмөр, цалингийн асуудлаар эдийн засгийн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалсан байна. Ардын Хувьсгалын 60, 70 жилийн ойн медалиар шагнагджээ.

1992 оноос Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Ш. Батбаяр нийгэм хамгаалал, нийгмийн даатгалын асуудал, ажилгүйдэл, тахир дутуу хүмүүсийн тэтгэвэр авч явуулах бодлогын асуудлыг хариуцан ажилладаг.

Улсын Их Хурлын 1993 оны дараачийн чуулганаар Ш. Батбаярыг Орон сууцны хуульчлал, сууцны хангамжийн асуудалд хяналт тавих, хуулийн төсөл боловсруулах Улсын Их Хурлын ажлын хэсгийн ахлагчаар томилжээ.

## ГЭНДЭНСАМБУУГИЙН ЗУУНАЙ

Г. Зуунай 1945 онд Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын нутагт төрсөн, ам бүл 5. Эхнэр, 3 хүүхдийн хамт амьдардаг. 1955—1965 онд бага, дунд сургууль, 1970 онд АУДэС төгссөн. 1979—1981 онд Москва хотод Н. А. Семашкийн нэрэмжит институтийн аспирантурт суралцаж анагаах ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалжээ. Хүний их эмч, олон улсын сэтгүүлчийн мэргэжилтэй.

1974—1975 онд Парис хотод Сорбонны Их сургуульд франц хэлний сургуульд суралцаж, 1979—1980 онд Москвад Жуковскийн нэрэмжит академийн дэргэдэх Англи хэлний хоёр жилийн хурдавчилсан курс төгссөн байна.

Г. Зуунай 1970—1972 онд Улсын шүүх-эмнэлгийн магадлах төвд эксперт эмч, 1972—1979 онд анагаах ухааны хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан, 1982—1987 онд Төмөр замын эмнэлгийн албаны дарга, 1987—1990 онд Эрүүл мэндийн яамны хэлтэс, газрын даргаар ажиллаж байв. 1990 онд АИХ-ын депутатаар сонгогдож 1990—1992 онд Улсын Бага Хурлын гишүүн, 1992 онд Улсын Их Хурлын гишүүнээр тус тус сонгогдсон. Одоо Монгол Улсын Их Хурлын Хүн ам зүй, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгэм хамгааллын байнгын хорооны даргаар ажиллаж байна.

## БАЗАРЫН ДЭМБЭРЭЛ

1934 онд Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн суманд төрсөн, ялах, малчин гаралтай. Хүний их эмч. 1942—1952 онд ерөнхий боловсролын бага, дунд сургууль, 1952—1957 онд МУИС-ийн Анагаах ухааны салбарыг тус тус онц сайн дүнтэй төгссөн байна.

1957—1960 онд МУИС-ийн Анагаах ухааны факультетийн орлогч декан, дотор өвчний эмчилгээний тэнхимд багш, 1965—1973 онд БНМАУ-ын Эрүүлийг хамгаалах яамны хэлтсийн дарга, нэгдүгээр орлогч сайд, сайдаар, 1973—1978 онд Дархан хотын Эрүүлийг хамгаалах газрын даргаар, 1978—1992 онд Анагаах ухааны дээд (их) сургуулийн эрүүл ахуй, эрүүлийг хамгаалахын зохион байгуулалтын тэнхимийн эрхлэгч, 1987—1989 онд Эрүүлийг хамгаалахын удирдлагын эрдэм шинжилгээний төвийн захирал, 1989—1990 онд Анагаах ухааны хүрээлэнгийн эрдэм шинжилгээ эрхэлсэн орлогч захирал, 1990 оны 6 дугаар сараас ШУА-ийн анагаах ухааны салбарын дарга (дэд ерөнхийлөгч)-өөр ажиллаж байгаад 1992 онд Улсын Их Хурлын гишүүнээр сонгогджээ.

Б. Дэмбэрэл 1972 онд Зөвлөлт Азербайджан улсын (хуучин нэрээр) Баку хотын Анагаах ухааны дээд сургуульд «БНМАУ-ын анагаах ухааны боловсрол, боловсон хүчин 1921—1970 онд» сэдвээр анагаах ухааны дэд эрдэмтний зэрэг, 1979 онд их орондоо «БНМАУ-ын эрүүлийг хамгаалахын зохион байгуулалтын онол-практикийн зарим асуудлууд» бүтээлээр анагаах ухааны докторын зэрэг хамгаалжээ. 1988 онд доцент, 1991 онд профессор цол хүртсэн, мөн онд ШУА-ийн жинхэнэ гишүүн (академич)-ээр сонгогджээ.

1958 онд МАХН-д элссэн, МАХН-ын бага хурлын гишүүн, Ардын Их Хурлын депутатаар 3 удаа, МАХН-ын XV, XVI болон Онц их хурлын төлөөлөгчөөр сонгогдож байжээ, МАХН-ын Төв Шалган байцаах комисс, Төв Хорооны гишүүн, МҮЭ Монголын биеийн тамир спортын холбоо, МУЗН-ийн Төв Зөвлөлийн бүгд хурлын болон тэргүүлэгч гишүүн, Дэлхийн эрүүлийг хамгаалах байгууллагын гүйцэтгэх хорооны гишүүнээр сонгогдон ажиллаж байв.

Монголын хүний их эмч нарын эрдэм шинжилгээний нийгэмлэгийн дарга. Цөмийн дайныг эсэргүүцэх монголын эмч нарын хорооны тэргүүлэгч гишүүний сонгуультай.

Н. Дэмбэрэлийн зүтгэл бүтээлийг төр засгаас үнэлж Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон, алтан гадас одон, бусад медалиар шагнажээ.

Б. Дэмбэрэл Улсын Их Хурлын байнгын хороонд эрүүл мэндийн болон эм, хангамжийн алба, рашаан сувилал, өндөр настны эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын асуудал хариуцан ажиллаж байна.

## *ДОРЖИЙН МӨНХӨӨ*

1943 онд Увс аймгийн Өмнөговь суманд төрсөн. Дөрвөд. 1961 онд Увс аймгийн ерөнхий боловсролын дунд сургууль, 1966 онд Улаанбаатарт АУДээд сургууль төгссөн. Хүүхдийн их эмчийн мэргэжилтэй.

1966—1972 онд Сэлэнгэ аймагт их эмч, ерөнхий эмч, эрүүлийг хамгаалах газрын дарга, 1972—1977 онд МХЗЭ-ийн Төв Хороонд хэлтсийн эрхлэгч, 1977—1982 онд МУЗН-ийн гүйцэтгэх хороонд дарга, 1982—1985 онд Улаанбаатарын АУ дунд сургуульд орлогч захирал, 1985—1990 онд ЭХЯ-нд орлогч сайд, 1990—1992 онд МЭХ-ны төв зөвлөлийн даргаар тус тус ажиллаж байв. 1992 онд Улсын Их Хурлын гишүүнээр сонгогджээ. МАХН-д 1965 онд элссэн бөгөөд 1990 онд Ардын Их Хурлын депутатаар сонгогдож байсан байна.

Алтан гадас одон, ойн медалиудаар шагнуулжээ.

Д. Мөнхөө эмэгтэйчүүдийн нийгмийн асуудал, эх нялхсын эрүүл мэндийн бодлого, гэр бүл, өрхийн талаар төрөөс баримтлах бодлогын асуудлыг хариуцан ажиллаж байна.

## *ЦЭДЭВИЙН ТОВУУСҮРЭН*

1947 онд Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын нутагт малчны гэрт төрсөн, ам бүл 6, эхнэр, дөрвөн хүүхдийн хамт амьдардаг. 1959—1969 онд ерөнхий боловсролын дунд сургууль, 1970—1975 онд Москва хотын Хүнсний үйлдвэрийн технологийн дээд сургууль төгссөн байна. Хүнсний үйлдвэрийн инженер технологичийн мэргэжилтэй. 1975—1984 онд Дарханы хүнсний комбинатад, 1984—1987 онд Хөнгөн хүнсний үйлдвэрийн яаманд инженер, 1987—1990 онд Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрийн яаманд газрын даргаар ажиллаж байв.

1990—1992 онд Монгол Улсын Бага хурлын гишүүн, 1992 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Ц. Төвүүсүрэн хорооны ажил үүргийн хуваарьаар төрийн зүгээс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого, дэргэдэгчийн эрхийг хамгаалах, хүнсний тухай, мөн ахмадын байгууллага, ахмад хүмүүсийн талаарх асуудлыг хариуцан ажиллаж байна.

## ЦОГБАДРАХЫН ТӨРМАНДАХ

1951 онд Дорнод аймгийн Сэргэлэн сумын нутагт төрсөн. Ам бүл 4, эхнэр Л. Эрдэнэтуяа гадаад хэлний дээд сургуулийн багш, хэл зүйн ухааны дэд доктор. Хүүхдүүд нь дунд сургуульд суралцдаг.

Ц. Төрмандах 1959 онд Чойбалсан хотын тоонийн арван жилийн дунд сургууль, 1975 онд Эрхүүгийн Улсын Их Сургууль, 1991 онд Улс төрийн дээд сургуулийг тус тус төгссөн. Сэтгүүлч, улс төр судлаач мэргэжилтэй. Монгол телевизэд 1975 оноос эхлэн ажиллаж редактор, хариуцлагатай редактор, хэлтсийн дарга, ерөнхий редактор, Монгол телевизийн гүйцэтгэх зөвлөлийн дарга, программын захиргааны даргаар ажиллаж байв.

Ц. Төрмандах 1986 онд МАХН-д оройлолоо хүсэлтээр элсэж, 1990 онд намуудын тухай хуулийн дагуу намаас түдгэлзэж, 1992 оны намар гишүүнчлэлийнхээ асуудлыг сэргээжээ.

Ц. Төрмандах биеийн тамир, спорт, аялал жуулчлал, залуучуудын талаарх төрийн бодлогын асуудлыг хариуцан ажиллаж байна.

*Зохиолд эдлэлтэд*

## ИРГЭДИЙН САНАЛ ХҮСЭЛТ

Улсын Их Хурлаас олон түмэнтэйгээ байнгын холбоотой байж тэдний санаа бодлыг сорогтоор мэдэрч, тавьсан санал хүсэлтэнд бодитой хандан, анхааралтай авч үзэхийг байнга эрхэмлэдэг билээ.

1993 оны эхний хагас жилд 900 шахам иргэн, хамт олноос 1100 орчим санал хүсэлтийг Улсын Их Хуралд иргүүлсний до-

тор 300 гаруй иргэн хүлээн авах байраар ирж санал бодлоо илэрхийллээ. Түүнээс 80-аад иргэн Улсын Их Хурлын гишүүдтэй биечлэн уулзсан байна. Иргэд, хамт олноос ирүүлсэн захидал, санал хүсэлт гомдолтой Улсын Их Хурлын удирдлага, гишүүд анхааралтай танилцан, байнгын хороод, ажлын хэсэг, Тамгын газарт судлан үзэж 99,6 хувьд нь хариу өгсөн байна.

Энэ хугацаанд Улсын Их Хурлын даргад 192, дэд даргад 19 иргэн санал хүсэлт, өргөдөл ирүүлэв. Эхний хагас жилд Хууль зүйн байнгын хороо 66, Хүн ам зүй, эрүүл мэнд, хөдөлмөр нийгэм хамгааллын байнгын хороо 50, Байгаль орчныг хамгаалах байнгын хороо 27, Дотоод асуудлын байнгын хороо 32, Хурал захиргааны байнгын хороо 25, Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн бодлогын байнгын хороо, Төсөв, санхүү, мөнгө, зээлийн бодлогын байнгын хороо, Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хороо, Хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Шинжлэх ухаан, соёл боловсролын байнгын хороо 9—22 иргэний захидал хүлээн авч шийдвэрлэжээ.

Улсын Их Хуралд ирсэн нийт захидлын 58,9 хувь нь нийслэлийн иргэд, байгууллагаас, 41,1 хувь нь аймаг, хотуудаас ирсний дотор Дорнод аймгаас 20, Сэлэнгэ аймгаас 18, Хөвсгөл, Дорноговь, Хэнтий аймгаас 13—15, Дундговь, Сүхбаатар, Булган аймгаас тус бүр 2 захидал ирсэн байна.

Ирж байгаа санал хүсэлтийн дотор нийгмийн дэг журам алдагдаж архидан согтуурах, танхайрах, хулгай дээрэм хийх, хүний эрүүл мэнд, амь нас бусниулах зэрэг сөрөг үзэгдэл газар авч байгаад сэтгэл эмзэглэн, санал зовниж энэ талаарх хууль, тогтоомжийг боловсронгуй болгох, тухайлбал эрүүгийн хуулийн зарим зүйл ангийг өөрчлөх, чангатгах, цаазаар авах ялыг хэвээр байлгах, архичидтай тэмцэх хууль гаргахыг хүссэн хүсэлт санал дарангуй их хувийг эзэлж байна.

Энэчлэн Улсын Их Хуралд иргэдээс ирүүлсэн санал хүсэлтийн өөр нэг сэдэв нь эмийн үнэ өндөржсөн, эмчилгээ, үйлчилгээ дутагдсан, ялангуяа өндөр настан, архаг хууч өвчтэй, нийгмийн эмзэг хэсгийн эрүүл мэндийн баталгаа алдагдаж байгаа болон валютын ханш чөлөөлснөөс үүдэн гарч буй үнэ, тарифийн өсөлттэй холбогдуулан ахмадууд, тэтгэврийн иргэд, орлого багатай айл өрхийн амьдралын баталгааг хангах талаар төр, засгаас тодорхой арга хэмжээ авч нийгмийн хамгаалалт бий болгох талаар санал бодлоо илэрхийлсэн байна.

Нийт захидлын тоймоос үзэхэд Улсын Их Хурлын хаврын чуулганаар нийгмийн амгалан тайван байдлыг хамгаалахад бэхжүүлэх, хүний эрхийг баталгаажуулах, шүүх засаглалыг бэхжүүлэхэд чиглэсэн багц хууль, тухайлбал шүүх болон прокурорын тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Иргэдийн эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг хэлэлцэн баталж гаргасан нь манай иргэдийн хэрэгцээ шаардлага байгаа өрнөлт хүсэлтэнд бүрнээ нийцсэн шийдвэр болсоныг тэмдэглэх бүрэн үндэстэй байна.

Эхний хагас жилд иргэдээс ирсэн захидлын нэр нэг онцлог нь Улсын Их Хурлын хаврын чуулганы хуралдаанаар хэлэлцэгдэж байгаа болон цаашид шинээр гаргах хуулийн төсөл, одоогоор мөрдөж буй хуулиудын талаар санал бодлоо илэрхийлэх хандлага нэмээд өргөссөнд оршино. Тухайлбал энэ хугацаанд Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай, Батлан хамгаалах болон Хилийн тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэдийн эрүүл мэндийн даатгалын тухай, Ойн болон байгаль хамгаалах, хүнсний тухай зэрэг 20 гаруй хуулийн төсөлд 100 шахам иргэн, хамт олон тодорхой санал ирүүлжээ. Энэ нь бичгээр ирүүлсэн санал, хүсэлтийн 30 шахам хувийг эзэлж байна.

Иргэд, хамт олны захидал, мэдээллийн дотор газартаа тэшиглах асуудлыг шуурхайлах, авто замын талаар төрөөс нэгдсэн бодлого боловсруулах, мал аж ахуйн гаралтай түүхий эдийг гадагшаа чөлөөтэй гаргаж байгааг хязгаарлаж зохицуулан эх орны үйлдвэрүүдийг хангахад анхаарах, тэтгэврийн хүмүүсийн пенсийн олговорыг амьдралыг нь харгалзан ялгавартай тогтоох..., орон сууц хувьчлалын асуудалд шударга, төрийн бодлогын үүднээс хандахын чухлыг болон хөдөө аж ахуйн өмч хувьчлалын явцад гарч байгаа хүнсний бүтээгдэхүүн, ялангуяа талх, үндсэн үнэтэй тооны хүмүүс бөөнөөр нь авч дамлан зарж байгааг зогсоохыг Улсын Их Хурлаас хүссэн нь цөөнгүй байна.

Улсын Их Хурлын Тамгын газрын
захидал харилцааны хэлтсийн
зохион байгуулагч

Ж. ЖЕКҮГД